



Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн  
V бүлэг (хөрөнгө буцаан олгох)-ийн  
хэрэгжилтийн нөхцөл байдлын үнэлгээ





*Empowered lives.  
Resilient nations.*

Тус судалгааг Монгол Улсын Их Хурал, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоотой хууль тогтооход ажиллагааг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр MDS and Khanlex ХХГ гүйцэтгэв.

Судалгаанд дурдагдсан дүгнэлт, зөвлөмж нь зохиогчдын байр суурь бөгөөд Монгол Улсын Их хурал ба НҮБХХ-ийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

“Иргэдийн оролцоотой хууль тогтооход ажиллагааг дэмжих нь” төсөл  
Монгол улс, 14201 Улаанбаатар хот, Төрийн ордон. Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1. Утас: +976-51-263143 [splp.parliament.mn](http://splp.parliament.mn)

## АГУУЛГА

НЭГ: ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	2
ХОЁР. АЭК, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ	5
ГУРАВ. АЭК, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЕХАНИЗМ	8
ДӨРӨВ. ДЭЛХИЙД ХӨРӨНГӨ БУЦААН ОЛГОСОН КЕЙС, ТУРШЛАГА	11
ТАВ: ГАДААД УЛСУУДЫН ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ БУЦААН ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ	14
5.1. Америкийн Нэгдсэн Улс:	14
5.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс:	16
ЗУРГАА. StAR САНААЧЛАГААС ГАРГАСАН СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОЙМ, 29 БАРРИЕР	20
6.1. Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers) гарын авлага, түүнд тодорхойлсон улс орон бүр шийдвэрлэвэл зохих асуудлууд	20
6.2. Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers) гарын авлага, түүнд тодорхойлсон зөвлөмжүүд	30
ДОЛОО: АЭК-ИЙН V БҮЛГИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАЖ, ПРАКТИКТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ	41
7.1. Тавиннэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл	41
7.2. Тавинхоёрдугаар зүйл. Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх	43
7.3. Тавин гуравдугаар зүйл. Эд хөрөнгийг шууд буцан олгох арга хэмжээ	53
7.4. Тавин дөрөвдүгээр зүйл. Эд хөрөнгийг хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм	58
ба	58
7.5. Тавин тавдугаар зүйл. Эд хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа	58
7.6. Тавин зургаадугаар зүйл. Тусгай хамтын ажиллагаа	60
7.7. Тавин долоодугаар зүйл. Хөрөнгө буцаан өгөх ба захиран зарцуулах	62
7.8. Тавин наймдугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн нэгж	68
7.9. Тавин есдүгээр зүйл. Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо	70
НАЙМ. ДҮГНЭЛТ	78
ЕС. ЗӨВЛӨМЖ	2
9.1. Бодлогын түвшинд авах арга хэмжээний талаарх зөвлөмж	2
9.2. Үйл ажиллагааны түвшинд авах арга хэмжээний талаарх зөвлөмж	5
9.3. Дотоодын чадавхийг бэхжүүлэх талаарх зөвлөмж:	6
9.4. Монгол Улс өөрийн үнэлгээнд бэлтгэх ажлын тухай зөвлөмж	7
АРАВ. ХАВСРАЛТУУД	10
Хавсралт I. ЭХ СУРВАЛЖ	10
Хавсралт II. 2014оны 6-р сарын 27-ны өдөр Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн V бүлгийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан танилцуулах семинарт оролцогчдын нэрс	14

Хавсралт III. Авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын номын санд зориулж бэлтгэсэн зарим нийтлэл, судалгаануудын жагсаалт	15
Хавсралт IV. Конвенцийн жагсаалт	15
V бүлэг	18
Хөрөнгө буцаан олгох	21
	21

## НЭГ: ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

НҮБ-ын “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төслийн захиалгаар Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн V бүлэг (Хөрөнгө буцаан олгох)-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах зөвлөх үйлчилгээний ажлын тендерт “Баянзүрх консалтинг” хуулийн нөхөрлөл шалгарсан юм.

Зөвлөх үйлчилгээний зорилго:

Конвенцийн V бүлгийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлан үнэлгээ хийх, Хөрөнгө буцаан олгох ажиллагаатай холбоотой бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарийг үр дүнтэй, шуурхай болгох, дотоодын чадавхийг бэхжүүлэх талаар санал зөвлөмж гаргах

Үнэлгээ, судалгааны аргачлалыг тодорхойлосон нь:

“Баянзүрх Консалтинг” нөхөрлөл нь (BZC хуулийн нөхөрлөл нь) дээрх зөвлөх үйлчилгээг хараат бус шинжээчийн байр сууринаасхийжгүйцэтгэж, АТГ болон бусад оролцогч талуудын оролцоотойгоор үнэлгээ, судалгааны аргачлалыг тодорхойлсон.

Тайлан гүйцэтгэсэн баг:

Эрэндоогийн Оюунбилэг	Зөвлөх, “Баянзүрх консалтинг” хуулийн фирм
Чимэд-Очирын Баяртуул	Ерөнхий партнер, “Баянзүрх консалтинг” хуулийн фирм
Гончигжавын Мөнгөнчимэг	Ерөнхий партнер, “Баянзүрх консалтинг” хуулийн фирм
Дүгэрсүрэнгийн Сүхбүрэн	Хараат бус шинжээч

Үнэлгээний тайлангагцхүү хараат бус шинжээчдийн судалгаа, үнэлгээний ажлын үр дүн хэмээн ойлгодоно. Захиалагч (НҮБ-ын “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төсөл)-ийн болоод оролцогч тал (АТГ ба бусад)-уудын байр суурийг илэрхийлээгүй болно.

Хугацаа: 2014 оны 5-р сарын 20-ны өдрөөс  
2014 оны 6-р сарын 30-ны өдөр хүртэл

Ажлын хоног: 29 хоног

## Судалгаа, үнэлгээний эх сурвалж:

### Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц (АЭК) бусад эх сурвалж:

- АЭК
- АЭК-ийн Техник арга зүйн удирдамж,
- АЭК-ийн Хууль эрх зүйн удирдамж
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц (Полермогийн конвенц)
- Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц
- Монгол Улсын хууль тогтоомж
- УИХ-д өргөн барьсан хуулийн төслүүд
- Олон улсын түвшинд энэ чиглэлээр хийсэн судалгаа,
- Монгол Улсад хийгдсэн судалгаа

## ХАВСРАЛТ I

### Арга зүй:

#### Зорилтот бүлгийн ярилцлага:

АТГ, Тагнуулын Ерөнхий Газар, УЕПГ, Нийслэлийн прокурорын газар, Гадаад харилцааны яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн Ерөнхий Газрын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар, Тахарын Ерөнхий Газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Эд хөрөнгийн бүртгэлийн газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар), Гаалийн Ерөнхий Газартай зорилтот бүлгийн ярилцлага хийх,

#### Харьцуулсан шинжилгээ (gap analysis):

Үндэсний хууль тогтоомж ба АЭК, холбогдох олон улсын гэрээ, конвенц, стандарт, зөвлөмжийн хүрээнд хийх,

#### Холбогдох талуудад “Судалгаа, үнэлгээний урьдчилсан тайлан”-г хэлэлцүүлэх уулзалт семинар:

ХАВСРАЛТ II: Тайлагнах уулзалт семинарт оролцсон байгуулага, албан тушаалтны нэрс

Арга зүйн хувьд АЭК-ийн үнэлгээний удирдамж (UNCAC Self-assessments: Going beyond minimum) -ийн арга зүйг баримтлав.

Авлигын эсрэг конвенцийн зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэглэх шаардлагын учир

- АЭК-ийн Техник арга зүйн удирдамж
- АЭК-ийн Хууль эрх зүйн удирдамжийг

тус тус удиртгал болгон хөрөнгө буцаан олгох арга хэмжээнд хамаарах дотоодын хууль тогтоомжуудыг АЭК-ийн хэм хэмжээтэй харьцуулан шинжилсэн болно.

Судалгаа, үнэлгээний дүнд хойшидавч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг гаргалаа.

Ингэхдээ хараат бус шинжээчид бид, баримтгүй, хийсвэрлэлээс зайлсхийх зарчмыг баримталж ажилласан.

АЭК-ийн оролцогч орнууд Конвенцийг хэрэгжүүлэх чин эрмэлзэл хүсэлтэй байгаа ба Оролцогч орнуудын бага хурал, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын “Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачлага”(StAR) зэргээс АЭК-ийн хэрэгжилт, үүний дотор хөрөнгө буцаан олгох үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, өргөн хүрээт олон талт үйл ажиллагаа авч хэрэгжүүлж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Ялангуяа (StAR)-аас эмхлэн гаргасан гарын авлага, судалгааны ажлууд нь хөрөнгө буцаан олгох асуудалд үнэтэй эх сурвалж мөн.

“Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох” асуудал нь манай орны хувьд маш шинэ судлагдахуун тул судлагаа, үнэлгээний ажлын практик хэрэглээний өгөөжийг бодолцон танин мэдэхүйн асуудлыг дэлгэрэнгүй оруулж, нэр томъёо, шинэ ойлголт, улс орон, байгууллагуудын тухай аль болох сайтар тайлбарлаж, эх сурвалжийг тухай бүр дурдсан болно.

Судалгаа, үнэлгээний ажилд дэмжлэг туслалцаа үзүүлсэн Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Буджавын Бат-Отгон, мөн хэлтсийн ажилтан, комиссар Сономын Галбадрах, Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачлага (StAR)-ын ахлах зөвлөх, доктор Оливер Столпе, ажилтан Сэнгээгийн Энхчимэг, НҮБ-ын “Иргэдийн оролцоотой хууль тогтооха ажиллагааг дэмжих нь төсөл”-ийн үндэсний менежер Гантөмөрийн Золжаргал болоод Гадаад харилцааны яам, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн Ерөнхий Газрын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй

тэмцэх газрын Мөрдөн байцаах газар, Тахарын ерөнхий газар,Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар(Эд хөрөнгийн бүртгэлийн газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газар),Гаалийн ерөнхий газартгүн талархал илэрхийлж байна.

## **ХОЁР. АЭК, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ**

Авлига нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд аюул занал учруулах, улмаарардчиллын тогтолцоо, ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулах, тогтвортой хөгжил, хуульд захирагдах ёсонд хохирол учруулахуйц гэмт үзэгдэл болохыг дэлхийн улс орнууд онцолж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенц (АЭК) нь авлигатай тэмцэх олон улсын анхны баримт бичиг болно. Зарим тохиолдолд Mérida Convention буюу АЭК-ийг хэлэлцсэн анхны хуралалдаан болсон Мексик улсын хотын нэрээр нэрлэдэг.

АЭК-ийг хууль бусаар олсон мөнгийг угааж, авлигын эх үүсвэртэй нуун дарагдуулсан хөрөнгийг буцаах процессыг өөрийн үндсэн зарчимд тооцож хуульчилж өгсөн цорын ганц конвенц гэж судлаач, мэргэжилтнүүд олонтаа тэмдэглэсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн АЭК-ийг соёрхон батлах тухай 58/4 тоот тогтоол гарч, улмаар 2005 оны 12 дугаар сарын 14-ны өдөр хүчин төгөлдөр болсон байна.

Эдүгээ энэхүү конвенц 170 оролцогч улстай.

Авлигын эсрэг конвенцийн зорилго:

- Авлигаас илүү үр ашигтай бөгөөд үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж, тэмцэх арга хэмжээг хөхиүлэн дэмжиж, бэхжүүлэх;
- Авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэх, түүний дотор хөрөнгө буцааж олгох талаарх олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөхиүлэн дэмжих, хөнгөвчлөн дэмжих, дэмжих;
- Нийтийн хэрэг, нийтийн эд хөрөнгийн үнэнч шударга, хариуцан тайлагнах, зохистой удирдлагыг хөхиүлэн дэмжихэд оршино.

АЭК нь 8 бүлэгтэй бөгөөд түүний заалтуудыг:

а) заавал биелүүлэх шаардлага буюу тухайн зүйлд заасан зохицуулалтыг “шаардлагатай хууль тогтоомжид заавал оруулах”;

б) хувилбарт шаардлага буюу тухайн зүйлд заасан зохицуулалтыг “шаардлагатай гэж үзсэн хууль тогтоомжид оруулах, эсхүл бусад арга хэмжээг авах эсэхийг улс орон дотооддоо харгалзан үзэх”;



в)хувилбартарга хэмжээ буюу“дараах арга хэмжээг бусад арга хэмжээний хамт авахыг эрмэлзэнэ” гэж хуваагддаг байна.

АЭК-д авлигын тодорхойлолт байхгүй боловч түүнд нэгдэн орсон улс орнууд нь тодорхой нэр заасан үйлдлүүдийг гэмт үйлдэлд тооцож, хариуцлага ногдуулна . Үүнд:

Гэмт хэрэгт зайлшгүй тооцох ёстой 5 үйлдэл

1)15 дугаар зүйл: Үндэсний нийтийн албан тушаалтныг хахуульдах;2)16 дугаар зүйл: Гадаадын нийтийн албан тушаалтан болон олон улсын нийтийн байгууллагын албан тушаалтныг хахуульдах /active bribery/; 3)17 дугаар зүйл:Нийтийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах;4)23 дугаар зүйл:Гэмт хэргээс олсон орлогыг угаах; 5)25 дугаар зүйл: Шүүн таслах ажиллагаанд саад учруулах зэрэг

Гэмт хэрэггэж тооцож болох бүйлдэл

1)16 дугаар зүйл: Гадаадын нийтийн албан тушаалтан болон олон улсын нийтийн байгууллагын албан тушаалтныг хахуульдах /passive bribery/;

2)18 дугаар зүйл:Эрх нөлөөгөө урвуулан ашиглах;

3)19 дүгээр зүйл: Чиг үүргээ урвуулан ашиглах;

4)20 дугаар зүйл: Хууль бусаар хөрөнгөжих;

5)21 дүгээр зүйл: Хувийн хэвшил дэх хээл хахууль;

6)22 дугаар зүйл: Хувийн хэвшлийн эд хөрөнгийг завших зэрэг

АЭК-д гэмт хэрэгт тооцох авлигын бүх үйлдлийг нэн тодорхой зааж, арга хэмжээ авах үүргийг оролцогч улс орнууддаа тохоосон байна.

Авлигыг “...хуулийн үйлчлэлд хамаарахэтгээд албан тушаалын эрх мэдлээ хувийнашигхонжоолоходурвуулан ашиглах,бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг” ойлгоно гэж тодорхойлсон юм.

Монгол улс нь АЭК-д 2005 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орж, мөн оны аравдугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан бөгөөд Монгол Улсын эрх зүйн тогтолцооны салшгүй хэсэг болно .

Манай улсын авлигын индекс 2013 оны авлигын индекс судалгааны тайлангаар 0,65 гарч, 2011 оныхоос 0,02 пунктээр өссөн зэрэг дүнтэй гарсан нь АЭК-ийн шаардлагыг ханган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авсантай

---

Mandatory requirement (obligation to take legislative or other measures) - “each State party shall adopt”

Optional requirement (obligation to consider) – “each State party shall consider adopting”, “each State party shall endeavor to”

Optional measure (measure that State party may wish consider) – “each State party may adopt/consider”

UNCAC: An overview with special focus on the provisions relevant to criminal justice authorities. Demosthenes Chryssikos , pp 2-3

холбоотой юм.

Үүний зэрэгцээ авлигатай илүү үр дүнтэй тэмцэх, АЭК-ийн заалтыг илүү сайн хэрэгжүүлэх шаардлага байсаар байна.

АЭК-ийн V бүлэг нь 9 зүйлээс бүрдэнэ. АЭК-д “Хөрөнгө буцаан олгох нь энэхүү конвенцийн тулгуур зарчим болно” гэж заасан төдийгүй гэмт хэргийн гаралтай хөрөнгийг буцаан олгох асуудлыг олон улсын түвшинд анх удаа хөндсөнд энэ конвенцийн онцлог оршино.

51 дүгээр зүйл:	Ерөнхий зүйл
52 дугаар зүйл:	Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх
53 дугаар зүйл:	Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ
54 дугаар зүйл:	Эд хөрөнгө хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм
55 дугаар зүйл:	Эд хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа
56 дугаар зүйл:	Тусгай хамтын ажиллагаа
57 дугаар зүйл:	Хөрөнгө буцаан өгөх ба захиран зарцуулах
58 дугаар зүйл:	Санхүүгийн мэдээллийн нэгж
59 дүгээр зүйл:	Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

АЭК нь Хүүхдийн эрхийн конвенцийн дараах хамгийн хурдан батлагдсан конвенцом. Энэ конвенцид дэлхийн олон улс орнууд нэгдэж орсны шалтгаан нь “V бүлэг: Хөрөнгө буцаан олгох арга хэмжээ”-ний зохицуулалт гэж үздэг.

Конвенцийг байгуулах хэлэлцээрийн үед хийсэн судалгаанд 1995-2001 онуудад Гаити, Иран, Нигери, Пакистан, Филиппин, Перу, Украин зэрэг орнуудын авлигач-албан тушаалтнууд 500,0 сая-35,0 тэрбум ам.доллар хүртэлх хөрөнгийг гадаад орны банкуудад байршуулсан тухай дурджээ.

## **ГУРАВ. АЭК, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЕХАНИЗМ**

Монгол улс нь Конвенцийн II ба V бүлгийн хэрэгжилтийг 2015 онд үнэлэх учирхараат бус шинжээчид бид, энэхүү судалгаа, үнэлгээний тайланд АЭК-ийн хэрэгжилтийг хянах механизмын талаар дэлгэрэнгүй тусгахыг чармайв.

**АЭК-ийн хэрэгжилтийн үнэлгээний механизмын туршилт:** АЭК-ийн хэрэгжилтийг тогтворжуулан баталгаажуулах, хянах чиг үүрэг бүхий “Оролцогч

---

Авилгын эсрэг хууль, 3.1.1 заалт

Монгол Улсын Үндсэн Хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтад “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан учир

улсуудын бага хурал” (бага хурал) байгуулагдаж, 2006–2013 онуудад будаа хуралджээ. Эдгээр хурлуудаас АЭК-ийн хэрэгжилтийг хянах, үнэлэх, хөхиүлэн дэмжих, нэгдэн орсон орнууд хоорондын мэдээлэл солилцохыг дэмжих, конвенцийн хэрэгжилтийн талаар зөвлөмж, зөвлөгөө өгсөн байна.

Йордан улсад 2006 оны 12 сард хуралдсан анхдугаар бага хурлаар АЭК-ийн 63 дугаар зүйлийн 7 дах заалтын дагуу “тус бага хурал шаардлагатай гэж үзвэл конвенцийн хэрэгжилтийг хангах байгууллага буюу механизм бий болгох” үүргийнхээ дагуу конвенцийн хэрэгжилтийг хянах үр нөлөөтэй механизм бий болгох шаардлага хэдийн үүссэнтэй санал нэгдэж энэ тухай 1/1 тоот тогтоолыг гаргажээ.

Бага хурал нь өөрийн үнэлгээний мэдээлэл цуглуулах, тайлагнах, конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийхэд нь оролцогч улсуудад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт тавьсны дүндхэд хэдэн улс орон конвенцийн хэрэгжилтийн үнэлгээний механизмд дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн байна.

Ийнхүү АЭК-ийн үнэлгээний механизмын туршилтаар нэр бүхий 4 бүлгийн зүйл ба заалтуудыг үнэлсэн байна. Үүнд:

АЭК-ийн үнэлгээний механизмын туршилтаар үнэлэгдсэн зүйлүүд:

- 5 дугаар зүйл: Авилгаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа,
- 9 дүгээр зүйл: Нийтийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нийтийн санхүүг удирдах,
- 13 дугаар зүйл: Нийгмийн оролцоо,
- 15 дугаар зүйл: Үндэсний нийтийн албан тушаалтныг хахуульдах,
- 16 дугаар зүйл: Гадаадын нийтийн албан тушаалтан болон олон улсын нийтийн байгууллагын албан тушаалтныг хахуульдах,
- 17 дугаар зүйл: Нийтийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зохицуулах,
- 25 дугаар зүйл: Шүүн таслах ажиллагаанд саад учруулах,
- 46 дугаар зүйл: Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх
- 52 дугаар зүйл: Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх,
- 53 дугаар зүйл: Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ

Энэхүү үнэлгээнд Монгол улс сайн дураараа оролцсон бөгөөд манай улсын үнэлгээний тайлантай Швед, Пакистан улс, МБГХТГ-ын шинжээч нарын баг танилцаж эцсийн үнэлгээг хийжээ..

Конвенцийн хэрэгжилтийг үнэлэх механизм туршилт амжилттай болж, 2009 оны 11 сард Катар Улсын Доха хотод болсон бага хурлаас үнэлгээний механизмыг дараах байдлаар эцэслэн баталжээ. Үүнд:

АЭК-ийн хэрэгжилтийг тус бүр 5 жилийн хугацаатай хоёр мөчлөгөөр үнэлнэ:

- Эхний мөчлөг (2010–2015): АЭКИИ бүлэг: “Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах тухай” IV бүлэг: “Олон улсын хамтын ажиллагааны тухай” хэрэгжилтийг;
- Хоёр дахь мөчлөг (2015–2020): II бүлэг: Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай V бүлэг: Хөрөнгө буцаан олгох тухай хэрэгжилтийг үнэлэх болсон.

Улс орны хэрэгжилтийг үнэлэх процесс нь дараах 3 үе шатаас бүрдэнэ:

- Үе шат I: Өөрийн үнэлгээ (self-assessment): МБГХТГ-аас тухайн орны хэрэгжилтийн үнэлгээг хийх талаар мэдэгдсний дараа тухай орон нь үнэлгээний ажлыг зохицуулах гол байгууллагыг тодохойлж програм хангамжаар өөрийн үнэлгээг хийнэ /self assessment checklist/
- Үе шат II: бүлгийн улс орнуудын үнэлгээ (peer review): Сугалаагаар тодорхойлсон хоёр орон нь шинжээч нарын багт оруулах мэргэжилтнүүдийг томилдог. Шинжээч нарын баг нь тухайн орны хийсэн өөрийн үнэлгээг судалж, шаардлагатай бол нэмэлт мэдээлэл хүсэх, үнэлгээ хийлгэж буй орны холбогдох байгууллагуудтай утсаар холбогдож хэлэлцүүлэг хийх, тухайн орон зөвшөөрсөн тохиолдолд тэднийд айлчлах замаар үнэлгээг хийнэ
- Үе шат III: үнэлгээ хийгдсэн орны үнэлгээний бүрэн тайлан болон тайлангийн тойм: Шинжээч нарын багаас МБГХТГ-ын тусламжтайгаар үнэлгээ хийгдсэн орны тайланг бэлдэнэ (тайлан 80–300 хуудастай байна). Энэхүү тайланг тухайн орны үнэлгээг хариуцсан төв байгууллагад батлуулахаар танилцуулна. Хэрэв төв байгууллага нь уг тайланг хүлээн зөвшөөрөхгүй бол үнэлгээ хийсэн талууд харилцан ярилцаж зөвшилцөлд хүрэхэд эрмэлзэнэ. Үнэлгээ хийсэн орны тайланг зөвхөн тухайн орны зөвшөөрөлтэйгээр нийтлэнэ. Шинжээч нарын багаас 7–12 хуудас бүхий тайлангийн тоймыг гаргаж, уг тойм тайланг МБГХТГ-ын цахим хуудсанд байршуулна.

Манай улс хэрэгжилтийг үнэлэх эхний мөчлөгт хамрагдаж, 2011 онд Конвенцийн III ба IV хэрэгжилтийг үнэлүүлсэн. Мөн төрийн бус байгууллагын зэрэгцүүлсэн үнэлгээг “Транспаренси Интернэшнл” байгууллагаас хийсэн байна.

Йордан улсын Амман хотод 2006 оны 12 дугаар сарын 10/14-ны өдрүүдэд хуралдсан бага хурлаар Хөрөнгө буцаан олгох асуудлыг хариуцсан Засгийн газрын

хоорондын ажлыг хэсэг байгуулах тухай тогтоол гаргасан юм.

Ажлын хэсэг нь Австри улсын Вена хотноо 2007-2013 онуудад нийт 7 удаа хуралдаж хөрөнгө буцаан олгох үйл ажиллагаанд гарч буй бэрхшээл, тэдгээрийг шийдэх арга зам, хөрөнгө буцаан олгох салбарт гарч буй дэвшил, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зэрэг асуудлаар зөвлөлдөн ярилцжээ. Тухайлбал: 2010 оны 8-р сарын 29/30-ны өдрүүдэд хуралдсан ажлын хэсгийн 7 дугаар хуралдаанаар Конвенцийн 54, 55, 56, 58 дугаар зүйлийн хэрэгжилтэд гарч буй бэрхшээл, дэвшилтэт үйл ажиллагаа, тэргүүн туршлагын талаар ярилцсан байна.

Монгол улс энэхүү ажлын хэсгийн хуралд 2008, 2010, 2013 онуудад төлөөлөгчдөө оруулжээ.

### ДӨРӨВ. ДЭЛХИЙД ХӨРӨНГӨ БУЦААН ОЛГОСОН КЕЙС, ТУРШЛАГА

StAR хөтөлбөрийн тооцоолсноор 1995-2010 онуудад 5,0 тэрбум гаруй ам. доллар бүхий хөрөнгийг буцаан олгосон байна.

ЭЗХАХБ-аас хийсэн судалгаанаас: ЭЗХАХБ-ын гишүүн 30 орноос

Хугацаа	Битүүмжилсэн хөрөнгийн нийт дүн	Хугацаа	Хөрөнгө буцаалт хийсэн орны тоо			
2006-2009	1,255 сая ам.доллар	2006-2009	4			
			Австрали (2.9%)	Швейцари (52.9%),	UK(0.8%)	USA(43.4%)
			Нийт: 277,0 сая ам.доллар			

Судалгаа, үнэлгээний явцад манай улс нь хөрөнгө буцаан олгох харилцаанд хамаарах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэглээ дутмаг, нэгдсэн ойлголт хангалтгүй байгаа нь илэрхий байсныг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Өнгөрсөн он жилүүдэд АТГ-аас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан авлигын гэмт хэргүүд нь 256,5 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 39,8 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилснээс 17,1 тэрбум төгрөгийн хөрөнгийг буцаасан байна.

## Шигтгээ НЭГ Хөрөнгө буцаан олгосон кэйс:

Филиппин улсын Ерөнхийлөгч асан Фердинанд Маркос АНУ,Швейцарийн банкуудаар дамжуулж эх орноосоо хулгайлсан олон тэрбум долларыг угааж байсан ба Филиппины хуульхяналтын байгууллагын төлөөлөгчид 20 гаруй жилийн туршид ажилласны үр дүнд 700 орчим сая ам.долларыг эх орондоо буцаажавсан байна.

Маркос сонгодох үедээ ард иргэдийн амьдралын нөхцөл, газрын бодлогын шинэчлэлэлийг амлан Төрийн тэргүүн болжээ.Маркос 1969 онд дахин сонгогдсныхаа дараа төрийн эрх барьж байх үедээ 1972 онд улс орондоо онцгой байдал тогтоож Үндсэн хуулиа өөрчилж өөрийгээ тахин шүтүүлэх замд орсон байна. 1986 онд Филиппин улсад ерөнхийлөгчийн ээлжит бус сонгууль болж Маркосын өрсөлдөгч нь Бенино Акиногийн бэлэвсэн гэргий Корасон Акино байв. Маркосыг сонгуульд ялсан гэсэн ч Акино үүнийг эсэргүүцэж католик сүмийнхний, дараагаар нь армийн дэмжлэг авсан. Улс оронд даяар эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж төрийн эргэлт болж Маркос Хавайи-руу зугтсан байна.

Филиппин улсын Засгийн газраас тооцоолсноор АНУ-аас Маркосын хулгайлсан 600 саяаас 1.5 тэрбум ам.долларын буцаан авахаар байсан боловч 1986 – 2006 оны хооронд АНУ-аас зөвхөн 50 сая хүрэхгүй ам. долларыг буцаан авсан байна. Швейцари улсаас буцаан авах 1 тэрбум ам.долларас 1986-2006 хооронд Швейцарийн банкуудад Маркос болон түүний хамсаатнуудын нэр дээр байршуулсан хадгаламж болох 374 ам.доллар /хүүгийн хамт 658 ам.долларыг/ буцаан авсан байна.

### Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олж авахад гарсан бэрхшээлээс дурдахад:

- Маркос болон түүний тойрон хүрээлэгчдийн Филиппин улсаас нийт хулгайлж, ашиглан шамшигдуулсан хөрөнгийн хэмжээг бүрэн тогтоох мэдээлэл хомс;
- Маркосын гадаадад байршуулсан хөрөнгийн талаарх мэдээллийг цуглуулах, баримтжуулахад гарсан хүндрэл болон гадаад улсын Засгийн газрууд хөрөнгө буцаан олгох тал дээр хойрог хандсан байдал
- Маркосын мөнгөн хөрөнгө байршиж байсан дансны мэдээллийг холбогдох банкууд нэн даруй мэдээллэх боломжгүй байсан эсвэл мэдээллэх сонирхолгүй байсан;
- Эрүүгийн гэмт хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцааны гэрээ байгуулаагүй;
- Хулгайлагдсан хөрөнгөөр худалдаж авсан үл хөдлөх хөрөнгө нь зээлийн барьцаанд тавигдсан;
- Банкны дансан дахь мөнгөн хөрөнгөнд гуравдагч этгээд нэхэмжлэл гаргасан гэх мэт хүндрэл бэрхшээл гарсан байна.

Эх сурвалж: Asset Recovery and Mutual Legal Assistance in Asia and the Pacific, 2007 ADB, OECD, Basel Institute on Governance

Efforts to recover assets looted by Ferdinand Marcos of Philippines August 2007  
www.assetrecovery.org

Шигтгээ Хоёр  
Хөрөнгө буцаан олгосон кэйс:

Нигерийн Ерөнхийлөгч асан Сани Абача улс орноосоо 8 тэрбум ам.доллар хулгайлж гадаадын банкуудад байршуулсан байна. Транспаренси интернэйшнэл түүнийг орчин үеийн дэлхийн түүхэнд 4 дэх том авилгач гэж нэрлэсэн. Тэрбээр Нигерийн үндэсний баялгийн 10 хувийг дээрэмдэж түүнийг нас барсны дараа Нигерийн Засгийн газар 700 сая ам. долларыг нутагтаа буцааж авчирсан байна.

Мөн Перу улс Тагнуулын Ерөнхий газрын даргын албыг олон жилийн туршид хашсан Владимиро Монтесинос-ын хулгайлсан 174 сая ам долларыг Швейцар, Кайман арал болон АНУ зэрэг улс орноос буцаан авсан байна. 2006 -2007 онуудад Нигери улсын газрын тосоор баян Баелса мужийн захирагч Диепрейе Аламиесегагийн хулгайлсан 17.7 ам.долларыг буцаан олгоход Английн болон Өмнөд Африкийн эрх бүхий байгууллагууд Нигери улсын Засгийн газартай хамтран ажилласан байна. Эх сурвалж: Asset Recovery and Mutual Legal Assistance in Asia and the Pacific, 2007 ADB, OECD, Basel Institute on Governance

Шигтгээ ГУРАВ.  
Хөрөнгө буцаан олгосон кэйс:

Монгол Улс ба БНСУ-ын Засгийн газар хоорондын "Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ"-г үндэслэн, хоёр орны "Прокурорын байгууллага хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн дагуу 2011 онд БНСУ-ын шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангажээ.

БНСУ-ын дээд байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт ба тус байгууллагыг төлөөлөх итгэмжлэлийг Монгол улсын Ерөнхий Прокурорын Газарт илгээсэн.

Энэхүү итгэмжлэлийг үндэслэн Нийслэлийн Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Алба нь БНСУ-ын шүүхийн шийдвэрт заасан үл хөдлөх эд хөрөнгийг ба Монгол Улсад бүртгэлтэй холбогдох компанийн дансдыг битүүмжилсэн байна.

Үүний зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэж, БНСУ-ын шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд ногдох хөрөнгийн зарим хэсгийг тус улсад буцаах

---

<http://www.uncaccoalition.org/en/learn-more/resources/finish/13-2011-cosp-materials/102-civil-society-review-mongolia-2011>  
Anti-corruption-and-Asset-Recovery-commitments-(Accra), pp 24

үйл ажиллагаа 2011 онд хийгдсэн.

Ингэхдээ Монгол Улсын талаас зохих журамд заасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны урамшуулал болон бусад зардлыг хасч тооцон, үлдэх хэсгийг шилжүүлсэн байна. Энэ кейсийн “Рич Фийлд”-ийн гэж нэрлэж байна.

### **ТАВ: ГАДААД УЛСУУДЫН ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ БУЦААН ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ**

Мексик улсад 2012 онд хуралдсан Их хорийн уулзалт-хуралдаанаас гаргасан “Их 20-ийн улс орнуудаас харилцан эрх зүйн туслалцаа хүсэх зааварчилгаа” хэмээх гарын авлагыг судалж үзсэн болно.

Энэ баримт бичигт АНУ, БНХАУ-ын эрх зүйн туслалцаа үзүүлэх, хөрөнгө буцаах үйл ажиллагааг дурьдсан байна.

#### **5.1. Америкийн Нэгдсэн Улс:**

АНУ нь НҮБ-ын Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг болон Авлигын эсрэг конвенцийг хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор 70 гаруй улс орон, газар нутагтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хэлэлцээр (Mutual Legal Assistance Treaties) байгуулж хамтран ажиллаж байна.

Түүнээс гадна БНХАУ-тай Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ (Mutual Legal Assistance Agreement), Их Британи, Нидерланд, Сингапур зэрэг орнуудтай “Мансууруулах бодисоос олсон хөрөнгийг хураах”, “Харилцан хуваалцах (share) гэрээ” тус тус байгуулжээ.

Мөн Канад улс, Кайманы арлууд, Колумб, Эквадор, Ямайка, Мексик болон Монако улсуудтай “Хөрөнгө хуваалцах гэрээ” байгуулаад байгаа юм байна.

АНУ-ын Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ нь дэлхийн 47 улс орны СМА-тай санамж бичиг үйлдэх зэргээр хамтарч ажилладаг байна.

АНУ-ын төрийн департамент нь харилцан ашигтай байдлаар хамтран ажиллаж, мансууруулах бодисын худалдаа, мөнгө угаах ажиллагаанаас хураагдсан хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хувийг мансууруулах бодисын хууль бус худалдаатай тэмцэх, энэ талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашигладаг тухай мэдээлжээ.

АНУ-ын засгийн газар нь 1989-2011 онуудын хооронд хууль бусаар олсон,

---

Авилгын эсрэг үндэсний хөтөлбөр 2002-2010; 1.1 дэх хэсэг  
Маркос нь 1965 онд Филиппин улсын Ерөнхийлөгчөөр сонгогджээ. Тэрээр 1963-1965 онуудад Филиппины сенатын даргын алба хашиж байжээ.



хулгайлагдсан хөрөнгө буюу нийт 235,925,145.00 ам долларыг 38 улс оронд буцаахад хамтарч ажилласан гэх бөгөөд өөрийн цахим хуудаснаа бусад орнуудад зааварчилгаа болгож “АНУ дахь хөрөнгө буцаах механизм ба процесс” гэдэг нэртэй гарын авлагыг байрлуулжээ.

Уг гарын авлагад хөрөнгө буцаах ажлыг гардан хийх байгууллагуудын нэрс, эрх зүйн туслалцаа хүсэх, хөрөнгийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа хийх, хураах тухай мэдээллүүд орсон.

АНУ-ын Засгийн газар нь хулгайлагдсан хөрөнгийг илрүүлж, хууль ёсны эзэмшигчид нь буцаах сонирхол байгаа гэдгээ албан ёсоор илэрхийлэхийн хамт хулгайлагдсан хөрөнгөө нэхэмжлэхийг бусад улс орнуудын засгийн газруудад уриалж байна.

Гэсэн хэдий нүсэр хууль тогтоомж, төрийн байгууллагуудын тоолж барашгүй шат дамжлага, банк, санхүүгийн байгууллагуудын харилцагчийн нууц хадгалалтын хэт хатуу тогтолцоо зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан хөрөнгө буцаах ажиллагаа маш их хугацаа шаарддаг болохыг Филиппин улс нь огцорсон ерөнхийлөгч Фердинанд Маркос, түүний төрөл садан болон найз нөхөд, хамтран зүтгэгч нарын хулгайлсан хөрөнгийг буцаах кейсээс харж болно. Филлиппины Засгийн газар анх хүсэлтээ анх 1986 онд АНУ-ын засгийн газарт гаргажээ .

Санхүүгийн системийн нууцлаг байдал, татварын хөнгөлөлттэй улс орнууд, хууль бус мөнгөний эх үүсвэр, урсгал хөдөлгөөн зэрэг ухагдахуунуудын талаар ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор “Tax Integrity Network” гэх татвар төлөлтийн шударга байдлын төлөөх сүлжээ нэртэй иргэний нийгмийн байгууллага нь 2013 онд дэлхийн нийт 82 орны санхүүгийн системийн нууцлалд үнэлгээ өгөх судалгаа хийсэн байна.

Улс орнуудын банк, санхүүгийн системийн үзүүлэлтүүдийг дэлхийн мөнгөний эргэлтэд эзлэх жингээр нь тооцоолон гаргаж, харин улс орнуудыг санхүүгийн системийн нууцлалын байдлаар нь жагсаасан байна.

Үзүүлэлт	Нийт 82 орноос эрэмблэсэн нь	Хамаарах улс орнууд
1 Хамгийн өндөр нууцлалтай	Эхний 6	Швейцар, Люксембург, Гонг Конг, Кайманы арлууд, Сингапур болон АНУ зэрэг

2	Эргэлтийн хөрөнгө	Нийт 82 орноос эрэмблэгдсэн байр	Хамаарах улс орнууд
		Эхний 6	АНУ (22.586), Их Британи (18.530), Люксембург (12.049), Швейцар (4.916), Кайманы арлууд (4.694) болон ХБНГУ (4.326)

Уг судалгааг боловсруулагчид ашигласан арга зүй, хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийн талаар маш дэлгэрэнгүй мэдээлэл нийтэлснийг дээрх байгууллагын цахим хаягаар орж судлах боломжтой.

## 5.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс:

БНХАУ нь хөрөнгө буцаах олон улсын ажиллагааны хүрээнд өөрийн дотоодын холбогдох хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын конвенц, олон улсын хоёрталт гэрээг баримтлана. БНХАУ нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг дэлхийн 50 оронтой байгуулаад байгаа бөгөөд НҮБ-ын хэд хэдэн конвенц буюу НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсон байна.

Хөрөнгө буцаах асуудлаар дараах зарчмуудыг баримталдаг байна. Үүнд:

### 1. Эрх зүйн үндэслэл:

БНХАУ-ын нэгдэж орсон олон улсын конвенц болон эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу хөрөнгө буцаах хүсэлтийг хүсэлт гаргаж буй орон хүргүүлнэ. Дээр дурдсан нөхцөл бүрдээгүй тохиолдолд харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн гэрээ байгуулах эсхүл дотоодын хүчин төгөлдөр хууль, дүрэм журмуудыг мөрдлөг болгоно.

### 2. Албан ёсны ажиллагаа:

I алхам: Хүсэлт гаргаж буй тал нь БНХАУ-ын эрх бүхий төв байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргана.

II алхам: БНХАУ-ын эрх барих төв байгууллага нь холбогдох хууль хяналтын байгууллагуудын хамт уг хүсэлт нь БНХАУ-ын эрх зүйн зарчмууд, улс орны ашиг сонирхлыг зөрчиж буй эсэх, хүсэлтийг хүлээж авахгүй байх үндэслэл байгаа эсэхийг шалгасны үндсэн дээр хариу тоот илгээнэ.

III алхам: Хоёр талт гэрээ, олон улсын конвенц болон өөрийн дотоодын

хуулийн хүрээнд хүсэлтэнд өгөгдсөн мэдээллийн дагуу холбогдох байгууллагууд нь хөрөнгийг илрүүлнэ.

IV алхам: БНХАУ-ын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу илрүүлсэн хөрөнгийг царцааж битүүмжлэх ажиллагаа явагдана.

V алхам: Нэгэнт хөрөнгийг царцааж битүүмжилсний дараа хүсэлт гаргаж буй тал хөрөнгийг хураах албан ёсны хүсэлт, шүүхийн шийдвэрийн хуулбарыг хятадын талын төв байгууллагад илгээнэ. Төв байгууллага нь эцсийн шийдвэрийг гаргахаас өмнө уг баримтуудыг холбогдох байгууллагууд руу шилжүүлж хянуулна. Буцаах хөрөнгийг талууд харилцан хувааж хувиарлах зарчим баримтлах тохиолдолд дээр дурдсан олон улсын болон хоёр-талт гэрээ, хэлэлцээр, конвенци баримтлах эсхүл харилцан хэлэлцсэний дагуу гэрээ байгуулах боломжтой.

Бусад төрлийн ажиллагаа:

Тодорхой хэргийн төрөл, хамрах цар хүрээгээс шалтгаалан хүсэлт гаргагч тал нь илүү албан бус арга буюу цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх газар зэрэгт шууд хүсэлт гаргах аргаар хамтран ажиллаж болдог.

Эрүүгийн гэмт хэргийн улмаас хулгайлагдсан хөрөнгийг битүүмжлэх болон хураах (царцаах):

Хөрөнгийг тодорхойлох:

БНХАУ-д байгаа хөрөнгийг буцааж авахын тулд юуны өмнө ямар шугамаар хүсэлт гаргах болсоноо мэдээлэх шаардлагатай (албан эсхүл албан бус). Дор дурдсан механизмуудыг ашиглаж хөрөнгийг тодорхойлж болох бөгөөд эдгээр мэдээллийг олж авахын тулд цагдаагийн байгууллага эсвэл бусад холбогдох байгууллагуудын зөвшөөрөл, туслалцааг хүсэх шаардлагатай:

- Харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ;
- Үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгийн (автомашин, усан онгоц, нисдэг онгоц гм) бүртгэл хөтөлдөг засгийн газрын байгууллагын бүртгэлийг хянах боломж хүсэх
- Том аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг үзэх (захирал, хувьцаа эзэмшигч гм)
- Татварын газруудаас хувь хүний, аж ахуйн нэгжийн татвар төлөлтийн тухай мэдээлэл судлах
- Бүртгэлтэй траст болон түүний эзэмшигчдийн талаар мэдээлэл олж авах

---

ADB/OECD, Mutual Legal Assistance, in Asia and the Pacific, 2007 үзнэ үү.

Энэ хэргийн тухай мөн бусад ижил төстэй томоохон хэргүүд, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ, мэргэжилтнүүдийн боловсруулсан зөвлөмжүүдийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг ADB/OECD, Mutual Legal Assistance, in Asia and the Pacific, 2007 тайлангаас үзэж болно.

Financial Secrecy Index, 2013, <http://www.financialsecrecyindex.com/introduction/fsi-2013-results>

Хөрөнгийг буцаах:

Нэгэнт хулгайлагдсан хөрөнгийг тодорхойлсны дараа БНХАУ нь дараах тусламж үзүүлэх боломжуудыг олгодог.

Хүсэлт гаргагч талын шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэл болгох буюу тухайн хөрөнгийг эзэмшигч нь шүүхээр ял шийтгүүлсэн байх ёстой бөгөөд хүсэлт нь dual criminality -ийн зарчимд мөн нийцэх ёстой.

Хүсэлтэд дурдсан хэргийн зүйлчлэл нь dual criminality-ийн зарчимд нийцэхгүй байх тохиолдолд БНХАУ-ын хүчин төгөлдөр хуулийг сайтар судалж, тэдгээрт нийцүүлэх арга хэмжээ авахыг холбогдох зааварчилгаанд зөвлөснийг анхаарна уу.

Хөрөнгө буцаах ажилагааг хоёрталт болон олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний зүйл заалтын дагуу буцаана. Ийм гэрээ хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд тухайн хэрэг бүр дээр талууд харилцан тохиролцох боломжтой.

Хүсэлт гаргагч тал нь банкны дансны дугаар, трастын аукцион зэрэг үл хөдлөх хөрөнгийг хэрхэн шилжүүлэх талаарх мэдээллийг БНХАУ-ын эрх бүхий төв байгууллагад албан ёсоор өгнө.

Энэхүү зааварчилгааны дагуу бусад орнууд БНХАУ-д байгаа хулгайлагдсан хөрөнгийг нэхэмжлэн буцааж авах боломжтой бөгөөд БНХАУ нь өөрөө хэрхэн бусад улсуудаас өөрийн хөрөнгийг нэхэмжилж байгаа тухай мэдээлэл хомс байлаа.

Харин олон улсад нэр хүндтэй, судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг олон улсын байгууллагууд, өндөр хөгжилтэй улс орнуудын төрийн тэргүүнүүд нь өөрийн тайлан, илтгэлдээ иш татдаг иргэний нийгмийн 3 байгууллагын судалгааны материалыг ашиглан БНХАУ болон АНУ улсуудын талаар зарим тоо, үзүүлэлтүүдийг тоймлох боломжтой.

Үүнд: Global Financial Integrity иргэний нийгмийн байгууллагын боловсруулсан “2002-2011 онуудын хооронд хөгжиж буй орнуудаас гарсан хууль бусаар олсон мөнгөний урсгал” судалгаа 2013 онд нийтлэгсэн. Судалгаанд хамрагдсан хөгжиж буй улс орнуудаас хулгайлагдсан хөрөнгийн хэмжээг 2 талт гадаад худалдааны тэнцлийг ашиглан тооцоолсон байна.

Уг судалгаанд ойролцоогоор 150 хөгжиж буй орнуудыг хамруулсан бөгөөд дийлэнх орнуудын гадаад худалдааны тэнцэл он тус бүрээр бүрэн олдоогүй байна ажээ.

Энэхүү жагсаалтыг БНХАУ тэргүүлжээ. Тус улсаас 2002-2011 онуудын хооронд нийт 1.1 их наяд ам.доллар хууль бусаар гарсан бөгөөд жилд дунджаар 108 тэрбум ам.доллар алдагдаж байна гэж тооцоосон байна.

Тухайн онуудад БНХАУ-ын Засаг Захиргааны тусгай бүс Гонг Конгоор дамжин ойролцоогоор 3.61 их наяд ам.доллартай тэнцэх бараа дахин экспортлогдсон бол түүний 62% нь БНХАУ-ын гарал үүсэлтэй бараа байсан гэж тогтоожээ. Жишээлбэл:

БНХАУ-ын засаг захиргааны тусгай бүс Гонг Конгоор дамжуулан АНУ-д нийт 115 тэрбум долларын бараа импортлогдсон тухай мэдээлэл АНУ-д байхад энэ тухай мэдээлэл БНХАУ-д байхгүй буюу “АНУ-д экспортлосон гэх бараа бүртгэгдээгүй байжээ”. Энэ нь ихэд анхаарал татсан байна.

Энэ судалгааг явуулсан иргэний нийгмийн байгууллага нь нэг зүйлд анхаарлаа хандуулахыг хүсч байсан нь уг судалгаанд зөвхөн худалдааны тоо мэдээг ашигласан бөгөөд мансууруулах бодис бусад хил дамнасан гэмт хэргээс олдсон бохир мөнгө, том аж ахуйн нэгжүүдийн гүйлгээ, бэлэн мөнгөний гүйлгээ зэрэг нь уг тайланд тусгагдаагүй гэдгийг судалгааны тайлан, аргачлалын тухай хэсэгтээ тэмдэглэсэн байна.

Мөн 2013 онд Швейцарийн Базель хотын Засаглалын Институт нь Basel AML Index гэх судалгааг нийтэлжээ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, санхүүгийн тогтолцоонд мөрдөгдөж буй стандартууд, бусад олон улсын байгууллага, мэргэжилтнүүдийн хийсэн үнэлгээ, судалгаа зэрэг 14 төрлийн үзүүлэлтүүдийг ашиглан 149 орны мөнгө угаах боломжийн эрсдлийг тооцоолж гаргасан байна.

Хамгийн эрсдэлтэй орнуудад Афганистан (8.55), Иран (8.48), Камбожи (8.35), Тажикстан (8.27), Ирак (8.19) орсон бол хамгийн эрсдэл багатай орнуудаар Норвеги (3.17), Словени (3.3), Эстони (3.31), Финлянд (3.74), Швед улс (3.75) зэрэг 5 улсыг тодруулсан байна. Харин БНХАУ нь жагсаалтын 63-д бичигдэж (6.7) оноо авчээ.

Энэ оны эхээр Их Британийн мэдээллийн BBC агентлаг нь “АНУ-ын засгийн газар нь багаар бодоход 1 сая ам долларын хөрөнгөтэй 80000 гаруй БНХАУ-ын иргэнд АНУ-ын иргэншил олгожээ” гэсэн мэдээлэл цацсан.

Үүний шалтгааныг БНХАУ-ын шинэ засгийн газрын авлигын эсрэг хатуу байр суурь баримталж байгаатай холбож тайлбарласан байна .

БНХАУ-ын засгийн газар хүүхэд, эхнэр нь гадаадад амьдардаг төрийн албан хаагч нарыг “нүцгэн ажилтнууд” гэж нэрлээд тэдэнд хэд хэдэн шаардлага тавьсан байна. Тухайлбал: Гадаадын улс оронд сурч, амьдарч байгаа хүүхэд, эхнэрээ нутагтаа эргэн ирүүлэх эсхүл төрийн албанаас татгалзахыг тулган хүлээлгэсэн байна.

Зарим нэг төрийн албан хаагч хүүхдийнхээ ирээдүйд санаа тавьсандаа ажлаасаа гарч байгаа тухай хэвлэлд ярилцага өгсөн тухай мэдээллүүд байна.

Түүнчлэн, БНХАУ нь 2014 оны 6 дугаар сарын эхээр АНУ-ын засгийн газарт БНХАУ-ын нэр бүхий 1000 иргэнийг буцаах хүсэлтийг илгээжээ.

## ЗУРГАА. StAR САНААЧЛАГААС ГАРГАСАН СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОЙМ, 29 БАРРИЕР

АЭК-ийн хэрэгжилтийг нэг мөр хангахын тулд саад учруулж буй асуудлуудыг илрүүлэх, шийдвэрлэх арга замыг нь тодорхойлох оролдлогыг улс орнууд, олон улсын байгууллагууд хийсээр ирсэн.

6.1. Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers) гарын авлага, түүнд тодорхойлсон улс орон бүр шийдвэрлэвэл зохих асуудлууд

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын хамтарсан “Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers)” гарын авлага нь хулгайлагдсан хөрөнгөө буцаан авах хүсэл бүхий хөгжиж буй орнуудад тулгарч байгаа бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжүүдээс бүрддэг. Эдгээрийг хураангуйлан дүгнэж, толилуулья.

Ерөнхий асуудал:

Ерөнхий буюу бүтэц, институц, зохион байгуулалтын асуудлууд

1 Институц, байгууллага хоорондын бие биедээ үл итгэх байдлыг арилгах:

Авбал зохих арга хэмжээ:

1. Хариуцагчид өөрийгөө өмгөөлөх хангалттай боломж олгоогүй байх тохиолдлоос бусад тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээж авсан тал нь эрх зүйн туслалцаа хүссэн талын хүсэлтийг аль болох буцаахгүй байх арга хэмжээ авах;

2. Хүсэлт хүлээн авагч тал нь хамтарч ажиллах бололцоог нэмэгдүүлэх үүднээс шүүх, СМА, гааль болон цагдаагийн байгууллагуудад хүсэлт гаргагч талын холбогдох ажилтнуудтай шууд хамтран ажиллах ажилтнуудыг томилох арга хэмжээ авах;

3. Эрх бүхий төв байгууллагууд болон чадварлаг прокурор, шүүгч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих;

4. Холбогдох ажилтнуудад нүүр тулж ажиллах боломж олгох үүднээс олон улсын хурал, форумд оролцох хангалттай санхүү төсөв баталж өгөх;

5. Талууд нь CARIN, ARINSA, IBERRED зэрэг хөрөнгө хураах талаар ажилладаг сүлжээ, группүүдтэй өөрийн ажилтнуудыг холбож өгөх;

6. Агентлагын түвшинд хамтарч ажиллах боломж олгох бодлого, процедур боловсруулж уг системийн мэдээллийг байнга шинэчилж байх арга хэмжээ авах;

---

P.R. China has not created an offense of bribery of foreign public officials, nor does it impose criminal liability against legal persons for corruption.

Dev Kar, Brian LeBlanc, December 11, 2013. Illicit Financial Flows from Developing Countries: 2002-2011. Global Financial Integrity. 2013. [http://gfintegrity.org/wp-content/uploads/2014/05/Illicit\\_Financial\\_Flows\\_from\\_Developing\\_Countries\\_2002-2011-HighRes.pdf](http://gfintegrity.org/wp-content/uploads/2014/05/Illicit_Financial_Flows_from_Developing_Countries_2002-2011-HighRes.pdf)

Экспорт, импорт

## 2. Хөрөнгө буцаах талаарх бодлого дэлгэрэнгүй бус, тодорхойгүй байх:

Авбал зохих арга хэмжээ:

- 1.Хөрөнгө буцаах ил тод, дэлгэрэнгүй бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- 2.Эрх зүйн туслалцаа үзүүлэхийг татгалзах үндэслэлийн тоог аль болох бууруулах, татгалзах үндэслэлийг ойлгомжтой байхаар тодорхойлох;
- 3.Тусгайлан эсвэл одоо байгаа бүтэц дотор хөрөнгө буцаах мэргэшсэн тусгай агентлаг эсхүл нэгж байгуулах;
- 4.Шүүгч, прокурор зэрэг ажилтнуудад хөрөнгө буцаах талаар тусгай сургалт явуулах;

## 3. Хангалттай төсөв, санхүүгийн эх үүсвэр баталж өгөхгүй байх:

Авбал зохих арга хэмжээ:

- 1.Дотоодын хууль тогтоомж, олон улсын конвенцийн хүрээнд хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай явуулахыг тэргүүн зорилгоо болгон холбогдох байгууллагуудад хангалттай тооны мэргэшсэн ажилтнууд ажиллуулах боломжоор хангах;
- 2.Эрх зүйн туслалцаа үзүүлэх үүргийг биелүүлэх явцад гарсан зардлын хэмжээний төлөө засгийн газарт торгууль ногдуулах явдлыг хориглох тухай хуульчлах;
- 3.Хүсэлт гаргагч болон хүсэлт хүлээн авагч талууд зарим зардлуудыг хувааж хариуцах;
- 4.Хураасан хөрөнгийг хуваалцах талаар хэлэлцээ хийхэд бэлтгэгдсэн байх;

## 4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээ, хуулийг үл хэрэгжүүлэх:

Авбал зохих арга хэмжээ:

- 1.ФАТФ нь улс төрднөлөө бүхий этгээд(PEP) тодорхойлолтыг АЭК-ийн шаардлагад нийцүүлэх;
2. Үндэсний стандарт боловсруулагчид болон бусад оролцогч талууд уг тодорхойлолтыг хүлээн зөвшөөрч нэвтрүүлэхийг үүрэг болгох;
- 3.Банк, санхүүгийн байгууллагуудад өөрийн PEP харилцагчийн мэдээллийг жил бүр хянаж, үүнийгээ баталгаажуулж байхыг үүрэг болгох;
- 4.PEP нь төрийн албачөлөөлөгдсөнөөс хойш болон хэрэв эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэх, яллагдах, шүүгдэх үед ч нөлөөтэй байх боломжтой тул банкууд PEP-ийн дансны мэдээллийг 8-10 жил хадгалах арга хэмжээ авах;
- 5.Гадаад улсын PEP-д хамаарах сэжиг бүхий гүйлгээний тухай мэдээлэлийг цаг

алдалгүй тухайн оронд мэдээлэх, зохих арга хэмжээ авах;

6. PEP тухай мэдээлэх, тайлагнах, эрсдлийн менежмент хийх тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэхийг холбогдох зохицуулах, хянахчиг үүрэг бүхий байгууллагуудаас шаардах;

#### 5. Гал тогоонд хэт их тогооч байх буюу зохицуулах механизм үгүйлэгдэх:

Авбал зохих арга хэмжээ:

1. Томоохон хөрөнгө буцаах хэрэгт хэд хэдэн улс орон оролцох тохиолдолд хамтарсан ажлын хэсэг байгуулах, эсхүл тэдгээр улсуудын хамтарсан уулзалтуудад оролцох боломжоор хангаж олон улсын хамтын ажиллагааг дэмжих;

2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг эрх бүхий төв байгуулагаас гаргаж, ажиллагаа нэгэнт эхлэх үед хууль хяналтын байгууллагуудын ажилтнууд шууд холбогдон ажиллах боломжоор хангах үйл ажиллагааг баталж хэрэгжүүлэх;

3. Шаардлагатай тохиолдолд хүсэлтийн хуулбарыг эрх бүхий төв байгууллагад өгч байх, ингэхдээ тухайн процесст хамааралгүй агентлагуудын оролцоог хязгаарлах арга хэмжээ авах;

6. Эрх зүйн туслалцаа үзүүлэх албан ёсны хүсэлтэд хайнга хандах, хүсэлт хүлээн авагч талын шаардлага, олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг авахгүй байх, бүрэн бус буюу биелэгдэх боломжгүй хүсэлт гаргах:

Авбал зохих арга хэмжээ:

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргахын өмнө талууд (улс орнуудын)-ын адил төрлийн байгууллагууд өөр хоорондоо харилцах сувгуудыг нээж өгөх (зааж өгөх)

2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг боловсруулж байх үед болон хүсэлтийг хүргүүлсэнээс хойш буюу хүсэлтийг хэрэгжүүлэх бүх үе шатанд дээрх сувгийг ашиглах боломжоор хангах;

3. Хүсэлт гаргач тал нь хүсэлтээ албан ёсоор гаргахаасаа өмнө хэргийн талаар мэдээлэл цуглуулж болох албан бус бүх сувгуудыг ашигласан байх хэрэгтэй;

Хоёр:

Хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх процессыг сааруулах бэрхшээл, шаардлагууд

#### 7. Хууль, эрх зүйн орчин, уламжлалын ялгаатай байдал:



Авбал зохих арга хэмжээ:

1.Талууд өөрийн орны хөрөнгө буцаахтай холбогдох хууль эрх зүйн актууд, нотлох баримтад тавигдах шаардлага, зөвшөөрөгдсөн мөрдөн шалгах арга, тактик буюу нээлттэй байлгах боломжит бүх мэдээллийг цахим хуудаснаа тавихсургалт семинар зохион байгуулах арга хэмжээ авна;

2.Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт болосвруулахдаа маш тодорхой, нийтлэг буюу АЭК-ийнI бүлэг болон Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэр томъёог ашиглах;

3.Харилцагч талднэр томъёо, үг хэллэгийг нэр мөр ойлгох эсэх асуудлаар болон бусад үл ойлголцол үүсгэж болзошгүй нөхцлүүдийн талаар урьдчилан мэдэгдэх; зэрэг зөвлөмжүүдийг энэ хэсэгт дурьдсан байна.

#### 8. Эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт гаргаж өгөх чадавхи дутагдах:

Авбал зохих арга хэмжээ:

1.Олон улсын конвенцийн зүйл заалтуудыг өөрийн хуулиудад тусгахдаа АЭК-ийн IV,V бүлэг, Хил дамнасан зохион байгуулалттай тэмцэх конвенцийн 18 дугаар зүйлийн шаардлагуудыг бүрэн хангах ёстой;

2.Зарим тохиолдолд хоёр талт эрх зүйн туслалцаа үзүүлэх хэлэлцээр эсхүл санамж бичиг үйлдэх;

Юуны өмнө хөрөнгө буцаах ажиллагааны хувьд стратегийн ач холбогдол бүхий улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцааны хоёр талт гэрээ хэлэлцээр хийх.

#### 9. АЭК, Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенциудыг хэрэгжүүлэхгүй байх:

Авбал зохих арга хэмжээ:

1.АЭК, Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенциудад тусгагдсан бүх гэмт хэргүүдээс олсон хөрөнгийг битүүмжлэх, хураах шийтгэл ногдуулах арга хэмжээ авахыг хуульчлах;

2. Мөн бүх төрлийн хөрөнгийг битүүмжлэх, хураах боломжоор хангах;

#### 10. Хөрөнгийг хурдан шуурхай битүүмжлэх (царцаах, түр хурааах), үрэгдэхээс сэргийлэх механизмгүй байх;

Авбал зохих арга хэмжээ:

1.Шүүн таслахажиллагаа явагдсан эсэхээс үл хамааран тухайн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа эхлэх үетэй зэрэгцэн эрх зүйн туслалцаа үзүүлэхийг хүсэх ажиллагааг эхлүүлэх боломжоор хангах;

2.Эрхзүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийг албан ёсоор өгөхөөс өмнө хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, битүүмжлэх механизм нэвтрүүлэх, Хүсэлт гаргагч тал хүсэлтийг албан ёсоор өгсөнөөс хойш хөрөнгийг битүүмжлэх ажиллагаа албажих ёстой.

11. Хүсэлт, даалгаварт тавигдсан шаардлагууд нь бүрхэг, эсхүл хэт олон бөгөөд мөрдөн шалгах шаардлагатай бүх ажиллагааг хүсэлт хүлээн авагчид тохоосон мэт байдлаас хөрөнгө үрэгдэх (хууль бусаар ашиглах) боломж нээгдэх:

Авбал зохих арга хэмжээ:

1.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гадаадаас ирсэн хүсэлтийн дагуу мэдээлэл өгөх тохиолдолд банк санхүүгийн байгууллагад өөрийнхөө харилцагчид заавал мэдэгдэх үүрэг хүлээлгэхээс зайлсхийх хэрэгтэй. Үүнийг хориглох;

2. Банк, санхүүгийн байгууллага нь харилцагчдад мэдээлэл өгснөөс үүсэх эрсдлийг хариуцах, учирсан хохирлыг барагдуулах, арилгах үүргийг ногдуулах;

3.Эрхзүйн туслалцаа хүсэх хүсэлтийг албан ёсоор гаргах, хүлээн авч хэрэгжүүлэх үед энэ тухай харилцагчид мэдэгдэхийг хуулиар зохицуулсан бол, харилцагчид гагцхүү хөрөнгийг нь битүүмжлэхийд вэр хүлээн авсан тухай, хөрөнгө нь битүүмжлэгдэж буй тухай мэдэгдэх;

12. Банкны мэдээллийн нууцыг хуульчлах:

Авбал зохих арга хэмжээ:

1.Банкны мэдээллийн нууцыг АЭК болон Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн хэрэг дээр хамтран ажиллахаас татгалзах үндэслэл болгож болохгүй;

2.“Хамгаалагдсан мэдээлэл”-ийг маш тодорхой томъёолж мөн хязгаарлаж өгсөн хууль боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.

3.Хүсэлт гаргагч талын прокурор, мөрдөн байцаагч нарт дансны мэдээллийг шалгах үндэслэл байх тохиолдолд хүсэлтийг хангах боломжийг хуульчилсан байх хэрэгтэй.

13. Нотлох баримт, процессын “яршиг төвөг” ихтэй хуулиуд:

Авбал зохих арга хэмжээ:

1.Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтэд “ойлгомжтой, илэрхий, хангалттай,

нотлогдсон, нотлох баримтын шаардлага хангасан мэдээлэл байхгүй” хэмээн хүсэлтийг буцаах, холбогдох ажиллагаа эхлэхээс татгалзах ёсгүй;

2.Хулгайлагдсан, хууль бус эх үүсвэртэй байж болох үндэслэл гэж үзэн аливаа хүсэлтийг хүлээн авч байх;

Хүсэлтэнд зөвхөн аль болох тодорхой болон ач холбогдол бүхий зүйлийг тодорхойлж түүний тухай мэдээллийг жагсаах хэрэгтэй.

14. Хулгайлагдсан хөрөнгийн үнэтэй тэнцэх хэмжээний бусад хөрөнгө, эд зүйл хурааж,хулгайлагдсан хөрөнгө үрэгдэхээс сэргийлэх зохицуулалт байхгүй байх:

Авбал зохих арга хэмжээ:

1.Хүсэлтэд дурьдсан хөрөнгийн үнэтэй тэнцэх хэмжээний хөрөнгө битүүмжлэх эсхүл хураах боломжоор хангах ёстой;

15. Гэмт буруутай эсэх нь шүүхээр тогтоогдох хүртэл хөрөнгө хураахыг хязгаарласан, хориглосон хэм хэмжээг хуульчлах:

Авбал зохих арга хэмжээ:

1.Гэм буруутай эсэх нь шүүхээр тогтоогдох хүртэл хөрөнгөүл буцаах явдлыг хуульчлахгүй байх,

Шүүн таслах ажиллагаанаас өмнө хулгайлагдсан хөрөнгийг буцаах, үрэгдэхээс сэргийлэх арга хэмжээ авах, битүүмжлэгдсэн хөрөнгийн менежментийг тодорхой хуульчлах,

2.Эсхүл хариуцагч нас барсан, оргон зайлсан, сураггүй болсон, дипломат эрх ямба эсхүл халдашгүй байдал нь хуулиар хамгаалагдсан зэрэг тохиолдолд гэм бутуутай эсэхийг шүүх тогтоохоос өмнө хөрөнгө буцаах боломжийг хуульчлах;

3.Гадаад улсын хөрөнгө буцаах тухай хуулийн байгууллагын баримт бичгийг хүчин төгөлдөрт тооцох;

16. Буцаагдах хөрөнгийн талаар хэлэлцэх, мэтгэлзэхболомж, чадавхи үгүйлэгдэх :

Авбал зохих арга хэмжээ:

1.Хөрөнгө буцаах нэхэмжлэлээр үүсгэгдсэн иргэний хэрэгт хариуцагчийг оролцох боломжоор хангах;

17. Төрийн албан хаагчийн халдашгүй байдал, баталгаа зэрэг хэм хэмжээг шаардлагатай тохиолдолдхуулийн дагуу хэрэгсэхгүйбайх зохицуулалттай байх-гэм

буруутай этгээдийг ял үл завшуулах;  
Авбал зохих арга хэмжээ:

1. Хөөн хэлэлцэх хугацааг тооцох: Төрийн албан хаагч албанаас чөлөөлөгдөх эсхүл халдашгүй байх эрхийг нь түдгэлзэх хүртэлх хугацааг хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаанд үл хамруулах;

2. Төрийн албан хаагчийн хуулиар баталгаажуулсан халдашгүй байдал, эрх ямба, баталгаа зэргийг хэрэгсэхгүй байх зохицуулалтыг холбогдох хуулиар зохицуулах,

18. Хөөн хэлэлцэх хугацааг шударгаар тогтоох;

Авбал зохих арга хэмжээ:

1. Аливаа этгээдийн халдашгүй байдлыг түдгэлзүүлсэн өдрөөс хойш хөөн хэлэлцэх хугацааг тооцож эхлэх зохицуулалттай байх;

2. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийг илрүүлэх үеэс эхлэн тооцож эхлэх зохицуулалттай байх;

19. Гадаад улсаас ирүүлсэн “хөрөнгө хураах, хөрөнгийг үрэгдэхээс сэргийлэх, хөрөнгийг ашиглах эрхийг хязгаарлах” тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх чадавхи үгүй байх боломжуудыг таслан зогсоох;

Авбал зохих арга хэмжээ:

1. Гадаад улсаас ирүүлсэн хөрөнгө хураах, хөрөнгийг үрэгдэхээс сэргийлэх, хөрөнгийг ашиглах эрхийг хязгаарлах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийг, тэрхүү шийдвэрт заасаг хөрөнгийн хэмжээг тэр хэвээр нь хүлээн зөвшөөрч байх механизмыг ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө битүүмжлэх, хураах боломжоор хангах;

20. Хөрөнгийг буцааж өгөх чадавхи үл дутаж байх;

Авбал зохих арга хэмжээ:

1. АЭК-ийн 57 дугаар зүйлийн дагуу хулгайлагдсан бүх хөрөнгийг буцаах ажиллагааг хуульчлах;

2. Ингэхдээ хөрөнгө буцаах ажиллагаанд хамаарах бүхий л зардлыг хасах;

3. Хөрөнгө буцаах ажиллагаа, улс орнуудын харилцаанд тулгарч буй асуудлууд;

21. Хөрөнгө буцаах асуудлыг тодорхой байгууллагад нэр заан хариуцуулаагүй, эсхүл хариуцсан байгууллагын чиг үүрэг нь тодорхой бус байх;

Авбал зохих арга хэмжээ:

1. Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх хүсэлтийг боловсруулах чадавхитайэрх бүхий байгууллагад хөрөнгө буцаах үйл ажиллагааг хариуцуулах, тэрхүү байгууллагыг хөрөнгө буцаах авч ирэх хариуцагч байгууллагаар тодорхойлж, энэ тухай хуульчлах;

2. Хөрөнгө буцаах асуудал эрхэлсэн улс орнуудын сүлжээг бэхжүүлэх, бүс нутгийн ижил төстэй сүлжээнд өөрийн улсын төлөөлөлтэй байх арга хэмжээ авах;

22. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд нүсэр шаардлага үл тавих, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг татгалзах өргөн хязгаарлалтыг үл хуульчлах;

Авбал зохих арга хэмжээ:

1. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт гаргагч улс орнуудын тоог үл хязгаарлах;

2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс эдийн засгийн сонирхол бүхий үндэслэлээр татгалзахыг хориглох;

23. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нөхцөл, шаардлагуудын тухай мэдээллийн хомсдолгүй байх;

Авбал зохих арга хэмжээ:

1. Улс орнуудын Засгийн газрын албан ёсны цахим хуудаст эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт хүлээн авах эрх бүхий төв байгууллага, түүний нэр, хаяг, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нөхцөл, журам, энэ төрлийн хоёр талт олон улсын гэрээ байгуулсан улсуудын жагсаалт, бусад оролцогч талуудын мэдээлэл, зааварчилгаа зэрэг шаардлагатай бүх мэдээллүүдийг ядаж наад захын хэмжээнд ил тод байлгах;

24. Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадал, эрмэлзэл үл дутагдах;

Авбал зохих арга хэмжээ:

1. Хүсэлт гаргагч тал ньдээд хэмжээнд орчуулга хийх чадвар бүхий байгууллага (албан ёсны зөвшөөрөл бүхий орчуулагч)-аар хүсэлтийг хүлээн авагч улсын албан ёсны хэлэнд хөрвүүлэх;

2. Орчуулгыг дан ганц хуулийн хэллэгээр бус гол нь нэн ойлгомжтойгоор хийх;

25. Эрх зүйн харилцан туслалцаа хүсэх харилцаанд хамаарах талууд тодорхой бус байх, хүсэлтэд хариу үл илгээхээс татгалзах;  
Авбал зохих арга хэмжээ:

1. Хүсэлт гаргагч тал нь илгээж буй хүсэлтэд хариуцсан ажилтны харъяалах байгууллага, ажилтантай холбоо барих бүх хаяг, утасны дугаар, ярих хэл (төрөлх болон гадаад хэл) зэрэг мэдээллийг бичих шаардлагатай;

2. Хүсэлт хүлээн авагч тал нь хүсэлтийг хүлээн авахаас татгалзах тухай үндэслэлийг тодорхой бичиж хариуг аль болох шуурхай илгээх ёстой.

26. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааг үндэслэлгүйгээр үл хойшлуулах;

Авбал зохих арга хэмжээ:

1. Хөрөнгийн бүртгэлд албан ёсны өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдэд мэдэгдэл хүргүүлэхгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухайхуулиар хүлээн зөвшөөрөгдсөн байх;

2. Хөрөнгө буцаах үйл ажиллагааг зогсоох, хүчингүй болгох зэрэг зорилгоор улс орнуудаас ирүүлсэн үндэслэлгүй хүсэлт илгээгч талд торгууль зэрэг ногдуулах хариуцлагын тогтолцоо, зохицуулалттай байх;

27. Буцаагдах хөрөнгийн тухай нэн дэлгэрэнгүй буюу эд хөрөнгийн улсын бүртгэлийн мэдээллийн өгөгдөл, түүнтэй адилтгах мэдээлэл ирүүлэхийг үл шаардах,

Авбал зохих арга хэмжээ:

1. Битүүмжлэх, хураах хөрөнгийн тухай хэт дэлгэрэнгүй мэдээлэл үл шаардах,

2. Битүүмжлэх, хураах, буцаах хөрөнгийн тухай шаардаж буй мэдээлэл нь эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг хэрэгжүүлэхэд саад тотгор үл учруулах нөхцөлтэй байх;

Хүсэлт илгээгч тал хөрөнгийн мэдээллийг аль болох дээд хэмжээнд бүрэн өгөхийг чармайж, холбогдох арга хэмжээг авсан байвал зохино.

28. Гадаад улсын банкин дахь дансны дугаарыг тодорхойлох боломж хомс биш байх,

Авбал зохих арга хэмжээ:

1. Банк, санхүүгийн байгууллага дахь дансны дугаар, данс эзэмшигч,

---

non-conviction

Зохицуулалтгүй байж болохгүй. Гэм буруутай этгээдийн өмнө хуулиар зохицуулагдаагүй байна хэмээн хүчин үл мөхөсдөх,

мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалт, баталгаат гарын үсгийн хэв загвар зэрэг мэдээлэл бүхий үндэсний мэдээллийн сан байгуулах шаардлагатай.

29. Битүүмжилсэн хөрөнгийг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд үл зарцуулах, хураагдсан хөрөнгөнд оновчтой менежментийг хийх, хураасан хөрөнгөөс хураамж, төлбөр авч үл хорогдуулах,

Авбал зохих арга хэмжээ:

1. Эрх бүхий төв байгууллагууд, түүнчлэн хууль сахиулах байгууллагууд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зардалд хамаарах хураамжийн хэмжээг үл хэтрүүлэх арга хэмжээг авч байх;

2. АЭК-ийн дагуу битүүмжлэгдсэн, хураагдсан хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах;

3. Хураагдсан хөрөнгийг үнэгүйжих, үнэлгээ буурах эрсдэлийг удирдах;

Эдгээр бэрхшээл нэг бүрийг даван туулах тухай “Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers) гарын авлага”-ын тодорхойлох хэсэгт тайлбарласныг 6.2 хэсгээс үзнэ үү.

6.2. Хөрөнгө буцаахад тулгарч буй бэрхшээлүүд (29 barriers) гарын авлага, түүнд тодорхойлсон зөвлөмжүүд

Бэрхшээл, хүндрэлүүдийг эрэмбэлэн жагсаавал:

Нэг: Оролцогч талууд харилцан үл итгэх байдал: Дан ганц дотоодын байгууллагууд, тэдгээрийн ажилтнууд төдийгүй гадаад улсын хамтран ажиллах байгууллага, ажилтнууд өөр хоорондоо үл итгэх, төв байгууллага ба орон нутгийн салбар байгууллагууд харилцан үл итгэх зэрэг бэрхшээл гардаг.

Учир нь мөнгө угаах гэмт хэргийг байцаан шийтгэх үедашиглагдах мэдээллийн нууцыг чандлан хадгалаагүйгээс шударгаар шийдвэрлэгдэх боломж хомсдож болзошгүйг дурджээ.

Институциуд хоорондын үл итгэлцэл авлига, мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх харилцааг гажуудуулж, авлига цэцэглэхэд хүргэдэг байна.

Хоёр: Институциудын үйл ажиллагааны давхардал ба хүнд суртал: Аль байгууллага чухам ямар асуудлыг хариуцах нь ойлгомжгүй, тодорхой биш, эсхүл нэг асуудлыг хэд хэдэн байгууллагад хариуцуулах, хяналтын оновчгүй тогтолцоо нь гэмт этгээдэд зугтах, буцаагдвал зохих хөрөнгийг үрэгдүүлэх, улмаар нөлөө бүхий улс төрчдөөр мөрдөн шалгах ажиллагааг удаашруулах, зогсоох зэрэг аюул учруулдаг

байна.

Гурав:Хууль хэрэгжүүлэх байгууллагуудын чиг үүргийн давхардал ба хийдэл, хяналтын болхи тогтолцоо:

1.Тодорхой нэг төрлийн чиг үүргийг хэд хэдэн агентлагуудадөөр өөр үг хэллэг, нэр томъёогоор давхардуулан хуваарилах;

2.Цогц байдлаар нэг агентлагт хуваарилагдвалзохих чиг үүргийг хэд хэдэн хэсэг болгон хэд хэдэн газарт хуваарилах;

3.Тухайн чиг үүргийн хэрэгжилтийг хянах, тайлагнах субъект тодорхойгүй(төр, эрх бүхий төрийн байгууллага гэх мэтээр заах), эсхүл эрх зүйн байдал ба эрхлэх үйл ажиллагаа нь харилцан адилгүй байгууллагуудад хуваарилах, тайлагнаж байх нэгж хугацаа тодорхойгүй байх зэрэг нь зохицуулалтын хийдэл, зөрчил буюу тухайн байгууллагын явцуу, бичил эрх ашгийг улс орны том эрх ашгаас илүүд үзэн үл ойлголцол үүсгэдэг учир шалтгаантай тул зохицуулах чиг үүргийг зөв тодорхойлж, нэн тодорхой оновчтойгоор төрийн тодорхой байгууллагад нэр заан хариуцуулах шаардлага гардаг байна.

Тодорхой нэг байгууллагаар толгойлуулах нь тайлагнах үйл ажиллагааг хүндрүүлэх тул зохих хэмжээнд мэргэшсэн хангалттай орон тоотой, хөрөнгийн эх үүсвэр бүхий аль нэг байгууллагаар зохицуулах үүргийг гүйцэтгүүлж болох талаар дурьдагддаг.

Үүнийг мөрдөгдөж буй хэргийн тухай мэдээллийг цаг тухайд нь түргэн солилцох, ажлын явцыг шуурхай мэдээлэх зөв зохион байгуулагдсан бие даасан нэгж бий болгох гэж ойлгох нь зүйтэй.

Дөрөв: Хүний нөөц, техникийн чадавхи, тоног төхөөрөмжийн хомсдол:

Мөрдөн байцаах болон тагнуулын байгууллага, прокурор, шүүх нь авлига, мөнгө угаах төдийгүй эдийн засгийн гэмт хэргүүдийг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажиллагаа явуулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих, шүүн таслах ажиллагааг тус тус эрхлэн гүйцэтгэдэг хуульчид(хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч)-ыг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах, нарийн мэргэжлийн хуульчид(авлига, мөнгө угаах гэмт хэргээр мэргэшсэн гэх мэт)-ыг тусгайлан бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх, шинэ тутам үйлдэгдэж буй гэмт хэрэг, тэдгээрийг үйлдсэн арга техник, хамрах хүрээг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, криминологийн судалгаа хийж байх, холбогдох судалгаа-мэдээллийг тухай бүр хуульчдад хүргэх шаардлагыг ханган ажиллах хэрэгтэй. Үүнийг мөнхуульчдыг бэлтгэх сургуулиуд анхаарч ажиллах нь зүйтэй.

Танзани болон Албан Улсуудын талаар энд анхааруулга болгон жишээ татъя.

---

Буцаагдах үндэслэл бүхий хөрөнгийг үл буцаах, өөрийн улсад байлгах хүсэл сонирхол "Баянзүрх консалтинг" хуулийн фирм:эсхүл НҮБ-ын албан ёсны хэлэнд, хэлийг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх олон талт гэрээнд зааж болно. Энэ нь ЭБШХ-ийг үл зөрчинө.



Дд	Улс	Хүн ам	Мөрдөн байцаагчийн нийт тоо	Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөн байцаагчийн тоо
1	ТАНЗАНИЙН НЭГДСЭН БҮГД НАЙРАМДАХ УЛС	44,9 сая	6000	10

Танзанийн Нэгдсэн Бүгд Найрамдах Улсын хувьдмөнгө угаах, авлигатай тэмцэх нь шинэ тутам асуудал юм байна. StAR санаачлагынхантай санал солилцсон Танзанийн ажилтан нар нотлох баримт, мэдээлэл цуглуулах сүүлийн үеийн шинэлэг арга зүй, техник эзэмшсэн ажилтан дутагддаг, үүнтэй холбоотойгоор прокурор нь мөнгө угаах, авлигын хэргийн 50% хувийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр тодорхой чиглэл өгөх, хэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буцаагддаг, түүнчлэн шүүгч, прокуроруудын авлига, мөнгө угаах гэмт хэргийн тухай мэдлэг нимгэн, эсхүл эдгээрт холбогдох суурь ойлголт (санхүүгийн ойлголтууд: НББ, татвар гэх мэт)-ын мэдлэг дутмагаас мөнгө угаах, энэ төрлийн гэмт хэргийг хэрэгсэхгүй болгох, ял өөрчлөн сонсгох, хөрөнгө хураах ялыг ногдуулдаггүй, хураагдвал зохих хөрөнгийг бүрэн дүүрэн тодорхойлж чаддаггүй байна.

Бүгд Найрамдах Албани Улс ч эдгээр бэрхшээлтэй тулгарсаар байна. Албани Улсын хуулийн дагуу зорчигч этгээд нь хилээр нэвтрүүлж буй бэлэн мөнгөний хэмжээг сайн дураараа мэдүүлэх, цагдаагийн газар нь хилийн шалган нэвтрүүлэх цэгийг хамгаалах үүрэгтэй ажээ. Хилийн шалган нэвтрүүлэх цэгийн хяналт хэрэгжүүлэгч албан хаагчдын тоо дутмагаас хилээр нэвтэрч буй бүх тээврийн хэрэгсэл, түүгээр зорчигчдыг шалгаж амждаггүй байна.

Дээрх нөхцөл байдал нь хууль бус гарал үүсэлтэй бэлэн мөнгийг хилээр нэвтрүүлж буй эсэхийг хяналтаас гаргажээ.

**Тав: Мөнгө угаахын эсрэг хууль тогтоомж, түүнийг хэрэглэх тухай мэдлэг хөгжиж буй орнуудад хомс байх:** Авлига, мөнгө угаахын эсрэг үйл ажиллагаань иж бүрэн мэдээллийн сан үүсгэх, түүнийг шаардлагатай ажилтан зөвхөн албан ажлын хэрэгцээнд чөлөөтэй ашиглах, нэвтрэх боломжтой байхаар програмчлах, биет баримт (хэвлэмэл, гар бичвэр, фото зэрэг)-ын эмх цэгцтэй, зөв зохион байгуулагдсан архивтай байх, эдгээр мэдээллийн санг ашиглах мэдлэг болон туршлага, ур чадвартай байхыг шаарддаг нарийн төвөгтэй ажиллагаа болно. Үүний зэрэгцээтөр ба хувийн

Үйл ажиллагааны бусад үед хөрөнгө өмчлөгчийн эрхийг хангасан байх тохиолдолд

хэвшил нь хамтдаа болон дангаараа хуульд заасан үүрэг (хэн ямар үүрэг хүлээсэн тухай, үүргээ эс биелүүлбэл ногдуулах хариуцлага нь тодорхой хуульд заах)-ийг биелүүлж оролцохөстой нарийн, нийлмэл үйл явц билээ.

Авлига, мөнгө угаахыг хориглох тухай эрх зүйн орчин, институцыг бий болгох нь зөвхөн анхны алхам, наад захын авбал зохих арга хэмжээ болно.

Улс орон бүр авлига, мөнгө угаахын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны цар хүрээгээ зөв тодорхойлж, оновчтой зохион байгуулагдсан тогтолцоо, эрх зүй, эдийн засгийн иж бүрэн судалгаанд түшиглэсэн ажиллах горим, дэгийг тогтоож, оролцогч бүх талуудын үүргийг нэн тодорхой тодорхойлж өгөх, чадавхийг сайжруулах шаардлагатай.

Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя. Бүгд Найрамдах Албани Улсын хууль хяналтын байгууллагууд нь “СМА ньхолбогдох мэдээллийг илрүүлж, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулсныхаа дараа эхний үр дүнг хууль хяналтын байгууллагад мэдээлж, бусад хуулийн эрх бүхий байгууллагад мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх боломж олгох ёстой гэж үздэг “практик” ойлголт байдаг байна.

Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар СМА-д мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээ байгүй бөгөөд зөвхөн мэдээллийг цагдаа болон бусад холбогдох байгууллагуудад шилжүүлэх үүрэгтэй байна.

Албанид хийсэн фокус ярилцлагаас үзэхэд: Хуулийн дагуутогтмол солилцвол зохих мэдээллийн зарим нэгийг нь хууль хяналтын байгууллагууд өөр хоорондоо солилцдог байна. Тухайлбал: ХОМ-ыг хүлээн авч, түүний мөрөөр шалгалт, гүн гүнзгий дүн шинжилгээ хийж, зөрчил гаргасан, хугацаа хэтрүүлсэн болон огт ХОМ мэдүүлээгүй албан тушаалтнуудад өөрийн байгууллагын эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авч, улмаар Татвар, Прокурорын байгууллага, СМА-д илэрсэн эрх зүйн зөрчлийн тухай мэдээлсэн байна.

Гэтэл авлига нь мөнгө угаах, татвараас зайлсхийх суурь ойлголтуудтай салшгүй холбоотой болох тухай мэдлэг хомсоос шалтгаалан ХОМ-ээс илэрхий болсон татвараас зайлсхийсэн болон мөнгө угаасан байж болзошгүй тохиолдлуудад хариуцлага ногдуулаагүй төдийгүй “нэг зөрчилд хариуцлага давхардуулан ногдуулахгүй” зарчимтай гэсэн тайлбар гарч байсан байна.

Дээр дурдсан тохиолдлын талаар татварын алба, прокурорын газар болон СМА-д мэдэгдсэн боловч нэгэнт тэдгээрийн ажлын уялдаа холбоо, үүссэн мэдлэгийн хомсдолыг арилгах, зохицуулах газар байхгүй тул хамгийн үр нөлөөтэй шийдэл олох,

мэдээллүүдийг өөрийн шугамаар нягтлах арга хэмжээ авах байгууллага олдоогүй байна.

Танзанийн Нэгдсэн Бүгд Найрамдах Улсын Ерөнхий прокурорын газрын болон тус улсынэдийн засгийн төв төдийгүй баян, том хот гэгдэх Dar es Salaam хотын прокурорууд нь гэм буруутай нь шүүхээр тогтоогдохоос өмнө сэжигтэн, яллагдагч этгээдийн хөрөнгийг хурааж болдог тухай анх сонсоод маш их гайхсан байна. Энэ нь мөнгө угаах, хөрөнгө буцаах ажиллагаа нь цоо шинэ салбар гэдгийг нотолж байна.

**Зургаа: Статистикийн мэдээлэл хомс байх:** Олон улсын туршлага, тулгарч буй хүндрэлд тулгаарлан статистикийн үзүүлэлтүүдийг зөв тодорхойлж, үнэн зөв мэдээллээр хангах нь статистикийн мэдээллийн зорилго болно. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэрэглээний шаардлага хангасан, боловсруулалт хийх боломжтой мэдээллийн сан (статистикийн) үүсгэх, баяжуулах, боловсруулах, ийт чадамжтай байх нь чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бодлого боловсруулагч нарт эрсдлийг үнэлэх, гэмт үйлдлийг урьдчилан таамаглах, чиглэлийг нь тодорхойлох, эрсдэлд өртөмтгий салбарт хөрөнгө нөөц хуваарилахад энэхүү статистикийн мэдээллүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал ХОМ, түүнийг өгөгдөлд шинжилгээ хийх замаар мөнгө угаах механизм, угаагдаж буй мөнгөний урсгалыг тодорхойлж, оролцогч байгууллага, түүний салбарт явуулах, тухайн байгууллагад шаардагдах тоног төхөөрөмжийг сонгоход ашигладаг байна.

Танзани, Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя. Албанид ихэнхи мэдээллийг гараар цаасан дээр бичиж цуглуулсаны дараа нэгтгэдэг тул мэдээллийн бодит байдалд эргэлзэх сэтгэгдэл төрүүлдэг. Мэдээллийн санд нэгж хугацаа тутамд мэдээлэл дамжуулах чиг үүрэг бүхий бүх этгээд өгөгдөл, үзүүлэлтийн дагуу мэдээллийг оруулдаг байхыг зүйтэйд тооцдог.

Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа мөнгө угаах хэргүүдийн суурь гэмт хэргийг тогтоож, тэдгээрийн суурь гэмт хэргийн дотор авлига хэдэн хувийг эзлэж байгаа тухай статистик мэдээлэл Албанид, Танзанид байхгүй байна. Хөгжингүй орнуудаас ч энэ төрлийн мэдээллийг шууд авах боломж хомс байгааг анхаарч, ажиллах хэрэгтэй .

#### **Долоо: Регистр, бүртгэлийн системийн дорой байдал:**

Танзани, Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя. Танзанид иргэдийн бүртгэл мэдээллийн систем нь маш сул байдаг тул зарим банкууд арга буюу жолооны үнэмлэх эсхүл оршин суух газрын тодорхойлолтыг үндэслэн банкны данс нээж өгдөг байна. Хот, суурин газрын хаягжуулах систем байхгүй ажээ.

Банкинд данс нээлгэх иргэн нь иргэний үнэмлэх хамт ирэх тухай, иргэний бичиг баримт (төрсөний гэрчилгээ, иргэний үнэмлэх)-ыг бусдад ашиглуулах, тэр бүү

хэл худалдахыг хориглож, хариуцлага (захиргааны, эсхүл эрүүгийн) ногдуулахыг хуульчлах хэрэгтэй. Энэ нь мөнгө угаах үйлдэлд бусдын нэрийг ашиглах явдлыг таслан зогсооно.

Албанид үл хөдлөх хөрөнгийн бүртгэл шаардлагад нийцдэггүй байна. Бүртгэл нь цаасан дээр хийгддэг тул мэдээлэл авах ажиллагаа удаашралттай байдаг гэнэ. Одоогоор их хэмжээний хөрөнгө бүртгэгдээгүй байх тул засгийн газар нь энэ асуудлыг эрхлэх газар байгуулж, нэг нь албан ёсоор бүртгэдэг бол нөгөө шинэ байгууллага албан бус бүртгэл явуулдаг аж.

Түүнээс гадна үл хөдлөх хөрөнгийг бэлэн мөнгөөр хийхийг зөвшөөрдөг бөгөөд энэ нь цаад жинхэнэ эзнийг тогтооход хүндрэл учруулдаг юм байна.

Аливаа үл хөдлөх хөрөнгийг хэзээнээс эхлэн үл хөдлөх хөрөнгийн газарт бүртгүүлэх, мөн үл хөдлөх эд хөрөнгийг бэлэн мөнгөөр арилжаалахыг хориглож, төлбөрийг банкаар хийх асуудлыг хуульчлах нь оновчтой. Энэ нь бүртгэлгүй хөрөнгө эдийн засгийн харилцаа (түрээслэх, тухайн байранд үйлдвэр, үйлчилгээ эрхлэх гэх мэт)-д орох, мөнгө угаагдах боломжуудыг таслан сэргийлэхэд туслана.

**Найм:Бэлэн бус төлбөр тооцооны сул хөгжил:**Танзани, Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя.

Танзанид төлбөр тооцооны зөвхөн 10% нь банкуудаар дамжиж хийгддэг байна. Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал эрхлэгчдийг хуулийн шаардлагыг хангаж, мэдээлэх үүргээ бүрэн биелүүлэхийг шаарддаг ч үр дүн муу байна.

Дэлхийн банкны (Schneider 2002) судалгаагаар Албанид ҮНБ-ний 33% нь албан бус сектороор дамжиж байна. Мөн их хэмжээний мөнгө Moneygram мэт мөнгөн гүйвуулгаар дамжиж гадагш гардаг.

Шилжүүлсэн бүх мөнгө бохир бус хэдий ч ийм хэмжээний шилжүүлгэнд мониторинг хийх, шалгах хүчин чадал байхгүй.Шилжүүлэг болон бэлэн мөнгөний төлбөр тооцоог хянах боломжгүй үед мөнгө угаахыг хянах радарын гадуур хичнээн хэмжээний мөнгө илрэлгүй урсаж байгааг таамаглах боломжгүй юм.

**Ес:Улсын дотор мөнгө угаах:** Мөнгө угаахын эсрэг арга хэмжээ ихэнхидээ гадагши урсгалтай хөрөнгөнд анхаарал хандуулж байна. Энэ бол өрөөсгөл. Учир нь хууль бус эх үүсвэртэй ихэнхи мөнгийг дотооддоо угаах, эсхүл гадаад улсд угааж, эргүүлэн авч ирдэг.

Танзани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя. Үл хөдлөх хөрөнгийг бэлэн мөнгөөр худалдаж авахыг хуулиар хориглоогүй.

Их хэмжээний бэлэн мөнгөөр гүйлгээ хийх нь ердийн үзэгдэл тул хардалт төрүүлэхгүй.

Тухайн худалдаанд оролцож байгаа мэргэжилтэн, хуульч нарт хардалт төрөх хэдий ч нэгэнт үл хөдлөх хөрөнгийн салбар зохицуулалт муутай тул уг худалдан авалт СМА-д бүртгэгддэггүй.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа уг үл хөдлөх хөрөнгийг дахин зарна.

Энэ хэлцлээс гарч ирсэн мөнгө “цэвэр” буюу эх үүсвэрийг нь шалгах боломжтой.

Энэ нь улс орны хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх боломжийг хүндрүүлж байна.

Олон улсын мөнгө угаахын эсрэг механизм нь аливаа улсын дотоодын хууль тогтоомжоор хариуцлага тооцох боломжгүй улс төрд “асар их” нөлөөтэй этгээдэд хариуцлага тооцох боломж олгодог хэдий ч (Chaikin 2010) улсын доторх мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа ургашгүй бол улс төрд “асар их” нөлөөтэй этгээдэд хариуцлага тооцох асуудал талаар болно.

**Арав: Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн үүргийг харилцан адилгүй тогтоох:** Бүгд Найрамдах Албани Улсын санхүүгийн том байгууллагууд нь гадаадын эзэмшилтэй бол Танзанийн Нэгдсэн Бүгд Найрамдах Улсад гадаадын 10 банкны салбар үйл ажиллагаа явуулдаг байна.

	Албани	Танзани		Албани	Танзани
Арилжааны банк	17	37 <sup>38</sup>	Бүртгэгдсэн валют солих цэг	283	170-аад
Гадаадын хөрөнгө оруулалттай	13	10 <sup>37</sup>		**	**
Нийт хувьцааг дотоодын хөрөнгө оруулагчид эзэмшдэг	3			Ихэнхи нь	**

Эдгээр улсуудын Төв банкны ажилтан нар “Гадны банкууд олон улсын стандартуудыг дагах хандлагатай. Харин дотоодын санхүүгийн байгууллагууд дүрэм, журам биелүүлэх үүргээ хайнга биелүүлдэг” гэжээ.

“Харилцагчаа таних”, мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх боломжтой бол үл хөдлөх хөрөнгө худалдаалах ажил эрхэлдэг албан бус сектор, нотариат, валют арилжаалах компани зэрэг байгууллагуудад тавих хяналт сул байх тохиолдолд эдгээр байгууллагуудад мөнгө угаах эрсдэл нүүрлэхийг анхаарна уу.

Арван нэг:Хяналт тавих этгээдийн ажиллагаа сул, эсхүл огт хяналтгүй, хяналт тавих этгээд тодорхой бус байх: СМА-ны нэг чиг үүрэг нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан мөнгө угаахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах явдал болно.

Харин мэдээлэх үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаандТөв банк, Мэргэжлийн холбоо, Нягтлан бүртгэлчдийн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд хяналт тавьдаг байна.

Мэдээлэх үүргийн хэрэгжилтийг СМА, үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг этгээдүүдхамтран хянах асуудал учир дутагдалтай, зөрчсөн нэгэнд хэн, ямар хариуцлага ногдуулах асуудал тодорхойгүй байгаа нь мөнгө угаахын эсрэг хүчин чармайлт, тэмцлийн үр дүнг бууруулах гол шалтгаануудын нэг болсон байна.

Танзани, Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя.

Улс	Хянах талбар	Хяналт хэрэгжүүлэгч	Хянаж буй байдал
Танзани	Банк	Төв банк	Хуулийн дагуу
Албани	Банк	Төв банк	Бүх банкиг иж бүрэн хамарч чаддаггүй.
Танзани	Мэдээлэх үүрэг бүхий хуульчид	ТанзанийнТанганика Хуульчдын Холбоо (2000 гишүүнтэй)	Огт хяналт тавьдаггүй.
	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаа	СМА Нийт ажилтан:15	Бүх мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт тавихад хүн хүч хүрдэггүй.
	Аудитор, нягтлан бодогч	Нягтлан бодогч, аудиторуудын Үндэсний Зөвлөл	Захирамж, зааварчилгаа гаргаж, хяналт тавьж ажилладаг.
Албани	Банк бус санхүүгийн байгууллага	Төв банк	Бүгдийг бүүрэн хяналтаар хамарч чадаагүй.

Арван хоёр:Халдашгүй байдал: Халдашгүй байдлыг урвуулан ашигласнаас үүсэх эрсдэл нэн өндөр тул “хэнд”, “ямар хугацаагаар олгох”, “ямар тохиолдолд хэн, хэрхэн түтгэлзүүлэхтухай шийдвэр гаргах” зэрэг асуудлыг маш няхуур, оновчтой хуульчлах шаардлагатай.

Албани Улсын талаар энд анхааруулга болгон жишээ татъя.

Албанид парламентын гишүүд болон төрийн өндөр албан тушаалтан нь мөрдөн шалгагдах (сэжигтэн, яллагдагчаар татагдах), шүүн таслах ажиллагаанаас бүрэн хамгаалагдсан байдаг.

Мөрдөн шалгах ажиллагаа эхлэхээс өмнө:

Парламентад хүсэлт гаргана.

Парламентын хуралдаанаар асуудлыг хэлэлцэнэ. Энэ нь дараахь байдлаар мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулдаг. Үүнд:

1) Гишүүд хэн нэг гишүүний бүрэн эрхийг түтгэлзүүлэх санал өгөх магадлал бага. Энэ тохиолдолд прокурорын байгууллага нь өөрт хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх эсэх зөвшөөрлөө парламентаас авч буй мэт болдог.

2) Байцаан шийтгэх ажиллагаа эхлэхээс өмнө түүний нууц задардаг.

Албани Улсд тулгараад байгаа болон адил төстэй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд байцаан шийтгэх ажиллагааны төсвийг зайлшгүй зардал нэг бүрээр зөв төлөвлөх, улс төрчдийн “хууль шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг баримтлах хүсэл эрмэлзэл чухал байдаг болохыг Базелийн засаглалын институт дурдахын хамт ажиглалтад тулгуурласан дараах дүгнэлтийг өгсөн. Үүнд:

Нэг: Хөгжиж буй орнуудын хууль хяналтын байгууллагын ажилтнууд гадны ижил төстэй байгууллагуудтай харилцан санал солилцож, улс оронд нь мөнгө угаагдах эрсдэлд хамгийн өртөмтгий салбаруудыг тодорхойлох ба үнэлэх хэрэгтэй. Энэ нь мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг эрэмбэ дараатай хэрэгжүүлэх боломжийг нээж өгдөг.

Авлига, мөнгө угаахтай тууштай тэмцэх улс төрийн эрмэлзэлийг бий болгох хэрэгтэй.

Энэхүү эрмэлзэлийг мөнгө угаах гэмт хэргээс ашиг хүртэгчид эсэргүүцэх магадлалтай.

Гэвч мөнгө угаах гэмт хэргийн эсрэг, авлигатай тэмцэх шинэтгэлийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төрийн албан хаагчид санаачилга гаргаснаар дурдсан бэрхшээлүүдийг даван туулж чадна.

Танзанийн ярилцлагад оролцогч нэгэн

“улс төрийн эрмэлзэлийг ямар ч хэмжээний техникийн туслалцаа орлохгүй” гэж хэлжээ.

Хоёр: Авлига, мөнгө угаахын эсрэг улс төрийн эрмэлзлэлд иргэний нийгмийн, хэвлэл мэдээллийн гэх зэрэг төрийн бус байгууллагууд дэмжлэг үзүүлэх боломжтой.

---

Банк, санхүүгийн байгууллагууд

Гадаадын банкны салбар

Тодорхой үнийн дүнгээс дээш хэмжээний гүйлгээг СМА-д мэдээлэх үүрэгтэй этгээд

Иргэний нийгмийн байгууллагууд нөлөөллийн ажил хийх, хэвлэл мэдээллийн ажилтнууд сэжиг бүхий хэрэгт эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мэдээллийг бэлтгэж, нийтийн хүртээл болгон улс төрчдөд тодорхой арга хэмжээ авах хүсэл эрмэлзэл бий болгодог. Иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн ажилтнуудын авлига, мөнгө угаах тухай мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах нь ач холбогдолтой арга хэмжээний нэг болно.

Гурав: Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд хамтарсан мөрдөн шалгах нэгж байгуулах нь авлига, мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэх, гэм буруутай этгээдэд ял үл завшуулах боломжийг нээж өгдөг. Хамтарсан нэгжийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулж, засаг захиргааны нэгжүүдэд байгуулдаг байна. Мөрдөн шалгах хамтарсан нэгжийг тодорхой хэрэг шийдвэрлэх ажлын хэсэгтэй адил мэт ойлгохгүй байвал зохино.

Одоо уншигдаж буй зөвлөмжүүдийг бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий дотоодын байгууллагуудад зориулсан “Базелийн засаглалын институт”-ын зөвлөмж болно.

Хөгжиж буй орнуудад хөрөнгө, хүч хомс, нэн түргэн шийдвэрлэх асуудлууд их байдаг тул зөвлөмжүүдийг авах арга хэмжээний тулгамдсан байдлаар (нэн тэргүүнд ба шат дараатайгаар нь авах арга хэмжээ) эрэмблэв.

Нэг: Авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог байгууллагуудын нэг нэгэндээ итгэх итгэлийг сайжруулах, тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах;

Мөнгө угаахын эсрэг, авлигатай тэмцдэг байгууллагууд өөрт ногдсон үүрэг, явуулж буй үйл ажиллагаа болон хариуцаж буй асуудлуудын талаар нээлттэй ярилцах хэрэгтэй. Ингэснээр чадавхиа үнэлэх, дотоод болон гадаадын харилцагч байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулах боломж нэмэгдэнэ.

Ядуу буурай, эсхүл өндөр хөгжилтэй зэргээс үл хамааран улс орнуудын хууль хэрэгжүүлэх байгууллагуудаас бусад

- байгууллагуудтай,
- мөн дотроо харилцах чадвар

сул байдаг нь ажиглагддаг тул энэ талыг нь хөгжүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

Байцаан шийтгэх ажиллагааны нууцыг сахин хамгаалах тулд 24 дүгээр хуудаст бичигдсэн “хамтарсан нэгж” байгуулах замаар байгууллага, ажилтан хооронд мэдээлэл солилцох, өдөр тутмын ажлыг шуурхай явуулах механизм бий болгох нь зүйтэй.

Төрийн байгууллагууд бие биенийхээ чиг үүрэг, эрх хэмжээг ойлгож, өөр хоорондоо



илүү нээлттэй, хамтран ажиллах нь агентлаг хоорондын явцуу болоод жижиг эрх ашгийг хамгаалах гэсэн өрсөлдөөн, хэнээг арилган “бид нэг зорилгын төлөөх төрийн албад” болох эв санааны нэгдлийг ухамсарлуулахын хамт төрийн байгууллага-ажилтан хоорондын итгэлцлийг бэхжүүлнэ.

Энэ нь авлигаас, гэм буруутай этгээд ял завшихаас сэргийлэх үйл ажиллагаанд үнэлж барамгүй дэм үзүүлнэ.

Мөнгө угаахын болон авлигатай тэмцдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгдмэл, цогц санг байгуулж, аль нэг газарт нь төвлөрүүлэх нь оновчтой.

Боломжтой бүх тохиолдлуудад хуулийн болон бүтцийн давхардлыг арилгах арга хэмжээ авах учиртайг анхаарна уу.

Гэхдээ тухайн нэг асуудлыг зайлшгүй хэд хэдэн байгууллага хариуцах шаардлагатай бол үүнийг давхардал хэмээн ойлгохгүй байхыг зөвлөж байна.

Эдгээр арга хэмжээг авахад бага зэргийн нөөц нэмж шаардагдах боловч өндөр үнэтэй тоног төхөөрөмж, урт удаан хугацааны сургалт явуулах хэрэггүй.

Хоёр: Чадварлаг ажилтнуудын тоо, техникийн багтаамжийг нэмэгдүүлэх;

Мөнгө угаахын эсрэг үйл ажиллагаа нь ярвигтай, ээдрээ төвөгтэй. Иймд олон улсын хөгжлийн агентлагууд нь хөгжиж буй орнуудын хууль хэрэгжүүлэх байгууллагуудын дэд бүтцийг сайжруулах, ажилтнууд (төрийн ажилтнуудаас гадна СМА-д мэдээлэх үүрэгтэй хувийн хэвшлийн ажилтнууд)-ыг сургалт, туршлага солилцох арга хэмжээнд хамруулан чадавхийг нь дээшлүүлэхэд туслах хэрэгтэйг анхаарна уу.

Түүнчлэн хөгжиж буй орнууд өндөр хөгжилтэй орнуудын хооронд ажилтнууд солилцож ажиллах хөтөлбөрүүд хэрэгжүүлэх нь үр дүнгээ өгнө.

Гурав: Мэдээлэл цуглуулах ажиллагааг бэхжүүлэх;

Мөнгө угаахба авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцогч талууд буюу СМА, шүүхийн статистикийн төв, түүний хуримтлагдсан мэдээнд дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах нь зүйтэй байна.

Шүүх нь хянан шийдвэрлэгдсэн хэрэгт криминлогийн судалгаа хийх, судалгааны дүнг

Basel Institute on Governance, Steinering 60, 4051 Basel, Switzerland.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь эрх мэдэл бүхий хувь хүн, байгууллагын хууль бус, ёс суртахуунгүй үйл ажиллагаа, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний эсрэг үйлдлийг илчилж, олон түмэнд мэдээлж, нийгмийн хөгжлийн үнэт зүйлс болох эрх чөлөө, ардчилал, ил тод байдлыг хамгаалдаг.  
[Wikipedia.org/сэтгүүл зүй](https://www.wikipedia.org/)

эрх бүхий этгээдэд танилцуулах, холбогдох санал дэвшүүлж шийдвэрлүүлэх, case management-ийг сайжруулах нь чухал ач холбогдолтой.

Мөн үл хөдлөх хөрөнгө, аж ахуйн нэгжүүдийн бүртгэл мэдээллийн сангбаяжуулах, хэрэглэх, шаардлагатай мэдээлэлавах боломжтой програм хангамжийг нэвтрүүлэхийг зөвлөв.

Дөрөв: Хүн амын регистрийн системийг бий болгож, төлбөр тооцоог банкаар хийхийг үүрэг болгох;

Энэ хэсэгт хүн амын бүртгэл сул хийгдэж буй Танзани зэрэг Африкийн бусад орнуудад зориулсан зөвлөмжүүд байх тул орхих нь зөв хэмээн шийдвэрлэв.

Харин манай улсын хувьд дараах төлбөр тооцоог бэлэн бусаар зөвхөн банкаар дамжуулан хийхийг хуульчлах хэрэгтэй болно .

Үүнд:

1. Төрийн байгууллагад хамаарах бүх төлбөр тооцоо,
2. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, соёлын өв, эртний эдлэл, үнэ бүхий уран зураг, валют арилжааны төлбөр тооцоо,
3. Бэлэн мөнгөний төлбөр тооцооны дээд хязгаарыг хуулиар тогтоож, энэ хязгаараас дээшхи төлбөр тооцоог банкаар хийх,

Тав: Хяналтын чиг үүрэг бүхий байгууллагуудыг бэхжүүлэх, түүний мониторинг хийх чадавхийг дээшлүүлэх;

Зөвлөмж(Нэг/Дөрөв)-үүд нь авлига, мөнгө угаахын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн болно.

Үүний зэрэгцээ улсын бүртгэлийн байгууллага ( үл хөдлөх, хуулийн этгээд, иргэний), үл хөдлөх эд хөрөнгийн худалдаа, зуучлал эрхэлдэг хуулийн этгээд ба иргэн, валют солих цэг, банк бус санхүүгийн байгууллага, мөнгөн гуйвуулгын үйлчилгэ, нотариатын СМА-д мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд болон эдгээрийн үйл ажиллагааг хянах байгууллагад сургалт, техник хангамж нэн дутмаг байгааг анхаарахыг зөвлөж байна.

СМА нь мэдээлэх үүргийн хэрэгжилтийн тэдний удирдах дээд удирдах дээд байгууллагатай хамтран хийх нь зүйтэй байдаг байна.

ДОЛОО: АЭК-ИЙН V БҮЛГИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ДОТООДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАЖ, ПРАКТИКТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ

7.1. Тавиннэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

АЭК-ийн хамаарал бүхий заалтууд	Хамаарал бүхий олон талт олон улсын гэрээ
3 дугаар зүйл: Конвенцийн хамрах хүрээ	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенц (Палермогийн конвенц) 2008/05/16 өдөр соёрхон баталсан.
14 дүгээр зүйл: Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	
23 дугаар зүйл: Гэмт хэргээс олсон орлогыг угаах	
31 дүгээр зүйл: Битүүмжлэх, түр хурааххураах	
32 дугаар зүйл: Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах	Зорилго: Энэхүү конвенцийн зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.
33 дугаар зүйл: Мэдээлэгч этгээдийг хамгаалах	
38 дугаар зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа	
43 дугаар зүйл: Олон улсын хамтын ажиллагаа	
46 дугаар зүйл: Эрх зүйн харилцан туслалцаа	

Авлига нь нийгмийн тогтвортойбааюулгүй байдалд аюул учруулахын зэрэгцээ ардчилал, түүний болон ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг доройтуулан сулруулдаг.

Түүнчлэн тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж, зохион байгуулалттай болон эдийн засгийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүний дотор мөнгө угаах гэмт хэрэгтэй салшгүй холбоотой.

Гэмт хэрэг үйлдэж татан төвлөрүүлсэн үлэмж их хэмжээний хөрөнгө , гэмт хэргийн орлогыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, мөнгө угаалтыг зайлшгүй үйлддэг авилга нь үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжилд аюул учруулдагүндэстэн дамнасан гэмт хэрэг мөн.

Авлига нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгааг алдагдуулж, хуульд захирагдах ёсыг үнэгүйдүүлж, гэмт этгээдэд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхийг “хууль бусаар” олгож байна.

Хээл хахууль авах замаарзүй бусаар хөрөнгөжих боломжуудыг хязгаарлах, түүнчлэн ийм эх үүсвэртэй хөрөнгө үүсэх, арилжаалах, гарал үүслийг нь тодорхойгүй

болгох зорилгоор улс дамнууланшилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нэгэнт үүссэн хөрөнгийг буцаан олгох асуудлаар олон улсын хамтын ажиллагаа хамгийн чухаг асуудлын нэг болоод байгаа билээ.

Авлигын гаралтай хөрөнгийн жинхэнэ өмчлөгчийг тогтоох, жинхэнэ өмчлөгчөөс нэхэмжлэл, хүсэлт гаргах буюу гаргасан нэхэмжлэл, хүсэлтийг хангах эрх зүйн зохицуулалтыг батлан гаргах нь хөндөгдсөн эрхийг сэргээх, авлигыг устгахад чухал үүрэгтэйг АЭК-д нэгдэн орсон улс орнууд хүлээн зөвшөөрсөн нь нэн ач холбогдол бүхий арга хэмжээнд тооцогдоно.

Дээрх бүх өгүүлэмжийг АЭК-ийг хэрэгжүүлэх техник, арга зүйн удирдамжид дурдсан байна.

Монгол Улс нь 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөргэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилго бүхий “Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хууль” баталсан нь сайшаалтай боловч шинжээч, мэдээлэгч этгээдийг хамгаалах эрх зүйн зохицуулалт орхигдсон нь АЭК-ийн 32,33 дахь зүйлд заасан шаардлагыг зохих ёсоор хангаагүй гэж дүгнэхэд хүргэв.

Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа, Эрх зүйн харилцан туслалцаа нь АЭК-ийн шаардлагын түвшинд бус байна.

## **7.2. Тавинхоёрдугаар зүйл. Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх**

АЭК-ийн хамаарал бүхий заалтууд	Хамаарал бүхий олон талт олон улсын гэрээ
---------------------------------	---

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенц: II.d), АЭК, II.d) “эд хөрөнгө” гэж хөрөнгө буюу эрхийн хэлбэрээр илэрхийлэгдсэн биет буюу биет бус, хөдлөх буюу үл хөдлөх аливаа актив, түүнчлэн тийм актив буюу тэдгээр дэх эрхийг баталгаажуулж буй хууль зүйн бичиг баримт, баримтыг хэлнэ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенц: II (e) “гэмт хэргийн орлого” гэж ямар нэгэн гэмт хэрэг үйлдсэний үр дүнд шууд буюу шууд бусаар олсон эсхүл авсан аливаа хөрөнгийг хэлнэ.

Эрүүгийн хуулийн 1661 зүйл: Мөнгө угаах

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: 1.1.4. Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.

Ардчилалын үнэт зүйлсийн нэг:

Эрүүгийн хуулийн 268 зүйл: Хээл хахууль авах

14 дүгээр зүйл: Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенц(Палермогийн конвенц):Зорилго:нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.
40 дүгээр зүйл: Банкны нууцлал	Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц: (2008.05.16 соёрхон баталсан)
	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага(FATF-Financial Action Task Force)-ын 40 зөвлөмж: Зөвлөмж нь тухайн улсын хуулийн болон хяналт шалгалтын байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх, санхүүгийн байгууллагын болон бусад үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч нарын авч хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгасан.

52.1:Монгол Улсад банк , банк бус санхүүгийн байгууллага , даатгал , хөрөнгө оруулалтын сан , үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага ,хадгаламж зээлийн хоршоо гэсэн санхүүгийн байгууллагууд эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна.

Дд	Санхүүгийн байгууллага	Тусгай зөвшөөрөл олгодог төрийн байгууллага	Үйл ажиллагааны хяналт хэрэгжүүлэгч байгууллага
1	Банк	Монголбанк	Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо

2	Банк бус санхүүгийн байгууллага	С а н х ү ү г и й н зохицуулах хороо	Санхүүгийн зохицуулах хороо
3	Даатгал		
4	Хөрөнгө оруулалтын сан		
5	Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага		
6	Хадгаламж зээлийн хоршоо		

Дээр дурдсан санхүүгийн байгууллага, түүнчлэн 7) үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, 8) нотариатч нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй болно .

ФАТФ-ын зөвлөмжийг баримтлан үнэт эдлэл, эртний эдлэлийн худалдаа эрхлэгч хувь хүн, хуулийн этгээд, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ буюу ломбард, үнэт цаасны зах зээлд оролцогчийг мэдээлэх үүрэг бүхий этгээдээр тодорхойлохыг зөвлөж байна. Үүний зэрэгцээ хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрыг мэдээлэх үүрэгтэй этгээдээр тодорхойлж, СМА-д илгээх мэдээллийн төрөл, мэдээлэл илгээх сувгийн эрхХалдашгүй байдлыг урвуулан ашигласнаас үүсэх эрсдэл нэн өндөр тул “хэнд”, “ямар хугацаагаар олгох”, “ямар тохиолдолд хэн, хэрхэн түтгэлзүүлэхтүхай шийдвэр гаргах” зэрэг асуудлыг маш няхуур, оновчтой хуульчлах шаардлагатай.

Монгол Улсын хэмжээнд 1097 ломбард /Улаанбаатар хотод 521 (хамгийн олон ломбардтай:Чингэлтэй дүүрэг 109, Баянгол дүүрэг 105) орон нутагт 576 ломбард (хамгийн олон ломбардтай:Орхон аймаг 310 )/ ямар нэгэн хяналт зохицуулалтгүйгээр үйл ажиллагаа явуулж байна . Манай улс 2754685 хүн амтай бөгөөд 15-54 насныхан нийт хүн амын 64,7 хувь буюу 1782282 болно. Тэгвэл 15-54 насны 1625 хүн тутамд 1 ломбард ногдох ажээ.

Банкны тухай хууль

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

Даатгалын тухай хууль;Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль; 4 дүгээр бүлэг

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, 5 дугаар бүлэг

Даатгалын тухай хууль; 13 дугаар бүлэг, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль; 8 дугаар бүлэг

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, 55 дугаар зүйл

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 8 дугаар бүлэг

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль , 9 дүгээр бүлэг

Эдгээр ломбардууд хэдий хэмжээний хөрөнгийг зээлийн эргэлтэнд оруулж байгааг тогтоох боломжгүй. Гэтэл ломбард нь мөнгө угаалтын идэвхитэй оролцогч болохыг судлаачид хэдийн тогтоогоод байна.

Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.4 дахь заалтад “Банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх бол тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэнэ” гэж заасан боловч хууль хэрэглээний болхи байдал нь энэ зохицуулалтыг зөвхөн “хадгаламж зээлийн хоршоодод олгох тусгай зөвшөөрөл”-д хамаарах хэм хэмжээ хэмээн ойлгуулж иржээ.

Түүнчлэн барьцаалан зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой Иргэний хуулийн заалт нь зохицуулбал зохих эрх зүйн харилцааг нягт нямбай, бүрэн хамраагүй хэт энгийн хэм хэмжээтэй байна.

Улс орнууд ломбардын үйл ажиллагааны тухай бие даасан хуультай ажээ. Тухайлбал: “ОХУ-ын ломбардын тухай хууль”, Украйнд ломбардын үйл ажиллагааг “Санхүүгийн үйлчилгээний тухай болон санхүүгийн зах зээлийн төрийн зохицуулалтын тухай хууль”-аар зохицуулдаг байна.

Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний хангавал зохих наад захын жишиг хэм хэмжээг тогтоосон стандарт MNS 5274:2003 нь норматив-техникийн баримт бичгийн 6.12.4 “үл хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгохыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөхгүй үл хөдлөх эд хөрөнгө барьцаалж зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Үүний зэрэгцээ үнэт эдлэлийн,эртний эдлэлийн, авто гэх мэтээр төрөлжсөн ломбардууд үүсч, тэдний эргэлтийн хөрөнгө үлэмж хэмжээнд байгааломбардуудын хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагаанд хяналт тавих шаардлага хэдийн үүссэн байна.

Учир нь иргэн 20,0 саяас дээш төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, эсхүл нэг иргэн цөөн бус тооны хуулийн этгээдийг байгуулахад тэдгээр хөрөнгийн хууль ёсны хөрөнгийн эх үүсвэрийг шаардах, энэ тухай мэдээлэх шаардлага үүсээд байна.

Хуульд төрийн байгууллага хоорондын мэдээлэх үүргийг нэн тодорхой заагаагүй, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа тааруу байгаа өнөө цагт“төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох боломжтой”хэмээх “малгай дор” амар, хялбар мэтээр төсөөлж ирсэн ньАЭК-ийн хэрэгжилтийг сааруулж байгааг

---

2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан.

“бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.16, 24.1

2013 оны 2 дугаар сарын байдлаар

УИХ-ын ТГ-ын судалгааны төв, “Барьцааны зээлдүүлэх үйлчилгээ (ломбард)-ний өнөөгийн байдал, эрх зүйн орчин болон бусад орнуудын туршлага, Харьцуулсан судалгаа (СТ-13/214)-гаар энэ мэдээллийг ЦЕГ-ын 2013 оны 4/113 тоот албан бичгээр авсан ба Орхон аймаг дахь ломбардын тоог дахин лавлаж баталгаажуулсан байна.

УИХ-ын ТГ-ын судалгааны төв, “Барьцааны зээлдүүлэх үйлчилгээ (ломбард)-ний өнөөгийн байдал, эрх зүйн орчин болон бусад орнуудын туршлага, Харьцуулсан судалгаа (СТ-13/214)

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын дүн

анхааралдаа авч, СМА ба АТГ–д төрийн бусад байгууллагуудаас зайлшгүй илгээх мэдээллийн төрөл нэг бүрийг тодорхойлж, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, сангаас мэдээлэл авах ба өөр хоорондоо мэдээлэл солилцох гэрээг байгуулах нь зүйтэй.

Мэдээлэх үүрэг бүхий этгээдээс мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх харилцааны эрх зүйн зохицуулалт

Дд	Мэдээлэх үүрэг бүхий этгээд	Харилцагчийн биеийн байцаалтыг нягталж байх	Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх үүргийн зохицуулалтынхэм хэмжээ
1	Банк	+	1) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл: Харилцагчийг таньж мэдэх 2) 7.1:Энэ хуулийн 4.1-д заасан этгээд . . . батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй. 3) “Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай журам”
2	Банк бус санхүүгийн Байгууллага	+	1) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 5 дугаар зүйл: Харилцагчийг таньж мэдэх 2) 7.1:Энэ хуулийн 4.1-д заасан этгээд . . . батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй. 3) “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”
3	Даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогч	+	
4	Хөрөнгө оруулалтын сан	+	
5	Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага	+	
6	Хадгаламж, зээлийн хоршоо	+	

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 313 тоот тушаалаар батлагдсан.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны 253 тоот тогтоолоор батлагдсан.



7	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага	+	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 5.1:Дараах тохиолдолд энэ хуулийн 4.1-д заасан этгээд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүрэгтэй.
8	Нотариатч	+	2) 7.1:Энэ хуулийн 4.1-д заасан этгээд . . . батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй. 3)“Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай журам”,“Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам” нь Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатчаас мэдээлэх харилцаанд үл хамаарна.

Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай журмуудын хамрах хүрээ, зохицуулах харилцаа:

“Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай журам”	. . . Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, эрх бүхий бусад байгууллагад дамжуулах талаарх банк, түүний удирдлага, ажилтнуудын үйл ажиллагааны харилцааг зохицуулна.
“Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”	. . . гүйлгээний тайланг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд дамжуулахтай холбоотой Санхүүгийн зохицуулах хороонд харъяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулахад оршино.

Дээрх нэр бүхий журмууд нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 4.1.1-4.1.6 дахь заалтад заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийг хамарсан байна.

Ийнхүү зарим мэдээлэх үүрэг бүхий этгээдийн үүргийн хэрэгжилтийг тодорхой

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 7 дугаар зүйл: Гүйлгээний талаарх мэдээлэл

зохицуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй байгаа нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн II бүлгийн хэрэгжилтийг сааруулж, СМА-д мэдээлэгдвэл зохих гүйлгээ бүрэн бус мэдээлэгдэж байна. Иймд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатчаас мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг даруй батлан гаргахыг зөвлөж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 348 дугаар тогтоолын хавсралтаар “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийг хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох хянах журам”-ын 1.2.7 дахь заалтад “санхүүгийн бус бизнес, мэргэжлийн байгууллага, этгээд гэж үл хөдлөх хөрөнгө зуучлагч, үнэт чулуу, металлын арилжаа эрхлэгч, хуульч, өмгөөлөгч болон нотариатч зэрэг бусад бие даасан, хараат бус хуулийн мэргэжилтэн, нягтлан бодогч, траст болон компанийн үйлчилгээ үзүүлэгчийг хэлнэ”, мөн 5.2 дахь заалтад “Энэ журмын дагуу чөлөөлсөн хөрөнгийн талаар болон хөрөнгө шилжүүлэхийг оролдсон тухай мэдээллийг Арилжааны банк нь Монголбанкинд, Санхүүгийн байгууллага болон Санхүүгийн бус үйлчилгээ эрхлэгч этгээд нь СЗХ-д тус тус мэдээлнэ” гэж заажээ. Банкууд нь теллер болон төлбөр тооцоо хариуцсан ажилтанд террорист этгээдийн жагсаалтыг хэвлэмэл эсхүл PDF байдлаар илгээдэг байна. Энэ нь эрсдэл үүсгэж байх тул “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг хянах програм хангамж”-ийг банк, санхүүгийн байгууллагууд худалдан авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, үүнд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо тус тус хяналт тавих нь хэрэгтэй байна.

Монголбанкны Ерөнхийлөгч, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллага болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад өгөх журам”-ыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, ойрын хугацаанд батлах шаардлагатай байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 1661 , 247 , 268 , 2681 , 270 дэх зүйлд заасан гэмт хэргийг бүртгэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахад чухал үүрэгтэй болно.

Банк нь мөнгөн хадгаламжийн болон харилцах, зээлийн дансдыг “Эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 12 дугаар зүйлд зааснаар нээж байна. Данс нээлгэхэд хуулийн дагуу дараахь баримтыг бүрдүүлж, данс нээх хүсэлтийн анкетыг бичнэ.

Хуулийн бичиг баримт	этгээдийн	бүрдүүлэх	Иргэний бүрдүүлэх бичиг баримт
-------------------------	-----------	-----------	--------------------------------

- Мөнгө угаах
- Гэмт хэргийг нуун далдлах
- Хээл хахууль авах
- Хээл хахууль зуучлах
- Хууль бусаар хөрөнгөжих
- Харилцагчийг таньж мэдэх
- 1/ харилцагч данс хаалгах хүсэлтээ бичгээр гаргасан;
- 2/ харилцагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцөл биелэгдсэн;

<p>1/ өргөдөл  2/ улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар,  3/ мөнгөн хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны нотариатчаар баталгаажуулсан гарын үсэг,  4/ тамганы дардас.</p>	<p>1/ өргөдөл, иргэний үнэмлэхийн хуулбар  2/ нотариатчаар баталгаажуулсан гарын үсэг,  **Монгол Улсад байнга оршин суух эрх бүхий гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнд данс нээх шаардлагыг банкууд өөрсдийн эрх зүйн баримт бичгээр сайтар зохицуулж байна.</p>
---	--

Банкууд данс нээх хүсэлтийн анкетыг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн шаардлагын дагуу харилцагчийг таньж мэдэх үүргээ хэрэгжүүлдэг.

“Эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-д нийтийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой хамтрагч этгээдийн нээхийг хүссэн буюу эзэмшиж буй данс, эсхүл тэдний нэрийн өмнөөс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй дансанд хамаарах зохицуулалт байхгүй байна. Түүнчлэн гадаад улсын харъяат болон харъяалалгүй хүнд данс нээх эсэх тухай эрх зүйн зохицуулалтгүй, данс хаах, битүүмжлэх тохиолдлуудыг тодорхой заагаагүй болно.

Эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль нь 1995 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан ба 2001, 2002, 2005, 2009, 2010, 2011 онуудад нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Энэ хуулийнданс нээлгэх хэм хэмжээ нь цаг үеийн шаардлагаас хоцорсон байна.

Иймд “Эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ тусгай стандарт”, АЭК-ийн нэр томъёо, зохицуулалттай нийцүүлэн шинэчлэн найруулахыг зөвлөж байна.

“Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ тусгай стандарт” 11-д “харилцагчийн хийсэн дотоод, гадаад бүх гүйлгээний баримт мэдээллийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалах зохицуулал

Монгол Улсад ямар дансыг “high-value accounts” үзэх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ХБНГУ-ын Key Trade Bank нь “high-value accounts” гэж хугацаатай (7 өдрөөс 10 жил хүртэлх), 1000 еврогоос дээш дүнтэй хадгаламжийн дансбөгөөд хадгаламжийн

3/ хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр гэсэн энгийн тохиолдол төдий.  
АЭК-ийн албан ёсны орчуулгаар “өндөр дүнтэй данс” .  
www.keytradebank.com  
Иргэний бүртгэлийн тухай 22.7 дахь заалт

хэмжээ ба хүү нь шууд пропорциональ хамааралтай байна гэж тодорхойлжээ.

Монгол Улсын банкуудад тусгай нөхцөлтэй хадгаламж гэж нэрлэгдсэн нийтэд зарласан ерөнхий нөхцлөөс дээгүүр хүүтэй хадгаламжийн бүтээгдэхүүн байдаг байна.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.2.1, 23.1 дэх заалтуудад “хадгалуулагчийн НЭР дээр”, “зээлдүүлэгч нь зээлдэгч бүрийн НЭР дээр зээлийн хувийн хэрэг нээж хөтөлнө” гэсэн нь данс бүр данс эзэмшигчийн нэрээр нээгдэхийг хуульчилсан байна.

Гэвч сүүлийн жилүүдэд бусдад нэр, иргэний үнэмлэхээ ашиглуулж бусдын дансыг өөрийн нэрээрнээх, бусдын нэрээр хуулийн этгээд байгуулах замаар эдийн засгийн харилцаанд оролцох үзэгдэл гарсаар байгаа нь “Иргэний үнэмлэхийг бусдад шилжүүлэх, барьцаалах, санаатайгаар гэмтээхийг хориглоно” гэсэн шаардлагыг “нэрээ ашиглуулж байгаа иргэн” биелүүлэхгүй байгаатай, мөн бусдын “нэр, иргэний үнэмлэхийг өөрийн ашиг сонирхлын төлөө ашигласан этгээд”-д хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтгүй байгаатай холбоотой болно.

Иймд УИХ нь “Зөрчилийн тухай хууль”, “Гэмт хэргийн хууль”-ийн төслийг хэлэлцэн батлахдаа эдгээр тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэх нь зүйтэй байна.

Аж ахуйн нэгжийн болон үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, үл хөдлөх эд хөрөнгийн болоод хуулийн этгээдийн өмчлөгчийн хөдлөлийн тайланд судалгаа хийх, анхаарал татахуйц мэдээллийг 6 сар тутам СМА, АТГ-д мэдээлэх үүргийг Улсын бүртгэлийн ерөнхий газар хууль эсхүл хамтын ажиллагааны гэрээгээр хүлээх нь хууль бус хөрөнгө үүсэх, дамжин худалдаалагдахыг зогсоож, хулгайлагдсан хөрөнгийн жинхэнэ эзэн нь болох төрд буцаах үйл явцад чухал үүргийг гүйцэтгэх болно. Үл хөдлөх эд хөрөнгө үүсэх үеэс хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо бий болгох нь тулгамдсан асуудлын нэг болжээ.

Ингэхдээ газар эзэмших, барилга байгууламж байгуулах зөвшөөрөл олгогдох үеэс эхлэн ирээдүйд бүртгэгдэх үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг Үл хөдлөх эд хөрөнгийн газар хөтөлж, барилга байгууламжийн ирээдүйн эзэн, эсхүл захиалан бариулагч нь үл хөдлөх эд хөрөнгийг бүтээж буй хөрөнгийн гарал үүсэл, хэмжээг он дараалалтайгаар бүртгэх байгууллагад өгөхийг хуульчлах нь зүйтэй.

Энэ нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд гарал үүсэл нь тодорхой бус хөрөнгөөр хөрөнгө бүтээгдэхээс буюу мөнгө угаагдахаас урьдчилан сэргийлнэ. Харин хүний эрх, эрх чөлөөнд халдсан, хувийн нууцыг задруулсан хэмээн ойлгогдохгүй болно.

Хувь хүний нууцын тухай хууль нь 1995 онд батлагдаж, 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр нэг удаа нэмэлт өөрчлөлт орсон болно. 3 бүлэг 9 зүйл бүхий энэ хуулийг мөн шинэчлэн найруулж, нарийвчилсан зохицуулалтуудыг оруулах нь зүйтэй байна. Тухайлбал: Хөрөнгийн нууцад үл хамаарах мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйлийг ширхэгчлэн заах хэрэгцээ үүссэн байна. Эс бөгөөс төрийн эрх бүхий байгууллагаас АЭК-ийн хэрэгжилтийн дагуу авсан арга хэмжээ нь хувь хүний нууцад халдсан эсхүл задруулсан хэмээн буруутгагдах тохиолдол үүсэх эрсдэл байна.

Аливаа этгээд нь УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх, төрийн алба хашихаар, Авилгын эсрэг хуулийн 4.1 дэх заалтад заасан ажил, албан тушаал хашихаар нэр дэвших, хүсэлт гаргах үедээ Сонгуулийн ерөнхий хороо, төрийн албанд томилох эрх бүхий этгээдэд өөрийн гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой хамтрагч этгээдийн тухай мэдээллийг өгөх, тэднээс данс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй данс, эсхүл тэдний нэрийн өмнөөс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт тавих болохыг хүлээн зөвшөөрсөн батламжийг авах нь зүйтэй. Үүнийг Төрийн албаны тухай хууль, УИХ-ын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Засгийн газрын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт оруулах замаар хуульчлах шаардлага үүссэн байгааг анхаарна уу.

Одоогийн дагаж мөрдөж буй УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 29.2.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь заалтад нийтийн албан тушаалтан, хамаарал бүхий этгээдийг тодорхойлсон ч энэ хууль нь Авилгын эсрэг тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээдэд үйлчлэхээр хуульчилсан. Нийтийн албан тушаалтан, хамаарал бүхий этгээдийг тэдний эзэмшиж буй дансанд ХАТУУ ХЯНАЛТ ХЭРХЭН ЯВУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ дотоодын хууль тогтоомжид байхгүй байна.

Дансд тавигдах хяналт нь төрийн хөрөнгийг хууль бусаар өөрийн өмчлөлд шилжүүлэхээс урьдчилан сэргийлдэг.

**52.2/А-Б:** “хатуу хяналт явуулах ёстой хувь хүн”, “хуулийн этгээдийн төрөл”, “онцгой анхаарал хандуулах данс” гэсэн ойлголтыг нэг мөр ойлгох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд чиглэсэн арга хэмжээг авах шаардлагатай байна.

Энэ зүйлийн эдгээрээс бусад хэм хэмжээнд хамаарах зохицуулалтыг “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам”, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам” –аар тус тус зохицуулжээ. Түүнчлэн СМА-аас холбогдох сургалтуудыг зохион байгуулсан байна.

**52.3.** “... дурдсан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэл”-д орох мэдээллийг тодорхой болгох шаардлагатай байна.

52.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2013 оны 5 дугаар сарын 31-ны өдөр УИХ баталсан болно. Энэ хуулийн 3.1.7 дахь заалтад “халхавч банк: аливаа нэг улсад бүртгэлтэй боловч, тухай улсдаа бодит байдлаар оршин байдаггүй банкыг хэлнэ”, 5.7 “энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд (банк) халхавч банк болон халхавч банктэй харилцаа тогтоосон банкинд харилцах данс нээхийг хориглоно” гэж тус тус заасан байна.

52.5.“ . . . мэдээллийг ил тод болгох ҮР ДҮНТЭЙ ТОГТОЛЦООГ бий болгох”-ын тулдалбан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгүүдэд дүн шинжилгээ, нэгдсэн хяналт (хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтарсан шалгалт) хийх, эрх зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээний хүрээнд гадаад улсуудын банк, санхүү, хөрөнгийн бүртгэлийн газраас мэдээлэл авах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн төрийн өндөр албан тушаалтан, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтнуудын мэдүүлэгт зайлшгүй дээрх дүн шинжилгээ, нэгдсэн хяналтыг хийж, олон нийтэд мэдээлэх нь оновчтой байна.

Мэдүүлгүүдийг үр дүнтэй байлгах зорилгоор тэдгээрийн асуулгуудад жил тутам хянан нийцүүлэлт хийж, шаардлагатай өөрчлөлтийг оруулж байхыг зөвлөж байна.

52.6“Гадаад улсад бусадтай хамтран эзэмшдэг, захиран зарцуулах гарын үсэг зурах болон бусад эрхтэй дансыг мэдүүлэх ” гэсэн шаардлагад нийцүүлэн “Ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийн 3.2.6 –г өөрчлөх хэрэгтэй. Зөвхөн өөрийн нэрээр төдийгүй, бусдын дансыг захиран зарцуулах эрхийг итгэмжлэл болон түүнтэй адилтгах эрх зүйн баримт бичгээр олгогдсон зэргийг мэдүүлэх тухай оруулахыг зөвлөж байна.

### 7.3. Тавин гуравдугаар зүйл. Эд хөрөнгийг шууд буцан олгох арга хэмжээ

АЭК-ийн хамаарал бүхий заалтууд
43 дугаар зүйл: Олон улсын хамтын ажиллагаа
34 дүгээр зүйл: Авлигын үйлдлийн үр дагавар
35 дугаар зүйл: Хохирлыг нөхөн төлөх
55 дугаар зүйл: Эд хөрөнгийг хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа
56 дугаар зүйл: Тусгай хамтын ажиллагаа
38 дугаар зүйл: Үндэсний эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа
46 дугаар зүйл: Эрх зүйн харилцаа туслалцаа

“Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн Текник, арга зүйн Удирдамж болон Хууль эрх зүйн удирдамж” -д АЭК-ийн 53 дугаар зүйлийг хэрэгжүүлэхийн тулд оролцогч улс нь хууль бусаар бусдын эзэмшилд буй эд хөрөнгийн талаар шүүхэд иргэний нэхэмжлэл гаргах, өмчлөх эрхийг тогтоох, хөрөнгийг буцаан олгох, хохирлыг барагдуулах, нөхөн төлөх, гэмт хэргийн улмаас хохирсон III этгээд хохирлоо нэхэмжлэх, хохирогчоор

Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг  
 “нийтийн албан тушаалтан” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг;  
 “хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;  
 СЗХ  
 Монголбанк

тогтоогдох хууль ёсны эрхийг олгох үүрэгтэй болох талаар дурдсан байдаг.

Монгол улс нь АЭК-ийн 53 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэмээндүгнэж байна. Үүнд:

1) ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсэн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй.

Мөн гадаад улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой нэхэмжлэлийг нэхэмжлэгчийн оршин суугаа (оршин байгаа) газрын, эсхүл хариуцагчийн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гаргах, Монгол улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой маргаан, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга хэмжээ авсан буюу холбогдох этгээд ийм арга хэмжээ авахуулахаар өргөдөл гаргасан бол шүүхийн онцгой харьяаллын хэрэг гэж үзэж хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой байна .

2) Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан бүх нөхцөлд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу явагдах ба гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн аливаа этгээдийг хохирогчоор тооцох, мөн гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгчээр тогтоожбайцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах эрх зүйн үндэслэл бүрэлдсэн байна .

Эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэлийг мөрдөн байцаалт, прокурор, шүүхийн аль ч шатанд гаргаж болно. Нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг уг хэргийн хамт хянан шийдвэрлэх ба нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө. Гэхдээ хэрэг шийдэгдсэний дараа нэхэмжлэл гаргавал Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн дагуу шүүхэд хандах эрхийг нээлттэй олгосон байдаг.

Монгол улс нь хөгжиж буй орны хувьд байцаан шийтгэх ажиллагааны зардал хангалтгүй байдаг нь бодит бэрхшээл болж байна.

Байцаан шийтгэх ажиллагааны зардлыг төр хариуцахаар заасан хэдий ч батлагдсан зардлыг төсөв хүрэлцдэггүй тул зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагаа,

түүнд хамаарах төсвийг зөв тодорхойлж батлахыг эрх бүхий байгууллагад удаа дараа дэвшүүлсэн байна. Гэвч үр дүнтэйгээр шийдвэрлэгдсэн нь бараг байдаггүй талаар оролцогч талуудтай хийсэн уулзалтанд онцолж байсныг энд тэмдэглэе.

Энэ талаар Улсын Ерөнхий прокурорын газраас 2014 оны 06 дугаар сарын 16-ны өдөр прокурор, мөрдөн байцаах байгууллагуудын нэгдсэн уулзалт хийх үеэр ярилцаж, Улсын Ерөнхий прокурор Улсын их хуралд тодорхой санал хүргүүлэхээр шийдвэрлэжээ.

Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр авлигын эх үүсвэртэй эд хөрөнгийг хураан авч, буцаан олгох ажиллагааг хийж болно. Гэхдээ ЭБШХ болон хоёр талт эрх зүйн туслалцаа гэрээ, хэлэлцээрүүдэд хөрөнгө буцаалтыг хэрхэн хийх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг аль болох олон оронтой байгуулах (гэрээгүй улс орнуудтай шинээр нэмж гэрээ байгуулах), урьд эртэд байгуулагдсан гэрээг шинэчлэн байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийн шинэчлэлт хийх чиг үүргийг Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам хүлээж байна.

Түүнчлэн авлигын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, барагдуулах арга замыг эрэлхийлж, хохирогч улсаас хохирол нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргах, эсвэл гэмт этгээдэд ял оногдуулахдаа хохирол нөхөн төлүүлэх талаар холбогдох нэмэлт шийтгэлийг шүүхээс оногдуулж болох талаар Удирдамжид тусгасан байна.

Монгол улсад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хохирогч улс нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт бүрэлдэн тогтсон боловч хохирогчид хохирлыг нөхөн төлбөр хэлбэрээр олгох ажиллагаа нь маш хязгаарлагдмал хүрээнд байна.

“Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 213 дугаар зүйл (Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан) –ийн зохицуулалтаар хохирогчийн зөвхөн эмчилгээ, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого л шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлөгдөнө.

Иймд холбогдох хуулиудад хөрөнгө буцаан олгохтой холбоотой гарах хохирол, нөхөн төлбөрийн асуудлын талаархи нарийвчилсан заалтуудыг нэмж оруулж өгөх нь зүйтэй байна.

Монгол улс нь гэмт этгээдэд ял оногдуулахдаа хохирол төлөлтийн асуудлыг онцгой анхаарч, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд холбогдох заалтууд орсон байна. Үүнд:

---

<http://www.legalinfo.mn/law/details/302?lawid=302>

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002, 16 дугаар зүйл, 190 дүгээр зүйл.

<http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59>. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002. 3,42,43, 115, 117 дугаар зүйлүүд.



- Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд гэмт этгээдэд оногдуулах ялын төрлүүдийг тодорхойлсон ба “эд хөрөнгө” хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр заасан байна.

- Дээрх “эд хөрөнгө хураах” ялын хэрэгжилтийг хангахын тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 76 дугаар зүйлээр шүүх, прокурор, түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь прокурорын зөвшөөрөлтэйгээр тогтоол гарган сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн эд хөрөнгийн хариуцлага хүлээх этгээдийн эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийг хязгаарлах, банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг хязгаарлаж болохоор зохицуулсан.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд “гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээ, шинж чанар” нь хэргийн талаар заавал нотолбол зохих зүйлүүдийн нэг байна.

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 286 дугаар зүйлд шүүхийн тогтоол гаргах үед шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг нь “иргэний нэхэмжлэлийг хангах эсэх, хэрэв хангавал хэнд, ямар хэмжээгээр олгох, түүнчлэн иргэний нэхэмжлэл гараагүй бол эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх” байна.

Техник, арга зүйн удирдамжид “уул уурхайн ашиглалт, дэд бүтцийн ажил явуулах зөвшөөрөл олгохын өмнөбайгаль орчинд үзүүлэх нөлөөллийгогт, эсхүл зохих ёсоор судлаагүйгээстүүнчлэн элдэв төрлийн хорт хаягдлыг хаях(савлаж болон задгайгаар булаах, хүн ам суурьшаагүй буюу сийрэг суурьшилтай бүс нутагт агаарт замхруулах гэх мэт)-ыг зөвшөөрснөөс үүдсэн байгаль орчны тэнцвэр алдагдах,сэргээгдэшгүй бохирдол үүсгэх, хүн амын эрүүл мэндэд хөнөөл учруулахзэрэг ньавлигын хэргээс шалтгаалан шууд бус хохирол болох”-ыг анхааруулан зөвлөсөн байна.

Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт 14 гэмт үйлдлийг бодит хор уршиг учруулсан тохиолдолдбайгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт тооцохоор заасан. Ийнхүү бодит хор уршиг шаардсан нь хууль бус-байгаль орчинд хор хөнөөлтэй шийдвэр гаргаж, гэмт хэрэг үйлдсэн албан тушаалтан ял завших бүрэн боломжийг нээхийн хамтаарэнэ төрлийн гэмт хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэгдэхэд хүргэж байна.

УИХ-дөргөн баригдаж, Хууль зүйн байнгын хороогоор 2014 оны 04 дүгээр сард хэлэлцэгдсэн “Гэмт хэргийн тухай хууль”-ийн төсөлд орсон байгаль орчны эсрэг гэмт хэргүүдийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар шинэчлэн найруулсан байгаа нь сайшаалтай .

Техник, арга зүйн удирдамж, Хууль эрх зүйн удирдамжид“Конвенцийн гишүүн

---

<http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59> Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002. 99 дүгээр зүйл.

[http://www.prokuror.mn/?page\\_id=8686](http://www.prokuror.mn/?page_id=8686) видео.

<http://www.legalinfo.mn/law/details/344?lawid=344> Засгийн газрын тухай хууль, 1992, 5 дугаар зүйл.

<http://www.legalinfo.mn/law/details/344?lawid=278> Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, 2006.

орнуудын шүүх болон бусад эрх бүхий байгууллагууд нь хөрөнгө хураах талаар шийдвэр гаргахдаа авлигын гэмт хэргийн улмаас “хохирсон төрийн өмчлөх эрхээ тогтоолгох тухай нэхэмжлэл”-ийг хүлээн авч харгалзан үзэх боломжтой байх”-ыг зөвлөжээ . ЭБШХ-ийн 286 дугаар зүйлийн нэгэн зохицуулалт нь шүүхийн тогтоол гаргах үед шийдвэрлэвэл зохих асуудлуудын нэг нь “иргэний нэхэмжлэлийг хангах эсэх, хэрэв хангавал хэнд, ямар хэмжээгээр олгох, түүнчлэн иргэний нэхэмжлэл гараагүй бол эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх” харилцаа болно.

Түүнчлэн Монгол улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаах ажиллагаа явуулсан тохиолдолд уг хэргийн шийдвэрлэлтийн талаар холбогдох улсад нь мэдэгдэх үүргийг Монгол улс, зарим орны Засгийн газар хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар байгуулсан гэрээгээр хүлээж байна.

Гадаад улсын иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсаас гарч явсан бол уг хэргийг шалгах явцад цугларсан бүх материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлэх үүргийг ЭБШХ-ийн 402 дугаар зүйлд заасны дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллага хүлээнэ.

Дээр дурдсан эрх зүйн зохицуулалт нь Монгол улс нь АЭК-д нэгдсэн орны хувьд 53 дугаар заалтын (с) шаардлагыг зохих хэмжээнд хангаж байгаа гэж үзэж болно. Хэдийгээр хуулинд зохих заалтууд байгаа боловч тэдгээр нь илүү нарийвчилсан харилцааг зохицуулах чадамжтайгаар хуульчлагдах нь АЭК-ийн шаардлагыг хангах болно. Тухайлбал: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд хөрөнгө буцаан олгох ажиллагаатай холбоотойгоор нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг хохирогч улсад мэдээлэх үүргийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон хоёр талт олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажуулах нь зүйтэй байна.

7.4 Тавин дөрөвдүгээр зүйл. Эд хөрөнгийг хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм ба

7.5 Тавин тавдугаар зүйл. Эд хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа

АЭК-ийн 54 ба 55 дугаар зүйл нь “хөрөнгө хураах олон улсын хамтын ажиллагааны процедур, улс хоорондын хамтын ажиллагааг аль болох бололцоотой бүх арга хэлбэрээр, өргөн хүрээнд дотоодын хууль тогтоомжоор дэмжиж, хамтран ажиллах талаар 55 дугаар зүйлд заасан гишүүн улсын үүргийг 54 дүгээр зүйлд заасан эд хөрөнгийг хураах тухай гадаад улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шилжүүлэх, эсвэл шинээр эхлүүлэх, хүсэлт гаргагч улсын шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгийг битүүмжлэх, түр хураан авах, хураан авах ажиллагаа явуулахыг зөвшөөрөх талаар шаардлагатай арга хэмжээ авах гэх зэрэг арга замаар хэрэгжүүлж болох”-ыг зөвлөсөн байна.

---

<http://www.legalinfo.mn/law/details/344?lawid=50> Эрүүгийн хууль, 2002.  
UNCAC Technical guide, 332009.

ЭБШХ-ийн 401, 403 дугаар зүйлүүдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн байгууллага нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хүсэлт хүлээн авсан бол биелүүлэх талаар бүх талын арга хэмжээ авах, түүнчлэн Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг шалгах хүсэлт ирүүлсэн бол байцаан шийтгэх ажиллагааг эхлүүлэх талаар зохицуулсан. Өөрөөр хэлбэл, Конвенцийн 54, 55 дугаар зүйлд заасан шаардлагыг гишүүн улсын хувьд Монгол улс биелүүлэх боломжтой байна.

Гэтэл Улсын Дээд шүүхийн 2001 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 09 дугаартай “Монгол улсын Олон улсын гэрээ болон Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” тогтоолд тайлбарлахдаа

“...Гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу нэгдэн орсон Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлогдоно. Монгол улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудлыг тусгасан бол гэрээний уг заалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2., Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай эрх бүхий этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

Монгол Улс тухайн гадаад улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй, эсхүл уг гэрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай асуудлыг тусгаагүй бол гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах асуудлыг шүүх шийдвэрлэхгүй” гэж заасан нь АЭК-ийн Техник арга зүйн удирдамж, Хууль эрх зүйн тайлбарын үзэл санаатай нийцэхгүй байгааг анхаарна уу.

Иймд энэхүү УДШ-ийн тогтоолыг АЭК-ийн 54 ба 55 дугаар зүйлийн шаардлагын хүрээнд өөрчлөх нь зүйтэй.

Монгол улсын хувьд хөрөнгө хураах, буцаан олгохтой холбогдсон гадаад орны шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг чармайн ажиллаж байгаа нэгэн хэргийн жишээг судлагааны явцад олсон ба тухайн гадаад орны шүүхийн шийдвэрийг биелүүлж хөрөнгийг буцаан олгоод зогсохгүй, Монгол улсын нутаг дэвсгэрт “мөнгө угаах” гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэй үйлдэл илэрсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн, одоо мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна.

---

[www.parliament.mn/laws/projects/368](http://www.parliament.mn/laws/projects/368)  
UNCAC Legislative guide, 2006, 245 дугаар тал.

Монгол улс, ОХУ-ын хооронд 1999.04.20-ны өдөр байгуулсан “Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай” гэрээ, 42 дугаар зүйл.

Техник, арга зүйн удирдамж, Хууль эрх зүйн удирдамжид зааснаар “гэмт хэрэг үйлдсэн этгээдийг буруутгахгүй байгаа тохиолдолд ч авлигын гэмт хэргийн орлогыг хураахыг зөвшөөрөх”-ийг тухайн оролцогч улсад зөвлөжээ.

ЭБШХ-ийн 24 дүгээр зүйлд зааснаар “хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, гэмт хэрэгт холбогдсон этгээд нас барсан зэрэг тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй буюу хэргийг хэрэгсэхгүй болгох” үндэслэл болно.

Дээрх үндэслэлээр прокурор, шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд уг хэрэгт битүүмжлэгдсэн болон түр хураагдсан хөрөнгө мөнгийг ихэвчлэн улсын орлого болгох, хохирогч нь тодорхой тогтоогдсон бол хохирогчид буцаан олгох эсэх асуудлыг хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоолдоо заавал дурдана.

Харин гэмт этгээд оргон зайлсан тохиолдолд мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болох ба хэргийг түдгэлзүүлсэн байгаа үед гадаад улсаас шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай хүсэлт ирсэн бол мөрдөн байцаалтын ажиллагааг сэргээн явуулах боломжтой.

ЭБШХ-ийн 134 дүгээр зүйлд 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр иргэний нэхэмжлэл болон эд хөрөнгө хурааж болзошгүй явдлыг хангах зорилгоор:

- яллагдагч, сэжигтэн, эсхүл хуулиар тэдний өмнөөс эд хөрөнгийн хариуцлага хүлээвэл зохих хүний эд хөрөнгийг битүүмжлэх,
- эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг нотлох хангалттай үндэслэл байгаа бол уг хөрөнгө, орлогыг битүүмжлэхийг үүрэг болгосон ба шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаагч нь прокурорын зөвшөөрөлтэйгээр битүүмжилсэн эд хөрөнгийг түр хураан авах,
- мөнгөн хадгаламжийг төлөх төлбөрийн хэмжээгээр битүүмжилж, байгууллагын санхүүгийн дансны гүйлгээ хийхийг зогсоох,
- гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг битүүмжлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг эзэмшигч нь тодорхойгүй, эсхүл эзэмшигчид мэдэгдэх нь тус үйл ажиллагааны зорилгод хор хохирол учруулахаар бол эзэмшигч, өмчлөгчид урьдчилан мэдэгдэхгүй байж болох хэм хэмжээг тогтоожээ.

Монгол Улсын хувьд гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн авсан тохиолдолд уг шийдвэрийг биелүүлэх эсэхийг шийдвэрлэх субъект хэн байх нь тодорхойгүй, ямар процедураар энэ шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа нь явагдах

талаар зохицуулсан журам байхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд “шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл”-ээс харахад гадаад улсын шүүхийн шийдвэр биелүүлэх эсэх нь, мөн гадаад орны хөрөнгө хураах, буцаан олгохтой холбогдсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх зардал тодорхойгүй байсаар байна

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлд битүүмжилсэн эд хөрөнгийг хадгалах, бүрэн бүтэн байлгах асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага өөрөө хариуцахаар заасан боловч тухайн эд зүйлийг тогтоосон горимын дагуу хадгалах нөхцөл, боломж хангалтгүй, хөрөнгийг хадгалах үүрэг бүхий субъектэд тавих шалгуур үзүүлэлт тогтоох шаардлагатай байна.

Энэ нь холбогдох байцаан шийтгэх ажиллагааг явуулах хугацаа удаашрах, сунжрах магадлалтай болгож байгааг анхаарна уу.

#### 7.6. Тавин зургаадугаар зүйл. Тусгай хамтын ажиллагаа

АЭК-ийн хамаарал бүхий заалтууд
1 дүгээр зүйл: Зорилго
17 дугаар зүйл: Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, Ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах
23 дугаар зүйл: Гэмт хэргээс олсон орлогыг угаах
31 дүгээр зүйл: Битүүмжлэх, түр хураах, хураах
30 дугаар зүйл: Яллах, шүүхийн шийдвэр гаргах, шийтгэл ногдуулах
37 дугаар зүйл: Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах
46 дугаар зүйл: Эрх зүйн харилцан туслалцаа
51 дүгээр зүйл: Ерөнхий зүйл
52 дугаар зүйл: Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх
55 дугаар зүйл: Эд хөрөнгийг хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа
57 дугаар зүйл: Хөрөнгө эргүүлэн өгөх ба захиран зарцуулах
58 дугаар зүйл: Санхүүгийн мэдээллийн нэгж
62 дугаар зүйл: Бусад арга хэмжээ: эдийн засгийн хөгжил болон техникийн туслалцааны замаар Конвенцийг хэрэгжүүлэх

Дан ганц оролцогч улсын хүсэлтийг дагуу мэдээлэл өгөх буюу тусламж үзүүлэх зарчимд тулгуурласан байдалтай байдаг байсан олон улсын хамтын ажиллагааг 56 дугаар зүйлд урагш нэг алхам урагшлуулж өгсөн заалт болжээ гэж АЭК-ийн Техник, арга зүйн удирдамж -д дурджээ.

Заавал хүсэлт гаргахыг хүлээлгүйгээр, сайн дураар хамтран ажиллах гэсэн ойлголтыг оруулсан нь өндөр хурдтай санхүүгийн гүйлгээний орчинд ялангуяа маш чухалд тооцогдож болох урьдчилан ажиллагаа явуулах арга замыг дэмжиж байгаа заалт юм.

НҮБ-аас 2006 онд гаргасан АЭК-ийн Хууль эрх зүйн удирдамж -д оролцогч улсууд мэдээллийг харилцан сайн дураар солилцон хамтран ажиллах шаардлага тавьж байна.

Ийнхүү мэдээлэл солилцох ажиллагааны суурь тавигдаж, Санхүүгийн мэдээллийн нэгжүүд хооронд болон ижил төрлийн цагдаагийн, прокурорын, шүүхийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох суваг нээгджээ. Ийм харилцааны нэг жишээ нь Эгмонтын бүлэг бөгөөд хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

АТГ нь хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох тухай Дэлхийн банк болон Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачилга (StAR) хөтөлбөртэй харилцах байгууллагаар бүртгүүлэхийн хамтаар StAR Интерполын хамтарсан “Global Focal point” гэх сүлжээг Монгол дахь Интерполын төвтэй хамтран байгуулж, шууд мэдээлэл солилцох ажиллагааны суурийг тавьсныг энд тэмдэглэе.

АТГ ба StAR хөтөлбөр 2013 оны 5 дүгээр сарын 1-ний өдрөөс 2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд хамтран “Монгол Улсын хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, буцаан олгох чадавхийг бэхжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан нь манай улсад хөрөнгө буцаан олгох ажиллагааг идэвхжүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйл ажиллагаа явуулах чадавхийг сайжрах цогц үйл ажиллагааны эхлэл болж байгаа нь сайшаах нь зүйтэй.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь тодорхой мэдээллийг албан болон албан бусаар олж авах арга замуудыг бүрэн ашиглахад анхаарах шаардлагатай байна. Тухайлбал: Гадаад улсад байгаа сэжигтэн, гэрч, хохирогчийн хаягийн талаар болон бусад мэдээллийг Интерполоор, хөрөнгө мөнгө байршсан эсэх, тухайн бизнесийн байгууллага хууль зүйн дагуу бүртгэлтэй эсэх зэрэг мэдээллийг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх алба болон StAR хөтөлбөр, мөн хөрөнгө хураан авах, царцаах чиглэлээр ажилладаг Европ дахь мэргэжилтнүүдийн албан бус сүлжээ-/CARIN-Camden Asset Recovery Inter-Agency Network /, Ази дахь ARIN зэрэг

байгууллагаас хүлээн авсны дараа тухайн этгээдийг байцаах, төрөл бүрийн лавлагаа авах зэрэг ажиллагааг хийлгэхээр хүсэлт, даалгавраа илгээх боломжийг албан хэрэгтээ нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагууд, онцгойлон хэлэхэд Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, хууль хяналтын байгууллагууд тус тусын жижиг ашиг сонирхлыг огоорч, төр түмний эрх ашгийн учир хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог нэн даруйшинэ түвшинд гаргах хэрэгтэй.

### 7.7. Тавин долоодугаар зүйл. Хөрөнгө буцаан өгөх ба захиран зарцуулах

АЭК-ийн хамаарал бүхий заалтуудыг бусад зүйлүүдийн судалгаа, үнэлгээнээс үзнэ үү.

263 дугаар зүйл: 1. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах

	Үр дагавар	Ял шийтгэл	
		Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах + Торгох	3 жил хүртэл хугацаагаар хасан буюу хасахгүйгээр
Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан	Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэн 960 000-9 600 000 MNT
		Эсхүл Баривчлах	1-3 сар

Давтан үйлдсэн	Их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах+ Торгох	5 жил хүртэл хугацаагаар хасах
		Торгох	51-100 дахин нэмэгдүүлсэн 9 792 000-19 200 000 MNT
		Эсхүл Хорих	Эсхүл 5 жил хүртэл хугацаагаар



264дүгээр зүйл: Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх

	Үр дагавар	Ял шийтгэл	
		Төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан
		Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэн 960 000-9 600 000 MNT
		Эсхүл Баривчлах	1-3 сар
Давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн	Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол	Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах+ Торгох	5 жил хүртэл хугацаагаар хасах 51-100 дахин нэмэгдүүлсэн 9 792 000-19 200 000 MNT
		Баривчлах	3-6 сар
		Эсхүл Хорих	Эсхүл 5 жил хүртэл хугацаагаар

192 000 төгрөг  
192 000 төгрөг

268дугаар зүйл: Хээл хахууль авах

Хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан бол	Үр дагавар	Ял шийтгэл	
		Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах + Торгох	3 жил хүртэл хугацаагаар хасч
Давтан, Хясан боогдуулах замаар эсхүл, Их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан	Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол	Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-200 дахин нэмэгдүүлсэн 972 000-38400 000 MNT
		Эсхүл хорих	5 жил хүртэл
З о х и о н байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн		Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах+ Торгох	5 жил хүртэл хугацаагаар хасах 51-100 дахин нэмэгдүүлсэн 9 792 000-19 200 000 MNT
		Эд хөрөнгийг хураах	Эд хөрөнгийг хураах
		Хорих	5 дээш 10 жил

192 000 төгрөг  
192 000 төгрөг

270<sup>1</sup> дүгээр зүйл: Хууль бусаар хөрөнгөжих(Тайлбар: Энэ хуулийн 2701 дүгээр зүйлд заасан эд хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл гэж үзнэ)

заасан эд хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл гэж үзнэ) Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол Үр дагавар Ял шийтгэл	Үр дагавар	Ял шийтгэл	
	заасан эд хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл гэж үзнэ) Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол Үр дагавар Ял шийтгэл		Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг + Торгох
Торгох			Х ө д ө л м ө р и й н хөлсний доод х э м ж э э г 5 1 - 2 0 0 д а х и н нэмэгдүүлсэн 972 000-38400 000 MNT
Эсхүл хорих			3 жил хүртэл
Нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээгээр эд хөрөнгө, орлого олсон нь тогтоогдсон бол		Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах+ Торгох	5 дээш 10 жил хүртэл хугацаагаар хасах Х ө д ө л м ө р и й н хөлсний доод хэмжээг 251-500 дахин нэмэгдүүлсэн 48,0 сая-96,0 сая MNT
		Хорих	3 дээш 8 жил

166<sup>1</sup>дүгээр зүйл: Мөнгө угаах

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг 1/авсан, 2/эзэмшсэн, 3/ашигласан, эсхүл 4/түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, 5/далдлах, 6/гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, 7/шилжүүлсэн, 8/эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол	Үр дагавар	Ял шийтгэл	
		Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэн 9 600 000-19 200 000 MNT
		Эсхүл баривчлах	1-6 сар хүртэл хугацаагаар
Энэ гэмт хэргийн улмаас 1/ онц их хэмжээний хохирол учирсан, 2/эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, 3/эсхүл зохион байгуулалттай бүлэг, 4/гэмт бүлэглэл үйлдсэн бол		Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэн 57 600 000-96 000 000 MNT
		Эсхүл Хорих	5-12 жил
Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн		Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах+Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300-500 дахин нэмэгдүүлсэн 57 600 000-96 000 000 MNT

Эрүүгийн хуульд “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг БҮГДИЙГ буюу ЗАРИМЫГ үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах

ял гэнэ хэмээн заасан. Энэхүү 49.1 дэх хэсгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн "... хувьд ногдох эд хөрөнгө ..." нь Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсэгт дурьдсан тухайн этгээдийн өөрт нь өмчлөгдсөн иргэний эд хөрөнгө, дундын өмчлөлийн эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс бүрдэнэ. Дундаа хэсгээр өмчлөгчийн түүнд ногдох хэсгийг Иргэний хуулийн 108, 129 дүгээр зүйлд зааснаар тус тус тодорхойлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.7-д заасан үндэслэлийг баримтлаж гаргуулна гэж Улсын Дээд Шүүхийн "Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай" 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор тайлбарласан байна.

УДШ-ийн энэхүү тогтоолыг тайлбар нь АЭК-ийн 2 дугаар зүйл г) "Хураах" гэж (зохих тохиолдолд улсаас бусдад хураахыг багтааж ойлгоно) шүүх буюу эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эд хөрөнгийг бүрмөсөн авахыг хэлнэ гэсэн хэм хэмжээтэй, 31 дүгээр зүйлийн 1-а) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлого буюу тийм орлогын үнийн дүнтэй тохирох үнийн дүн бүхий эд хөрөнгө,

1-в) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэхэд ашигласан эсхүл ашиглах зориулалттай эд хөрөнгө, тоног төхөөрөмж бусад хэрэгсэл гэсэн хэм хэмжээтэй үл нийцэж байх тул түүнийг өөрчлөх, "Гэмт хэргийн тухай хууль"-ийн төсөлд "хөрөнгө хураах ял"-ын эрх зүйн зохицуулалтыг АЭК-ийн 2 ба 31 дүгээр зүйлд зааснаар оруулах шаардлагатай.

Гэмт хэргийг нуун далдлах, үл мэдээлэх:

246	Гэмт хэргийг үл мэдээлэх	268. Хээл хахууль авах	
	268.2 Хээл хахууль авах хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн . . . Энэ гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэж байгаа буюу үйлдсэнийг лавтай сайн мэдсэн атлаа зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлээгүй бол	268.2 Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах	
		Торгох	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 - 5 0 д а х и н нэмэгдүүлсэн 96 000-960 000 төгрөг
		Эсхүл баривчлах	3 хүртэл сар
247	Гэмт хэргийг нуун далдлах	268. Хээл хахууль авах	
	247.1.Энэ хуулийн тусгай ангийн 268.2 заасан гэмт хэргийг урьдчилан амлалгүйгээр нуун далдалсан бол . . .	268.2 Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хээл хахууль авах	
		Албадан ажил хийлгэх	300-400 цаг
	Хорих	Хорих 4 жил хүртэл	

Монгол Улсад хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэхэд ХӨРӨНГӨ ХУРААХ ял ногдуулдаггүй байна. Харин Эрүүгийн хуулийн 268.2 дахь хэсэгт “Хээл хахууль авах гэмт хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд , түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж хуульчилжээ.

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын статистик судалгааг үзэхэд “хорихоос бусад төрлийн ял” -уудаас хамгийн бага ногдуулдаг ял нь “хөрөнгө хураах

Хянан шалгах эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтарсан шалгалт хийх, Тухайлбал: Татварын ерөнхий газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, Монголбанк, Нийгмийн даатгалын ерөнхий газар гэх мэт

85.2.Компанийн эрх бүхий албан тушаалтан дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчид учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

Эрүүгийн хууль, 49.2,49.3

ял” байна.

Дд	Он	Хөрөнгө хураах гүйцэтгэх хуудас бичигдсэн тоо		Хөрөнгө хураах ялыг гүйцэтгэсэн тоо		
		Хөрөнгө хураах ялын мөнгөн дүн		Хураасан хөрөнгийн дүн (төгрөг)		
1	2011 он	337 хүн	94 189 000 төг	225 хүн	53 сая төг	61,5 хувь
2	2012 он	318 хүн	95 868 000 төг	231 хүн	55 740 000 төг	64,4 хувь
3	2013 он	585 хүн	224 сая төг	492 хүн	193985000 төг	85,3 хувь

Ийнхүү хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах төрлийн гэмт хэргүүдэд хөрөнгө хураах ялыг ногдуулах тухай эрх зүйн зохицуулалт туйлынучир дутагдалтайбайх тул улсын доторх хөрөнгө буцаалтын үйл ажиллагааны талаар дүгнэх асуудал мухардмал боллоо.

Эдгээр гэмт хэргүүдэд хөрөнгө хураах ялыг ногдуулахгүй байгаа нь Эрүүгийн хуулийн “ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛЫН ХЭР ХЭМЖЭЭ, ГЭМ БУРУУТАЙ ЭТГЭЭДИЙН ХУВИЙН БАЙДАЛ, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРСОН БАЙНА” гэсэн шударга ёсны зарчимд нийцэхгүй байна. Иймд “Гэмт хэргийн тухай хууль”-ийн төслийг УИХ хэлэлцэн батлах үед энэ зөвлөмжийг гойд анхаарна уу.

Улсын Дээд Шүүхийн “Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай” 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор Эрүүгийн хуулийн 49.1 дэх хэсгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн “ ... хувьд ногдох эд хөрөнгө ... ” нь Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсэгт дурьдсан тухайн этгээдийн өөрт нь өмчлөгдсөн иргэний эд хөрөнгө, дундын өмчлөлийн эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс бүрдэнэ. Дундаа хэсгээр өмчлөгчийн түүнд ногдох хэсгийг Иргэний хуулийн 108, 129 дүгээр зүйлд зааснаар тус тус тодорхойлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.7-д заасан үндэслэлийг баримтлаж гаргуулна гэж тайлбарласан нь УЧИР ДУТАГДАЛТАЙ БАЙНА.

Ийнхүү 1)хээл хахууль авах,2)хууль бусаар хөрөнгөжих, 3)мөнгө угаах гэмт хэрэгт хөрөнгө хураах ялыг ногдуулахгүй, эсхүл хураагдвал зохих хөрөнгийг бүрэн хамрахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор уршигийг өсөн нэмэгдүүлж байна хэмээн дүгнэхэд хүргэв. Улмаар “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийн практик хэрэглээг үнэгүйжүүлж байна. АТГ ньхөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахдаа нэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Компанийн тухай хуулийн 84.1 дэх заалтад Компанийн төлөөлөн удирдах

Хууль сахиулах талаар хамтран ажиллах  
Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл олгогдож, үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг санхүүгийн байгууллагууд

зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно, мөн хуулийн 84.10 дахь заалтад Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт гаргасан хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд нь энэ хуулийн 84 дүгээр зүйлд заасан хариуцлагыг эрх бүхий албан тушаалтны нэгэн адил хүлээнэж заасан байх тул Хуулийн этгээд нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд түүний эрх бүхий албан тушаалтанд ял шийтгэл ногдуулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.

“Гэмт хэргийн тухай хууль”-ийн төсөлд энэ тухай санал хүргүүлэхийг зөвлөж байна.

Дээр дурдсан учир дутагдал оршин байгаа ч манай улсын эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана”, “шүүх эд хөрөнгө хураах ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана гэж заасан” байна.

#### 7.8. Тавин наймдугаар зүйл. Санхүүгийн мэдээллийн нэгж

АЭК-ийн хамаарал бүхий заалтуудыг өмнөх зүйлүүдийн судалгаа, үнэлгээнээс үзнэ үү.

Хамаарал бүхий олон талт олон улсын гэрээ:	
Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц	2008 оны 5 дугаар сарын 16 өдөр соёрхон баталсан.
Үндэстэндамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ийн конвенц (Палермогийн конвенц) 2008/05/16 өдөр соёрхон баталсан.	Зорилго: Энэхүү конвенцийн зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.



<p>Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (FATF-Financial Action Task Force) 40 зөвлөмж</p>	<p>Зөвлөмж нь тухайн улсын хуулийн болон хяналт шалгалтын байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх, санхүүгийн байгууллагын болон бусад үйл ажиллагаа эрхлэгч, мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч нарын авч хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгасан.</p>
---	--

АЭК-ийн V бүлгийг үнэлэх судалгааны явцад Монгол Улсын СМА нь сайшаалтай ажиллаж байна хэмээн нижгээд олон улсын байгууллагаас үнэлсэнийг тэмдэглэе. Хойшид дараахь арга хэмжээг авахыг зөвлөж байна. Үүнд: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан “Хамтын ажиллагааны зөвлөл”-ийг байгуулж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж ажлыг системтэйгээр зохион байгуулах шаардлагатай байна. Үүний тулд Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн, түүний удирдлагыг батлана уу.

АЭК-ийн 48 дугаар зүйлийг хэрэгжүүлэхийн учир өөрийн орны төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, энэ тухай гэрээ байгуулах, мэдээлэл солилцох харилцааг шинэ түвшинд гаргах хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж байгааг анхаарна уу.

Авилга, мөнгө угаалтын өсөлт, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн шалгах тогтолцоог боловсронгуй болгох, улмаар үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс Санхүүгийн мэдээллийн албыг Санхүүгийн тагнуулын алба болгон Төв банкны бүтцээс гаргах арга хэмжээг хэтдээ шат дараалалтай авах хэрэгтэй байна.

Зарим мэдээлэх үүрэг бүхий этгээдүүдээс мэдээлэл цуглуулах харилцаа Санхүүгийн зохицуулах хороогоор дамжихын зэрэгцээ бүх мэдээлэх үүрэг бүхий этгээдээс мэдээлэл мэдээлэгдэх харилцаа хуульд заасан шаардлагыг хангахгүй байгаад дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг даруй авна уу.

Үүний тулдүл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатчаас мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг даруй батлан гаргахыг зөвлөж байна.

UNCAC Technical guide, 2009.[http://www.unodc.org/documents/corruption/Technical\\_Guide\\_UNCAC.pdf](http://www.unodc.org/documents/corruption/Technical_Guide_UNCAC.pdf)  
 compliance  
 Гэрээний жагсаалтыг дараах линкээс авна уу [http://moj.gov.mn/legal\\_assistance\\_treaty.html](http://moj.gov.mn/legal_assistance_treaty.html)

Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллага болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад өгөх журам”-ыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, энэ жилд батлах шаардлагатай байна.

StAR санаачлагаас гаргасан судалгааны дүн, шинжилгээний тойм ба Бусад зүйлийн судалгаа, үнэлгээнээс холбогдох хэсгийг харахын хамтаар тэдгээрт дурьдсан арга хэмжээг авах нь зүйтэй.

### 7.9. Тавин есдүгээр зүйл. Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

АЭК-ийн хамаарал бүхий заалтууд
1 дүгээр зүйл: Зорилго
3 дугаарзүйл:Конвенцийнхамраххүрээ
4 дүгээр зүйл: Бүрэн эрхт байдлыг хамгаалах
14 дүгээрзүйл:Мөнгөугаахаасурьдчилансэргийлэхаргахэмжээ
38 дугаарзүйл:Үндэснийэрхбүхийбайгууллагахоорондынхамтынажиллагаа
43 дугаарзүйл:Олонулсынхамтынажиллагаа
46 дугаар зүйл:Эрхзүйнхарилцантуслалцаа
56 дугаар зүйл:Тусгай хамтын ажиллагаа

Хүн төрөлхтөн болоод цэнхэр гаргийн аюулгүй байдлыг сахин хамгаалахын учир өөрийн иргэд, төр улсынхаа эрх ашгийг сахин хамгаалах зорилгын дор АЭК-ийн 51 дүгээр зүйлд заасан ерөнхий зарчмыг үндэслэн улс орон бүр бусад улсын төр засагтай хоёр ба олон талт хэлэлцээрийг байгуулахыг зөвлөдөг.

АЭК-ийн техник, арга зүйн удирдамж -д “хөрөнгө буцаан олгох тухай хэм хэмжээ бүхий хоёр талт буюу бүс нутгийн хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай дотоодын хууль тогтоомж гаргасан оролцогч улсууд нь тэдгээр хэлэлцээрүүдийг АЭК-ийн V бүлэгтэй хянан нийцүүлж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл шинэчлэн байгуулах асуудлыг нягтлан шалгаж байхыг заасан. Үүний тулд оролцогч улсууд АЭК-ийн хэрэгжилтийг бүрэн хангах, хамтын ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор талуудын байгуулсан олон улсын гэрээнд хамаарах нэмэлт протоколыг байгуулж байхыг анхаарна уу.

Энэ чиг үүргийг Хууль зүйн яам, Гадаад хэргийн яам хамтран хэрэгжүүлэх ёстой.

Эрх зүйн ялгаатай тогтолцоо, улс орнуудын хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх дотоодын хууль тогтоомжийн арга техникээс хамаарч, хөрөнгө буцаан

StAR, АТГ-аас санаачилсан ХЗЯ, УЕП-ын хамтарсан тушаалаар батлагдах Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа хүсэх тухай гарын авлагын төсөл-с иш татав  
<http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59>  
398 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх

олгох хамтын ажиллагаанд техникийн бэрхшээл гарч болох учир юуны өмнөийм бэрхшээл учирч болзошгүй улсуудтай хоёр талт хэлэлцээр байгуулах нь зүйтэй гэж мэргэжилтэн судлаачид дүгнэдэг байна.

Нэг: Монгол Улс нь 19 улсын засгийн газартай 1968-2001 онуудад иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай хэлэлцээрийг байгуулжээ. Эдгээр нь эрх зүйн туслалцааны хоёр талт хэлэлцээр бөгөөд нилээд нь “социализм”-ын он жилүүдэд байгуулагдсан байна.

Иймд Гадаад хэргийн яам, Хууль зүйн яам хамтран хуучин цагт (шинэ үндсэн хууль батлагдахаас өмнө) байгуулагдсан хэлэлцээрүүдийг АЭК-тайхянан нийцүүлж, нэмэлт протокол үйлдэх хийгээд шинэчлэн байгуулахыг зөвлөж байна.

Хоёр: Монгол улсын Цагдаагийн Ерөнхий газар нь БНСУ, Бүгд Найрамдах Турк Улс, Оросын Холбооны Улсын цагдаагийн төв байгууллагатай, Дорноговь аймгийн Замын Үүд сумын цагдаагийн хэлтэс нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Цагдаагийн газартай тус тус хамтран ажиллах санамж бичиг, хэлэлцээр, протокол байгуулаад байна.

Монгол Улсын Прокурорын байгууллага нь гадаад улсын адил төрлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг, гүйцэтгэлийн гэрээ 20 байгуулжээ.

Эдгээрийг байгууллага хоорондын олон улсын гэрээ гэнэ.

Прокурорын байгууллагаас байгуулсан байгууллага хоорондын олон улсын гэрээний хүрээнд цуглуулсан нотлох баримт нь

- ЭБШХ-ийн 398 дугаар зүйлд “ . . . эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ”, “ . . . олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан байгууллагаар дамжуулан явуулна” ,

- Олон Улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан “олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн Газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн Газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талтын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ” гэсэн хэм хэмжээнд тус тус нийцэх эсэхийг хянан тохиолдуулж, шүүнтаслах ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд бүрэн үнэлэгдэх эсэхийг магадлан тогтоож, гарсан дүгнэлтийг үндэслэн зохих зөвлөмж, УДШ-ийн тайлбар гаргах, эсхүл хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорууд нь тодорхой мэдээллийг албан болон албан бусаар олж авах арга замуудыг бүрэн ашиглах, нэмж ижил төрлийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох сувгуудад нэгдэх ажлыг түргэвчилэх

---

Конвенцийн жагсаалт, эх текстийн линкийг Тайлангийн хавсралт № IV-өөс үзнэ үү.

398/403 дугаар зүйл

ажлыг анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, гадаад улсад байгаа сэжигтэн, гэрч, хохирогчийн хаягийн талаар болон бусад мэдээллийг Интерполоор, хөрөнгө мөнгө байршсан эсэх, тухайн бизнесийн байгууллага хууль зүйн дагуу бүртгэлтэй эсэх зэрэг мэдээллийг НҮБ-ын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх алба болон Дэлхийн банкны хамтарсан “Хулгайлагдсан эд хөрөнгийг буцаан олгох тухай олон улсын санаачилга” /StAR/, мөн хөрөнгө хураан авах, битүүмжлэх чиглэлээр ажилладаг Европ дахь мэргэжилтнүүдийн албан бус сүлжээ-/CARIN-Camden Asset Recovery Inter-Agency Network/, Ази дахь ARIN зэрэг байгууллагаас авсны дараа тухайн этгээдийг байцаах, төрөл бүрийн лавлагаа авах зэрэг ажиллагааг хийлгэхээр хүсэлт, даалгавраа илгээх боломж байна.

Монгол улсын прокурор, цагдаагийн байгууллага гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах талаар байгуулсан санамж бичиг, хэлэлцээрүүдийг үндэслэн эрүүгийн хэрэгт нотлох баримтыг цуглуулж болох эсэх талаар зарим талаар ойлгомжгүй байдалтай байна. Иймд:

А)Өөрөөр хэлбэл 2 орны хил залгаа хуулийн байгууллагууд хоорондоо хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулан түүний дагуу олж авсан нотлох баримтыг шүүх үнэлэхгүйгээр хэргийг буцаах тохиолдлууд гарч байхад нөгөө талд прокурорууд ийм байдлаар цуглуулсан нотлох баримтыг үнэлэн хэргийг шийдвэрлэсэн тохиолдол гарч байгааг цэгцлэх, протокол, гэрээ болон санамж бичгүүдэд нэмэлт оруулах, оролцогч улсуудын даалгавар, хүсэлт буцаах үндэслэлийг аль болох боломжит хэлбэрээр багасгасан гэрээ, хэлэлцээр болон нэмэлт протокол, санамж бичиг байгуулах

Б)Эрх зүйн харилцан туслалцааны хүрээнд авч хэрэгжүүлэх нарийн процессыг ЭБШХ-д дэлгэрэнгүй тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах

Гурав: НҮБ-аас батлан гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээрүүд нь олон талт олон улсын гэрээ, хэлэлцээр хэмээн ойлгогдоно. Энэ төрлийн гэрээнд оролцогч нь бусад оролцогч талуудыг эрх зүйн туслалцаа үзүүлэхийг шаардах эрхтэй.

Дд	Монгол Улсын нэгдэн орсон олон талт гэрээ, хэлэлцээрийн төрөл (конвенц, протокол)	Нэгдэн орсон олон талт гэрээ, хэлэлцээрийн тоо
1	Хүний эрхийн	40 гаруй
2	Олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбарт	20 гаруй
3	Дипломат, консулын эрх зүйн чиглэлээр	4
4	Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр	20 гаруй

Эрх зүйн харилцан туслалцааны чухаг эх сурвалж нь олон улсын олон талт

гэрээ хэлэлцээр болно. Иймд энэ төрлийн гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орох ажлыг шуурхайлах нь ажил хэргийн үр дүнд тустай.

Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх, уг даалгавар нь ямар шаардлага хангасан байх, гадаад орноос ирүүлсэн даалгавар, хүсэлтийг биелүүлэх, хэргийг гадаад улсад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх ажиллагааг ЭБШХ-ийн 45 дугаар бүлгээр зохицуулна.

Гэхдээ ЭБШХ-ийн 45 дугаар бүлэг нь даалгавар өгөх нарийн нийлмэл ажиллагаанд хамаарах процессын зохицуулалт бүрхэг (зохицуулаагүй гэж дүгнэгдэх хэмжээний) байгаагийн зэрэгцээ гадаад улсад илгээх даалгавар, хүсэлт нь шаардлага хангасан хэв загвар, бичвэрийн хэмжээнд бус, орчуулга муугийн дээр холбогдох зардал төсөвлөгдөөгүй, хураагдсан хөрөнгийн хамгаалалт, хадгалалт, хөрөнгийн менежментийн асуудал зохицуулалтгүй байгааг анхаарна уу.

Байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх, уг даалгавар нь ямар шаардлага хангасан байх, гадаад орноос ирүүлсэн даалгавар, хүсэлтийг биелүүлэх, хэргийг гадаад улсад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх ажиллагааг ЭБШХ-ийн 45 дугаар бүлгээр зохицуулна.

Гэхдээ ЭБШХ-ийн 45 дугаар бүлэг нь даалгавар өгөх нарийн нийлмэл ажиллагаанд хамаарах процессын зохицуулалт бүрхэг (зохицуулаагүй гэж дүгнэгдэх хэмжээний) байгаагийн зэрэгцээ гадаад улсад илгээх даалгавар, хүсэлт нь шаардлага хангасан хэв загвар, бичвэрийн хэмжээнд бус, орчуулга муугийн дээр холбогдох зардал төсөвлөгдөөгүй, хураагдсан хөрөнгийн хамгаалалт, хадгалалт, хөрөнгийн менежментийн асуудал зохицуулалтгүй байгааг анхаарна уу.

Харин АТГ нь бие даасан гадаад харилцааны хэлтэс, орчуулагч-ажилтнуудтай нь дээрх хүндрэлийг өөрийн байгууллагын хэмжээнд шийдвэрлээд байна.

Олон улсын гэрээ, хэлэлцээр, гарын авлага, оролцогч улсуудын хууль тогтоомжийн орчуулга, түүний чанарт тавих хяналт нь шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болжээ. Тухайлсан хэрэгт бичигдсэн хүсэлт, даалгаврын орчуулга хийгдэхэд тодорхойцагхугацаа шаардлагатай байдаг, түүнчлэн шаардлагын төвшинд мэргэжлийн орчуулгыг богино хугацаанд хийх чадвартай орчуулагч нарын талаарх мэдээллийн сайн байхгүй байна. Нэгэнт хийгдсэн орчуулга нь чанарын шаардлага хангасан байна уу гэдгийг хянах боломжгүй, орчуулгын зардлыг төрийн аль байгууллага нь хариуцах нь тодорхой биш зөвхөн төр хариуцна гэсэн тодорхой бус заалт байгааг дотоодын хууль тогтоомжид маш тодорхой болгон холбогдох хуулийн байгууллагын жилийн төсөвт яг орчуулгын зардал нэрээр суулган батлах нь энэ төрлийн хэргийг шийдвэрлэхэд

---

[http://www.oas.org/juridico/mla/en/can/en\\_can\\_loi\\_mla.html](http://www.oas.org/juridico/mla/en/can/en_can_loi_mla.html) Эрх зүйн харилцан туслалцааны тухай хуулийн жишээ

STAR, АТГ-аас санаачилсан ХЗЯ, УЕП-ын хамтарсан тушаалаар батлагдах Эрүүгийн хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа хүсэх тухай гарын авлагын төсөл-с иш татав.

<http://www.legalinfo.mn/law/details/1165?lawid=1165>, Консулын харилцааны тухай Венийн конвенц, 1967 он

\*5(j) Олон улсын хүчин төгөлдөр гэрээний дагуу, хэрэв тийм гэрээгүй бол хүлээн авагч улсын хууль, журамд үл харшлах аливаа өөр журмаар шүүхийн болон шүүхийн бус бичиг баримт дамжуулах, томилогч улсын шүүхийн даалгавар буюу шүүхэд зориулан мэдүүлэг авах даалгавар гүйцэтгэх

маш том түлхэц болно. Үүний зэрэгцээ буцаагдах хөрөнгийн үнэлгээний зардал, шинжээчийн зардлыг холбогдох хууль тогтоомжид маш тодорхой тусгаж, хуулийн байгууллагын төсөвт суулгах ажлыг санаачлах, батлуулах;

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт түгээгдсэн байвал зохихэрх зүйн туслалцаа, даалгавар, хүсэлт бичих тухай гарын авлага, хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын олон талт болон хоёр талт гэрээ, байгууллага хоорондын олон улсын гэрээ хэлэлцээрийн жагсаалт, эрх зүйн гадаад улсуудын туслалцаа үзүүлэх тухайхууль тогтоомжийг албан ёсоор орчуулсан эмхэтгэл байхгүй, байгаа нэг нь хэдийн цаг үеийн шаардлагаас алсарсан байгааг анхаарна уу.

Судалгаа, үнэлгээний ажлын хүрээнд Гадаад харилцааны яам, Хууль Зүйн Яам, АТГ, УЕПГ, УДШ-ийн цахим хуудастшинжилгээ хийхэдэрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээрт хамаарах мэдээлэл нь заримд нь байхгүй, байгаа гэгдэх нэг нь жагсаалт гаргасан төдий байна.

Өөрөөр хэлбэл дээрх байгууллагуудын цахим хуудас нь Монгол Улсын эрх зүйн харилцан туслалцааны чиг баримжаа тогтоох мэдээлэлгүй, олон улсад төдийгүй өөрийн орны хэмжээнд “хэрэглээний өгөөжгүй” байна.

Иймд дээрх байгууллагууд цахим хуудастаа Монгол Улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалтын тухай нэн ойлгомжтой, энгийн бичвэр бүхий мэдээллүүд, нэгдэн орсон болон байгуулсан олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг нэг дор байршуулах хэрэгтэй байна. Түүнчлэн эрх зүйн туслалцаа, түүнийг хэрэглэх эрх зүйн чиг баримжаа олгох сургалт-танин мэдэхүйн мэдээ мэдээлэл оруулах нь оновчтой. Үүнийг цахим хуудас хооронд холбоо хэсгээр дамжин орж мэдээлэл авах боломжтой гэж тайлбар шидэхгүйгээр бусад улс орны туршлагаар эрх зүйн туслалцааны харилцаанд оролцогч төрийн байгууллагуудын цахим хуудас бүрт оруулна уу.

Судалгаа, ярилцлагад хамрагдсан оролцогч талуудаас Хууль зүйн, Гадаад хэргийн яамдаас аль нэг улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан эсэх, байгуулсан бол эх хувис хуулбар хувь үйлдэн хүргүүлэхийг хүссэн албан тоот цөөнгүй удаа явуулсан байсан байна.

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарт албан ёсны эрх бүхий байгууллагаас хэвлэсэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийг үйл ажиллагаандаа хэрэглэх ном, гарын авлага байхгүй, энэ сэдвээр сургалт зохион байгуулагдсан тохиолдол байхгүй байна.

Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор зэрэг байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг албан хаагчдыг хөрөнгө буцаахтай холбоотой даалгавар, хүсэлт бичих, оролцогч улсын ижил төрлийн хуулийн байгууллагуудтай мэдээлэл

солилцох, лавлагаа авах зэрэг бүхий л асуудлыг хамруулан шат дараалсан, давтамжтай сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож байх (жич: кейс сургалтын хэлбэрийг ашиглах) асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Зарим улсууд “Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль”-ийг тусгайлан баталсан байна. Ийнхүү бие даасан эрх зүйн туслалцаа үзүүлэх хуультай улсуудад даалгавар, хүсэлт илгээхийн өмнө тэрхүү улсын хуулийн шаардлагыг судлах хэрэгтэй. Үүний зэрэгцээ “Эрх зүйн харилцан туслалцааны тухай Монгол Улсын хууль”-ийн төсөл боловсруулан ажлыг нэн даруй эхлүүлэх нь зүйтэй.

Канад Улс, БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Гонконг, Шведийн Вантулс зэрэг улс орнууд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай бие даасан хууль батлан гаргаад байгааг судалгааны ажлын явцад тогтоолоо.

Дөрөв: Дипломат шугамаар гэрээ хэлэлцээрийн бус аргаар “даалгавар, хүсэлт”-ийг тавьж болох бөгөөд “Хүсэлт тавих захидал” (Letter Rogatory) гэж нэрлэдэг. “Консулын харилцааны тухай Венийн Конвенц”-ийн 5 дугаар зүйлийн (j) -д зааснаар энэ үүргийг тухайн оролцогч улсад Монгол Улсын төлөөлөн сууж байгаа консул хамааран ажиллах үүрэг хүлээсэн байна.

Судалгаа, үнэлгээг хийх ажлын хүрээнд хамтран ажилласан оролцогч талуудын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтаар консулын ажилтнууд нь “Консулын харилцааны тухай Венийн Конвенц”-ийг хэрэгжүүлэх, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагатай нягт хамтран ажиллах байдал маш муу хуулийн байгуулагуудаас илгээсэн даалгавар, хүсэлтийг дамжуулах, хариуг шаардах үүргийн биелэлт хангалтгүй, зарим тохиолдолд үл тоомсорлох нь байдаг тухай мэдээлэл өгөгдсөн. Үүнийг талууд хичээнгүйлэн анхаарч ажиллана уу.

Гэхдээ “Консулын харилцааны тухай Венийн Конвенц”-ийн хэрэгжилтийн хүрээнд авсан баримт, материал нь шүүн таслах ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байх магадлалтай байна.

Үүнийг Олон улсын гэрээний тухай хууль ба ЭБШХ-ийн хянан нийцүүлэлт хийн шийдвэрлэх хэрэгтэй.

Гадаад улсад томилогдон очсон Консулын ажилтан, албан тушаалтны үүрэг хариуцлага, олон улсын гэрээ хэлэлцээр болон өөрийн орны хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулснаар гадаад улсад тавьсан хүсэлт, даалгаврын чанар үр дүн, богино хугацаанд зөв шийдвэрлүүлэх, бусад холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авах боломжтой. Иймд энэ тухай Гадаад харилцааны яамтай хамтран шийдвэрлэх Монгол Улсын иргэд олноор амьдардаг зарим улс оронтой гэрээ хэлэлцээр байгуулах, Элчин сайдын яам, Консултай болгох, хуучин гэрээнүүдийг шинэчлэн боловсруулах талаар Гадаад харилцааны яамтай хамтран шийдвэрлэх. Эдгээр улсуудын тоонд дараах улсуудыг дурдаж байна. Үүнд: Бельгийн Вант Улс, ХБНГУ, БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Гонконг улс, Бүгд Найрамдах Сингапур улс, БНСАУ, Швейцарийн

Холбооны Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Турк улс , Малайзын Холбооны улс зэрэг болно.

Тав: АЭК-ийн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжид боломжит бүхий л хэлбэрээр тусган, хамтран ажиллахаас гадна нэмэлт протокол байгуулах нь ижил төрлийн хуулийн байгууллагууд өөр хоорондоо авлигын гэмт хэргийн талаар цаг алдалгүй мэдээлэл солилцох, лавлагаа авах болон хүсэлт илгээх, мэдээлэл дамжуулах боломжийг илүү нэмэгдүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэргээс олсон орлогыг таньж тогтоох, хөрөнгө буцаах, битүүмжлэх зэрэг байцаан шийтгэх ажиллагааг үр дүнтэй болгох ач холбогдолтой болно.

АЭК нь оролцогч улсууд эрүүгийн хэргийн асуудлаар хамтран ажиллахаар хязгаарлалгүй зохих тохиолдолд дотоодын эрх зүйн тогтолцоотой нь нийцсэн бол авлигатай холбогдсон мөрдөн байцаалт, иргэний ба захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бие биедээ туслалцаа үзүүлэхийг техник арга зүйн удирдамжид зөвшөөрсөн.

АТГ нь StAR хөтөлбөртэй харилцах байгууллагаар бүртгүүлэн StAR Интерполын хамтарсан “Global Focal point” гэх сүлжээг Монгол дахь Интерполын төвтэй хамтран байгуулж, шууд мэдээлэл солилцох болсныг дахин тэмдэглэе.

НҮБ-аас батлан гаргасан хүний эрх, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбар, дипломат, консулын эрх зүй, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Монгол улсын нэгдэн орсон конвенц, протоколоос гадна тухайн хүсэлт хүлээн авагч орны эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиуд монгол хэл дээрээ прокурор, мөрдөн байцаагч нарт нэн тэргүүнд шаардлагатай байна.



## НАЙМ. ДҮГНЭЛТ

Монгол улсын 2009 оны 2-р сарын 2-ны өдөр Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн өөрийн үнэлгээний тайланд тусгагдсан дүгнэлтийг манай багийн хийсэн харьцуулсан шинжилгээний /gap analysis/ үр дүнтэй харьцуулсан хүснэгтийг бэлдлээ.

Зүйл, заалт	АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ 2009				АВЛИГЫН ЭСРЭГ НҮБ-ЫН КОНВЕНЦИЙН V-P БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ СУДЛАХ ЗӨВЛӨГӨӨ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ 2014			
	Yes	Yes, in part	No	Info not available	Yes	Yes, in part	No	Info not available
	Тийм, хэрэгжүүлсэн	Тийм, хэрэгжүүлсэн, гэвч шаардлагын хэмжээн д хүрээгүй	Үгүй, огт хэрэгжүүлээгүй	Мэдээлэл олдоогүй	Тийм, хэрэгжүүлсэн	Тийм, хэрэгжүүлсэн гэвч шаардлагын хэмжээнд хүрээгүй	Үгүй, огт хэрэгжүүлээгүй	Мэдээлэл олдоогүй
52.1		X				X		
52.2a		X				X		
52.2b	X					X		
52.3		X				X		
52.4			X			X		
52.5		X				X		
52.6			X			X		
53.a	X					X		
53.b			X			X		
53.c	X							
54.1.a	X					X		

54.1.b	X					X		
54.1.c	X					X		
54.2.a	X					X		
54.2.b	X					X		
54.2.c	X					X		
55.1	X					X		
55.1.a						X		
55.1.b						X		
55.2	X					X		
55.3*	X					X		
55.4						X		
55.5						X		
55.6						X		
55.7						X		
55.8						X		
55.9						X		
56						X		
57.1	X					X		
57.2			X			X		
57.3*			X				X	
57.4	X				X			
57.5			X			X		
58					X			
59						X		

## ЕС. ЗӨВЛӨМЖ

### 9.1 Бодлогын түвшинд авах арга хэмжээний талаарх зөвлөмж

Хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар:

№	ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН НЭР	АВАХ АРГА ХЭМЖЭЭ
1	Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон улс хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр байгуулагдсан гэрээ, хэлэлцээрүүд	1. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр тухайн эд хөрөнгийг хураан авсан тохиолдолд энэ ажиллагааг яаж хийх талаар нарийвчилсан зохицуулалтыг оруулах. Энэ чиглэлээр байгуулагдсан гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжийн шинэчлэлт, гэрээгүй улс орнуудтай шинээр нэмж гэрээ байгуулахтай холбогдсон чиг үүргийг Хууль зүйн яам, Гадаад хэргийн яамд хүлээлгэх;
		2. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд хөрөнгө буцаан олгох ажиллагаатай холбоотойгоор нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг хохирогч улсад мэдээлэх үүргийг баталгаажуулах;
		3. битүүмжилсэн эд хөрөнгийг хадгалах үүрэг хүлээж байгаа субъект нь ямар шаардлагыг хангасан субъект байх талаар нарийвчилсан зохицуулалт оруулах;
		4. Эрх зүйн харилцан туслалцааны хүрээнд авч хэрэгжүүлэх нарийн процессыг дэлгэрэнгүй тусгасан нэмэлт өөрчлөлт оруулах

2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд	<p>1. Монгол улсын хувьд гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн авсан тохиолдолд уг шийдвэрийг биелүүлэх эсэхийг шийдвэрлэх субъект хэн байх, ямар процедураар энэ шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа нь явагдах талаар зохицуулсан журам гаргах;</p> <p>2. Гадаад улсын шүүхийн шийдвэр биелүүлэх эсэх, биелүүлэх бол хэрхэн биелүүлэх талаар зохицуулалт оруулах;</p>
3	Улсын Дээд шүүхийн тогтоолыг өөрчлөх	<p>1. Тухайн улстай гэрээ байгуулаагүй, байгуулагдсан ч шүүхийн шийдвэрийг биелүүлэх асуудал нь Монгол улсын шүүхэд хамааралгүй гэж үзэж байгаа нь АЭК-ийн 54, 55 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэхгүй байх тул УДШ-ийн тогтоолыг өөрчлөх</p>
4	Шинээр гэрээ хэлэлцээр байгуулах	<p>1. Оролцогч улсуудын даалгавар, хүсэлт буцаах үндэслэлийг аль болох боломжит хэлбэрээр багасгасан гэрээ, хэлэлцээр болон нэмэлт протокол, санамж бичиг байгуулах;</p>
5	“Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”	<p>1. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ тусгай стандарт” АЭК-ийн нэр томъёо, зохицуулалттай нийцүүлэн уг хуулийг шинэчлэн найруулах;</p> <p>2. Уг хуульд гадаад улсын харъяат болон харъяалалгүй хүнд данс нээх эсэх тухай эрх зүйн зохицуулалт оруулах, данс хаах, битүүмжлэх тохиолдлыг тодорхой болгох;</p>

6	“Гэмт хэргийн тухай хууль”-ийн төсөл	<ol style="list-style-type: none"> <li>1. Хууль бусаар хөрөнгөжих, мөнгө угаах төрлийн гэмт хэргүүдэд хөрөнгө хураах ялыг ногдуулах асуудлыг оруулах.</li> <li>2. Мөн хуулийн этгээд нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд түүний эрх бүхий албан тушаалтанд ял шийтгэл ногдуулах зохицуулалтыг оруулах;</li> <li>3. Бусдын “нэрийг өөрийн ашиг сонирхлын төлөө ашигласан этгээд”-д хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг оруулах;</li> </ol>
7	“Зөрчлийн тухай хууль”-ийн төсөл	<ol style="list-style-type: none"> <li>1. бусдын “нэрийг өөрийн ашиг сонирхлын төлөө ашигласан этгээд”-д хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг оруулах;</li> </ol>
8	Шинээр хуулийн төсөл боловсруулж, батлуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. “Эрх зүйн харилцан туслалцааны хууль”-ийг боловсруулан хууль тогтоох байгууллагаар батлуулах;</li> </ol>
9	Монгол Улсын иргэд олноор амьдардаг зарим улс оронтой гэрээ хэлэлцээр байгуулах, Элчин сайдын яам, Консултай болгох, хуучин гэрээнүүдийг шинэчлэн боловсруулах	<ol style="list-style-type: none"> <li>1. (Үүнд: Бельги, Герман, Хонгконг, Сингапур, Өмнөд Солонгос, Швейцарь, Филиппин, Турк, Малайз зэрэг)</li> </ol>
10	Монголбанкны Ерөнхийлөгч, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллага болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад өгөх журам”	<ol style="list-style-type: none"> <li>1. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж, нэн даруй батлах</li> </ol>

## 9.2 Үйл ажиллагааны түвшинд авах арга хэмжээний талаарх зөвлөмж

Хөрөнгө буцаан олгох ажиллагаатай холбоотой бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарийг үр дүнтэй, шуурхай болгох талаар авах арга хэмжээ:

№	АВАХ АРГА ХЭМЖЭЭ	ЗӨВЛӨМЖ, САНАЛ
1	Хөрөнгө буцаан олгох Байцаан шийтгэх ажиллагааны зардлыг шийдвэрлэх	11. Дотоодын хууль тогтоомжид Олон улсын гэрээ, хэлэлцээр, гарын авлага, оролцогч улсуудын хууль тогтоомжийн орчуулга, түүний чанарт тавих хяналт орчуулгын зардлын асуудлыг маш тодорхой болгон холбогдох хуулийн байгууллагын жилийн төсөвт орчуулгын зардал нэрээр суулган батлуулах. 2. Мөн буцаагдах хөрөнгийн үнэлгээний зардал, шинжээчийн зардлыг холбогдох хууль тогтоомжид маш тодорхой тусгаж, хуулийн байгууллагын төсөвт суулгах ажлыг санаачлах, батлуулах
2	Хөрөнгө буцаан олгох чиглэлээр ажилладаг төв байгууллагыг тодорхой болгох, хамтран ажилладаг байгууллагуудын ажлын уялдаа холбоо, бүтцийг сайжруулах	1. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй дотоодын хуулийн байгууллагууд тэр дундаа Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, Прокурор, Шүүхийн байгууллагатай харилцан хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо, бүтцийг сайжруулах чиглэлээр анхаарч ажиллах
3	Мэдээлэл солилцох албан болон албан бус сувгуудад нэгдэх ажлыг түргэвчлэх ажлыг анхаарах	1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар тодорхой мэдээллийг албан болон албан бусаар олж авах арга замуудыг бүрэн ашиглах, нэмж ижил төрлийн байгууллага хоорондын сувгуудыг нээх, нэгдэх орох
4	Мэдээлэх үүрэг бүхий этгээдээр зарим санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг нэмж тодорхойлох	1. ФАТФ-ын зөвлөмжийг баримтлан үнэт эдлэл, эртний эдлэлийн худалдаа эрхлэгч хувь хүн, хуулийн этгээд, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ буюу ломбард, 2. үнэт цаасны зах зээлд оролцогч, 3. хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрыг мэдээлэх үүрэгтэй этгээдээр тодорхойлж, СМА-д илгээх мэдээллийн төрөл, мэдээлэл илгээх сувгийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох; 4. Үнэт эдлэлийн, эртний эдлэлийн, авто гэх мэтээр төрөлжсөн ломбардуудын хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг сайжруулах

5	“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 22 дугаар зүйлд заасан “Хамтын ажиллагааны зөвлөл”-ийг байгуулах	1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж гаргах ажлыг системтэйгээр зохион байгуулах
6	Санхүүгийн мэдээллийн албыг Санхүүгийн тагнуулын алба болгон Төв банкны бүтцээс гаргах	1. Мөнгө угаалтын өсөлт, энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн шалгах тогтолцоог боловсронгуй болгох, улмаар үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс СМА-ны бүтэц, нэрний асуудлыг авч үзэж, шийдвэрлэх, чиг үүргийг өргөжүүлэх
7	Мэдээллийн гэрээ байгуулах	1. СМА ба АТГ нь хамтран төрийн бусад байгууллагуудаас зайлшгүй илгээх мэдээллийн гэрээг байгуулах;
8	Зарим мэдээлэх үүрэг бүхий этгээдээс мэдээлэл цуглуулах харилцаа Санхүүгийн зохицуулах хороогоор дамждаг хэдий ч мэдээлэх үүрэг бүхий этгээдээс мэдээлэл мэдээлэгдэх харилцаа хуульд заасан шаардлагыг хангахгүй байгаад дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг авах	1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатчаас мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг даруй батлан гаргах
9	“Өндөр дүнтэй данс” гэж үзэх мөнгөн хөрөнгийн доод хэмжээг тогтоох төрийн байгууллагыг нэрлэх	
10	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, нотариатчаас мэдээлэх үүргээ хэрэгжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг батлан гаргах;	
11	Аж ахуйн нэгжийн бенефициар өмчлөгч болон үл хөдлөх эд хөрөнгийн тооллого, хөрөнгийн болоод хуулийн этгээдийн өмчлөгчийн хөдлөлийн тайланд судалгаа хийх	1. анхаарал татахуйц мэдээллийг 6 сар тутам СМА, АТГ-д мэдээлэх үүргийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар гэрээгээр хүлээлгэн өгөх;

12	Аливаа этгээдийн зарим албан тушаалд нэр дэвших, сонгогдох үедээ хувийн болон санхүүгийн мэдээллийг хянах, ил болгохыг зөвшөөрөх механизмыг бий болгох	1. Аливаа этгээд нь УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгүүлэх, төрийн улс төрийн, захиргааны, тусгай алба, Авилгын эсрэг хуулийн 4.1 дэх заалтад заасан ажил, албан тушаал хашихаар нэр дэвших, хүсэлт гаргах үедээ Сонгуулийн ерөнхий хороо, төрийн албанд томилох эрх бүхий этгээдэд өөрийн гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой хамтрагч этгээдийн тухай мэдээллийг өгөх, тэднээс данс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй данс, эсхүл тэдний нэрийн өмнөөс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт тавих болохыг хүлээн зөвшөөрсөн батламжийг авах зохицуулалттай болох;
13	АТГ ныхөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахдаа нэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх, программ хангамжтай болох, түүнийг боловсронгуй болгох	
14	Гадаад улсад томилогдон очсон Консулын ажилтан, албан тушаалтны үүрэг хариуцлага, олон улсын гэрээ хэлэлцээр болон өөрийн орны хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулах	1. Гадаад улсад томилогдон очсон Консулын ажилтан, албан тушаалтны үүрэг хариуцлага, олон улсын гэрээ хэлэлцээр болон өөрийн орны хууль тогтоомжийн мэдлэгийг сайжруулснаар оролцогч улсад тавьсан хүсэлт, даалгаврын чанар үр дүн, богино хугацаанд зөв шийдвэрлүүлэх, 2. бусад холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авах боломжтой болгохын тулд Гадаад харилцааны яаманд асуудал тавих

### 9.3. Дотоодын чадавхийг бэхжүүлэх талаарх зөвлөмж:

№	АВАХ АРГА ХЭМЖЭЭ
1	Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор зэрэг байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг албан хаагчдын АЭК-ийн V бүлгийн хөрөнгө буцаахтай холбоотой даалгавар, хүсэлт бичих, оролцогч улсын ижил төрлийн хуулийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, лавлагаа авах зэрэг бүхий л асуудлыг хамруулан шат дараалсан, давтамжтай сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож байх (жич: кейс сургалтын хэлбэрийг ашиглах);
2	Дотоодын хууль тогтоомжийн нэр томъёо, хэллэгийг (төрийн албан тушаалтан, улс төрд өртөмтгий албан тушаалтан, мөнгө угаах, хээл хахууль) НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн хэллэгт нийцүүлэх, ингэснээр харилцагч бусад улс орнууд, олон улсын хөгжлийн агентлагуудтай илүү сайн ойлголцох боломжтой болно;



3	Нэгдсэн Үндэсний Байгууллагаас батлан гаргасан хүний эрх, олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах салбар, дипломат, консулын эрх зүй, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Монгол улсын нэгдэн орсон конвенц, протоколоос гадна тухайн хүсэлт хүлээн авагч орны эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиуд монгол хэлрүү орчуулах, эмхтгэл гаргах;
4	Хөрөнгө буцаан олгох ажиллагааны Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх үүднээс Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт гаргах, хянах, бүртгэх асуудлыг хариуцах төв байгууллагыг тодорхой болгох;
5	Гадаад улсуудтай харилцах асуудлыг эрчимжүүлэх үүднээс УПЕГ-ын сургалтын төвийн орон тоог нэмэгдүүлж албан ёсны мэргэжлийн орчуулагчид ажиллуулах боломжоор хангах;
6	Дэлхийн хамгийн том санхүүгийн зах зээлтэй 20 улс оронтой яаралтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах
7	Иргэдээс мэдээлэл хүлээж авах суваг, мэдээллийг хуваарилах систем, мэдээллийн хамгаалалт, нууцлал, бүртгэл хийх системийг сайжруулах, Иргэдээс ирсэн гомдол, мэдээлэл алдагдахгүй байх арга хэмжээ авах (утасны аппаратыг автомат хураагчтай холбох гм)

#### 9.4. Монгол Улс өөрийн үнэлгээнд бэлтгэх ажлын тухай зөвлөмж

Үнэлгээг хийх шинжээчид тавигдах шаардлагын талаарх:

Үнэлгээний тайланг бэлдэх шинжээчид тавих шаардлагын талаар Транспарэнси Интернэшнл байгууллагаас Авлигын эсрэг Конвенцийн оролцогч улсаас хийсэн өөрийн үнэлгээний зэрэгцүүлсэн /parallel/ үнэлгээ хийх төрийн бус байгууллагад зориулсан зөвлөмжийг үндэс болгон өөрсдийн саналыг нэмж орууллаа.

Үнэлгээний тайланг бэлдэх шинжээч нь дараах шаардлагыг хангавал зохино:

• Тухайн орны эрүүгийн хууль болон эрүүгийн практикийн талаарх мэдлэгтэй байх. Шинжээч нь хууль эрх зүйн салбарт ажиллаж байгаа, эсвэл ажиллаж байсан туршлагатай, багш, эрдэм шинжилгээний ажилтан байвал зохино
• Судалгаа шинжилгээ хийх ур чадвартай
• Авлига, ил тод байдал, засаглалын асуудлын талаар мэдлэгтэй
• Англи хэлний мэдлэгтэй эсвэл НҮБ-ын албан ёсны зургаан хэл болох Англи, Орос, Франц, Испани, Хятад, Араб зэрэг аль нэгэн хэлний мэдлэгтэй байх, Учир нь АЭК-ийн үнэлгээний талаарх гаргасан зөвлөмж заавар нь ихэнх нь Монгол хэлэнд орчуулагдаагүй, орчуулсан цөөхөн хэдэн баримтын орчуулгын чанар нь шаардлага хангахгүй түвшинд хийгдсэн байна.

- V бүлгийн хэрэгжилтийг үнэлэх шинжээч нарын багт банкны салбарын туршлагатай хүмүүс байвал зохино. Учир нь хөрөнгө буцаан олгох үйл ажиллагааны томоохон хэсэг нь мөнгө угаах үйл ажиллагаатай холбоотой байна.

Үнэлгээг хийх хугацаа:

Үнэлгээний хугацааг АЭК-ийн өөрийн үнэлгээний удирдамжид нийт үнэлгээнд 6 сар гаруй хугацаанд хийхээр заасан байна. Үүнээс өөрийн үнэлгээг 2 сарын хугацаанд хийхээр заасан байна. Үнэлгээ хийх хугацааг ийнхүү хангалттай байдлаар олгосноор үнэлгээний ажил чанартай түвшинд хийгдэх болно. Манай багийн хувьд үнэлгээний ажлыг хийхэд учирсан хамгийн том бэрхшээл нь давчуу цаг хугацаа байлаа. Цаг хугацаанд хязгаарлагдмал /29 ажлын өдөр /байсан тул зарим төлөвлөсөн уулзалтыг хийж амжихгүй, судлах материалыг бүрэн судлах боломж гарахгүй зэрэг бэрхшээл гарч байсан.

Үнэлгээ хийх үед ашиглах баримт материал:

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар болон СТАР санаачлагаас АЭК-ийн хэрэгжилтийг үнэлэх талаар хангалттай баримт материал, гарын авлага, судалгааг гаргасан байна. Бид өөрсдийн ашигласан материалын жагсаалтыг тайландаа хавсаргасан.

Үнэлгээ хийх материалын талаарх:

1. Үнэлгээ хийхэд нэн шаардлагатай зарим материалыг орчуулах. Үүнд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хууль эрх зүйн удирдамж, СТАР хөтөлбөрөөс боловсруулсан гарын авлага, судалгаа / Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд учирч буй бэрхшээлийн тухай судалгаа /зэргийг. Зарим орчуулсан материалыг эргэн хянаж орчуулгыг сайжруулах

2. АТГ-аас хөрөнгө буцаан олгох үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлготтой болгох, үнэлгээ хийх ажлыг бэлдэх зорилгоор V бүлгийн талаар соён гэгээрүүлэх ажлыг системтэйгээр зохион байгуулах. Хөрөнгө буцаан олголтын зохицуулсан журам процедур дутуу, энэ ажлыг хариуцан хийх чиг үүрэг бүхий албан тушаалтны ойлголт дутуу байна.

3. НҮБ-ын МБГХТГ-аас боловсруулсан TRACK “Tools and Resources for Anti-Corruption Knowledge” буюу Авлигын эсрэг Мэдээллийн нөөц, хэрэгсэл бүхий цахим хуудасны Эрх зүйн орчин /Legal library/ булангийн Legal resources for Mongolia хэсэгт Монгол улсын мэдээллийг шинэчлэх шаардлагатай байна. Жич СМА-гийн үйл ажиллагааны 2010 оны тайлан, хүчингүй болсон хуулийн орчуулга, үүнд 1999 оны Компанийн тухай хууль, 2002 оны Банкны тухай хууль, 2006 оны Мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хууль зэрэг нь энэ цахим хуудсанд байна. Ийнхүү хуучирсан мэдээлэл, хүчингүй хуулийг МБГХТГ-аас боловсруулсан цахим хуудсанд байршуулах нь манай орны үнэлгээг хийх шинжээч нарт буруу мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх, шинэчлэгдсэн

<http://www.track.unodc.org/LegalLibrary/pages/LegalResources.aspx?country=mongolia>

мэдээллийг олох дахин мэдээлэл эрсдэлтэй байна.

Оролцогч талуудын уулзалт зөвлөгөөн зохион байгуулах:

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн үнэлгээний механизмыг “ил тод, үр дүнтэй, оролцоог хангасан, хараат бус” байхаар заажээ. Оролцоог хангах зорилгоор үнэлгээ хийх явцад төрийн байгууллагын төлөөлөгчдөөс гадна хувийн хэвшэл, иргэд, бусад бүлгийн төлөөлөгчидтэй уулзаж зөвлөлдөхийг чухалчилжээ.

Иймд үнэлгээний ажлын эхэнд болон үнэлгээний тайлангийн төслийг танилцуулах уулзалт зохион байгуулах, үнэлгээ хийх явцад оролцогч талуудтай ганцаарчилсан уулзалтаар санал солилцож зөвлөлдөх нь үнэлгээний үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

АРАВ. ХАВСРАЛТУУД  
Хавсралт I. ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын хууль

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /2013 /  
<http://www.legalinfo.mn/law/details/9242?lawid=9242>
2. Банкны тухай /2010/  
<http://www.legalinfo.mn/law/details/108?lawid=108>
3. Авилгын эсрэг НҮБ-ын Конвенцийг соёрхон батлах тухай /2005/  
<http://www.legalinfo.mn/law/details/10269?lawid=10269>
4. Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай /1995 / <http://www.legalinfo.mn/law/details/106?lawid=106>
5. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай /2001 /  
<http://www.legalinfo.mn/law/details/34?lawid=34>
6. Улсын бүртгэлийн ерөнхий хууль /2009/  
<http://www.legalinfo.mn/law/details/511?lawid=511>
7. Эрүүгийн хууль /2002/  
<http://www.legalinfo.mn/law/details/50?lawid=50>
8. Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002/  
<http://www.legalinfo.mn/law/details/59?lawid=59>
9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /2002/  
<http://www.legalinfo.mn/law/details/302?lawid=302>
10. Компанийн тухай /2011/  
<http://www.legalinfo.mn/law/details/310?lawid=310>
11. Үндэсний Аюулгүй байдлын тухай /2001/  
<http://www.legalinfo.mn/law/details/18?lawid=18>
12. Үнэт цаасны зах зээлийн тухай /2013/  
<http://www.legalinfo.mn/law/details/9243?lawid=9243>
13. Хадгаламж зээлийн хоршооны тухай /2011/

<http://www.legalinfo.mn/law/details/8772?lawid=8772>

14. Гэрч хохирогчийг хамгаалах тухай /2013/  
<http://www.legalinfo.mn/law/details/9287?lawid=9287>

15. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /2012/  
<http://www.legalinfo.mn/law/details/397?lawid=397>

Монгол Улсын олон улсын гэрээ

16. United Nations Convention against corruption /2005/\_ Англи хэл дээрх эх текст  
[http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026\\_E.pdf](http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf)

17. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц /2005/\_Монгол хэл дээрх албан бус орчуулга  
[http://www.iaac.mn/pdf/avligiin\\_esreg\\_konvents.pdf](http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf)

18. United Nations Convention against Transnational Organized Crime (2000)\_Англи хэл дээрх эх текст

<http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TO-Cebook-e.pdf>

19. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц/2000/\_Монгол хэл дээрх албан бус орчуулга  
Төрийн мэдээлэл, хуудас 910-923, №17 /734/, 2012 он

20. Консулын харилцааны тухай Венийн конвенц /1963/  
[www.legalinfo.mn/law/details/1165?lawid=1165](http://www.legalinfo.mn/law/details/1165?lawid=1165)

Зохицуулагч байгууллагуудын журам

21. Банкны зөвшөөрлийн журам /2012/  
[http://www.mongolbank.mn/documents/regulation/control\\_check/20120612\\_banknii\\_zuvshuurliin\\_juram.pdf](http://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20120612_banknii_zuvshuurliin_juram.pdf)

22. Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам /2007/  
<http://www.mongolbank.mn/listCMA.aspx?did=1>

23. Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам/2009/

<http://frc.gov.mn/index.php/2013-05-22-01-24-57/2013-05-22-01-28-33/2013-05-23-03-16-07>

24. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж

мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам /2011/  
[http://www.frc.gov.mn/index.php/joomlart/2013-03-25-02-46-40/cat\\_view/5-/6-?start=30](http://www.frc.gov.mn/index.php/joomlart/2013-03-25-02-46-40/cat_view/5-/6-?start=30)  
НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын зөвлөмж

25. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн Техник арга зүйн удирдамж /2009/  
UNCAC Technical guide  
<https://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/technical-guide.html>

26. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн Хууль эрх зүйн удирдамж /2006/  
UNCAC Legislative guide  
<https://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/legislative-guide.html>  
НҮБХХ-ийн удирдамж

27. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн Өөрийн үнэлээний удирдамж /2010/  
UNCAC self assessments: Going beyond the minimum, UNDP  
[www.u4.no/recommended-reading/...uncac-self-assessments.../2023](http://www.u4.no/recommended-reading/...uncac-self-assessments.../2023)  
StAR санаачлагын гарын авлага, судалгаа

28. Хөрөнгө буцаан олгох үйл ажиллагаанд гарч буй бэрхшээл /2011/ Barriers to  
Asset Recovery. Kevin M. Stephenson, Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabriele  
Dunker, Melissa Panjer <http://star.worldbank.org/star/publication/barriers-asset-recovery>

29. Хөрөнгө буцаан олгох тухай гарын авлага /2011/  
Asset Recovery Handbook: A Guide for Practitioners. Jean-Pierre Brun, Clive Scott, Kevin M.  
Stephenson, Larissa Gray  
<http://star.worldbank.org/star/publication/asset-recovery-handbook>  
Монгол Улсын АЭК-ийн хэрэгжилтийн үнэлгээний үнэлгээний тайлангууд

30. Авлигын эсрэг Конвенцийн үнэлгээний механизмын туршилтын үеийн тайлан  
/2009/ Pilot Review Program: Mongolia  
[http://iaac.mn/pdf/tailan/Pilot\\_review\\_programme\\_Mongolia\\_Eng.pdf](http://iaac.mn/pdf/tailan/Pilot_review_programme_Mongolia_Eng.pdf)

31. Монгол Улсын явцын тайлан. ЭЗХАХБ /2013/  
OECD Anti-Corruption Network for Eastern Europe and Central Asia. Mongolia Progress Re-  
port <http://www.oecd.org/corruption/acn/ProgressUpdateMongoliaSept2013ENG.pdf>

32. Авлигын эсрэг Конвенцийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлан Монгол  
улс 2009  
[www.iaac.mn/pdf/tailan/Eng\\_Self\\_Assessment.pdf](http://www.iaac.mn/pdf/tailan/Eng_Self_Assessment.pdf)

Бусад

33. StAR Хулгайлагдсан хөрөнгийг буцаан олгох санаачлага болон Авлигатай  
тэмцэх газар хоорондын байгууллах Үзэл баримтлалын баримт бичгийн төсөл 2014  
оны 5-р сар

34. Монгол улсад Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн III, IV дүгээр бүлгийн зүйл

заалтуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй зарим асуудал, Улсын Дээд Шүүхийн судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн

35. Авлигын индексийн 2013 оны судалгааны үр дүнгийн тайлан, Авлигатай тэмцэх газар 2014 он

Ашигласан цахим хуудасны жагсаалт

1. <http://star.worldbank.org/>
2. <http://www.unodc.org/>
3. <http://www.iaac.mn>
4. <http://www.mongolbank.mn>
5. <http://prokuror.mn/>
6. <http://www.legalinfo.mn/>
7. <http://zasag.mn/>
8. <http://moj.gov.mn/>
9. [www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn)

Хавсралт II. 2014 оны 6-р сарын 27-ны өдөр Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн V бүлгийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан танилцуулах семинарт оролцогчдын нэрс

1	Г. Батчимэг	Гадаад харилцаан яам Гэрээ эрх зүйн газрын атташе
2	Д Эрдэнэцэцэг	УЕПГ Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор
3	У. Эрдэнэтуяа	Нийслэлийн прокурорын газар Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор
4	н.Төмөрбаатар	Тагнуулын ерөнхий газар Мөрдөн байцаах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч
5	Б. Бат-Отгон	Авилгатай тэмцэх газар Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар
6	С. Галбадрах	Авилгатай тэмцэх газар Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар
7	н.Заяахишиг	Татварын ерөнхий газрын дотоод хяналт ёс зүйн асуудал хариуцсан улсын байцаагч

8	н.Батгэрэл	Гаалийн ерөнхий газрын хяналт дүн шинжилгээ хариуцсан улсын байцаагч
9	н.Батцоож	Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газрын ахлах байцаагч
10	Т. Дуламсүрэн	Монголбанк Санхүүгийн мэдээллийн алба шинжээч
11	Б Мандахнаран	Монголбанк Санхүүгийн мэдээллийн албаны шинжээч

Хавсралт III. Авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын номын санд зориулж бэлтгэсэн зарим нийтлэл, судалгаануудын жагсаалт

1. Edited by Peter Reuter, 2012. "Draining Development? Controlling Flows of Illicit Funds from Developing Countries". Office of the Publisher, World Bank, 1818 H Street NW, Washington, DC 20433, USA; fax: 202-522-2422; e-mail: [pubrights@worldbank.org](mailto:pubrights@worldbank.org). <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/2242/668150PUB0EP-10067848B09780821388693.pdf?sequence=1>
2. Larissa Gray, Tim Steele, Nina Gidwaney; Ben Dickinson, Kjetil Hansen. 2011. "Tracking Anti-Corruption and Asset Recovery Commitments", StAR, OECD DAC. <http://star.worldbank.org/star/publication/tracking-anti-corruption-and-asset-recovery-commitments>
3. OECD Anti-Corruption Network for Eastern Europe and Central Asia (ACN) and the OECD-EU SIGMA Programme. 2011. Fighting Corruption in Eastern Europe and Central Asia: "Asset Declarations for Public Officials", A Tool To Prevent Corruption <http://www.oecd.org/daf/anti-bribery/47489446.pdf>
4. OECD/The World Bank (2012), Identification and Quantification of the Proceeds of Bribery: Revised edition, February 2012, OECD Publishing. <http://dx.doi.org/10.1787/9789264174801-en>
5. OECD, 2009. Money Laundering Awareness Handbook for Tax Examiners and Tax Auditors <http://www.oecd.org/tax/exchange-of-tax-information/43841099.pdf>
6. ADB/OECD, 2007. Mutual Legal Assistance, Extradition and Recovery of Proceeds of Corruption in Asia and the Pacific. <http://www.oecd.org/site/adboecdanti-corruptioninitiative/mutuallegalassistanceextradi->



tionandrecoveryofproceedsofcorruptioninasiaandthepacific.htm

7. International Co-operation against Tax Crimes and Other Financial Crimes, A Catalogue Of The Main Instruments. International Co-Operation Against Tax Crimes And Other Financial Crimes: A Catalogue Of The Main Instruments © OECD. 2012.  
<http://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/50559531.pdf>

8. Andrew Marshall. 2013. "What's Yours Is Mine: Asset Recovery in Global Corruption Cases." CGD Policy Paper 018. Washington DC: Center for Global Development.  
<http://www.cgdev.org/content/publication/whats-yours-is-mine>

9. FATF Recommendations  
[http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF\\_Recommendations.pdf](http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF_Recommendations.pdf)

10. FATF/OECD. October 2013. "Best Practices: The Use of the FATF Recommendations to Combat Corruption" <http://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/BPP-Use-of-FATF-Recs-Corruption.pdf>

11. FATF/OECD. June 2012. "Specific Risk Factors in Laundering the Proceeds of Corruption Assistance to Reporting Institutions".  
<http://www.fatfgafi.org/media/fatf/documents/reports/Specific%20Risk%20Factors%20in%20the%20Laundering%20of%20Proceeds%20of%20Corruption.pdf>

12. Basel Institute on Governance. 2013. The Basel AML Index 2013  
[http://index.baselgovernance.org/index/Project\\_Description.pdf](http://index.baselgovernance.org/index/Project_Description.pdf)

13. Basel Institute on Governance. 2013. Ranking of Basel AML Index (149 countries)  
<http://index.baselgovernance.org/index/Index.html#ranking>

14. Basel Institute on Governance. 2013. The Basel AML Index Expert Edition [http://index.baselgovernance.org/index/Expert\\_Edition\\_Brochure.pdf](http://index.baselgovernance.org/index/Expert_Edition_Brochure.pdf)

15. Pedro Gomes Pereira, Alessandra Fontana. (ICAR) 2012. Using Money Laundering Investigations to Fight Corruption in Developing Countries: Domestic obstacles and strategies to overcome them

16. Dev Kar, Brian LeBlanc, December 11, 2013. Illicit Financial Flows from Developing Countries: 2002-2011. Global Financial Integrity. 2013. [http://gfintegrity.org/wp-content/uploads/2014/05/Illicit\\_Financial\\_Flows\\_from\\_Developing\\_Countries\\_2002-2011-HighRes.pdf](http://gfintegrity.org/wp-content/uploads/2014/05/Illicit_Financial_Flows_from_Developing_Countries_2002-2011-HighRes.pdf)

17. ANNUAL REPORT 2012\_INTERPOL Интерполын 2012 оны тайланг:  
<http://www.interpol.int/News-and-media/Publications>
18. GRECO 2013. "Corruption prevention in respect of members of parliament, judges and prosecutors", Evaluation Report, Denmark. GRECO EVALIV REP (2013) 6EV E [http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/news/News\(20140416\)Eval4Denmark\\_en.asp](http://www.coe.int/t/dghl/monitoring/greco/news/News(20140416)Eval4Denmark_en.asp)
19. Egmont OpWG White Paper: "The Role of FIU's in Fighting Corruption and Recovering Stolen Assets". Egmont Group.  
<http://www.egmontgroup.org/library/egmont-documents>
20. WEF, 2011-2011 Term Report. "Money Laundering into Real Estate".  
[http://www3.weforum.org/docs/WEF\\_GAC\\_OrganizedCrime\\_Report\\_2010-11.pdf](http://www3.weforum.org/docs/WEF_GAC_OrganizedCrime_Report_2010-11.pdf)
21. Global Organization of Parliamentarians against Corruption (GOPAC), 2012. "Anti-Money laundering action Guide for Parliamentarians".  
<http://gopacnetwork.org/publications/>
22. Assessment of IMF's evaluations of the AML/CFT systems of 150 countries from 2004 to 2013, Center on Law and Globalization (American Bar Foundation). 2013.  
<http://star.worldbank.org/star/content/assessing-assessors-form-substance>
23. Tax Justice Network олон улсын иргэний нийгмийн байгууллага нь Financial Secrecy Index (FSI) судалгааг улс төрөөс хараат бус байх зарчмыг баримтлан 2009 оноос эхлэн явуулж эхэлжээ. Санхүүгийн системийн нууцлаг байдал, татварын хөнгөлөлттэй улс орнууд, газар нутаг болон хууль бус мөнгөний эх үүсвэрийн урсгал зэрэг ухагдахуунуудын талаар ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор уг индексийг боловсруулсан байна. 2011 оны судалгаандаа 73 улс орон хамруулсан бол 2013 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр нийтэлсэн судалгаандаа 82 улс орон, нутаг дэвсгэрийн санхүүгийн системийн нууцлаг байдлыг харуулсан байна. Уг судалгааны арга зүй, дүнгийн талаарх мэдээллийг дор буй линкүүдээр орж авна үү:
- Financial Secrecy Index, 2013  
<http://www.financialsecrecyindex.com/introduction/fsi-2013-results>
- <http://www.financialsecrecyindex.com/introduction/introduction>
24. Requesting Mutual Legal Assistance In Criminal Matters From G20 Countries a Step-By-Step Guide. 2012

25. Kevin M. Stephenson, Larissa Gray, Ric Power, Jean-Pierre Brun, Gabriele Dunker, Melissa Panjer. 2011. "Barriers to Asset Recovery". The International Bank for Reconstruction and Development / The World Bank/StAR

#### Хавсралт IV. Конвенцийн жагсаалт

№	Конвенцийн нэр, огноо Convention	Конвенцийн эх текст Links to the Convention
1	Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай Венийн конвенц /1971/ Convention on Psychotropic Substances (1971)	Англи хэл дээр: <a href="http://www.unodc.org/documents/commissions/Conventions/ebook/13-85380_Ebook_WEB.pdf">http://www.unodc.org/documents/commissions/Conventions/ebook/13-85380_Ebook_WEB.pdf</a>  НҮБ-ийн бусад хэл дээр (Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани): <a href="http://www.unodc.org/unodc/en/commissions/CND/conventions.html">http://www.unodc.org/unodc/en/commissions/CND/conventions.html</a>
2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц /1988/  United Nations Convention against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances (1988)	Англи хэл дээр: <a href="http://www.unodc.org/documents/commissions/Conventions/ebook/13-85380_Ebook_WEB.pdf">http://www.unodc.org/documents/commissions/Conventions/ebook/13-85380_Ebook_WEB.pdf</a>  НҮБ-ийн бусад хэл дээр: <a href="http://www.unodc.org/unodc/en/commissions/CND/conventions.html">http://www.unodc.org/unodc/en/commissions/CND/conventions.html</a>
3	Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц /1999/  International Convention for the Suppression of the Financing of Terrorism (1999)	Монгол: <a href="http://www.legalinfo.mn/law/details/1163?lawid=1163">http://www.legalinfo.mn/law/details/1163?lawid=1163</a>  Англи: <a href="http://www.pacii.org/vu/legis/consol_act/icfts-otfota769/">http://www.pacii.org/vu/legis/consol_act/icfts-otfota769/</a>

4	<p>Авилгын эсрэг НҮБ-ийн конвенц /2005/</p> <p>United Nations Convention against Corruption (2005)</p>	<p>Монгол:  <a href="http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf">http://www.iaac.mn/pdf/avligiin_esreg_konvents.pdf</a></p> <p>Англи:  <a href="http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf">http://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf</a></p> <p>НҮБ-ийн бусад хэл дээр:  <a href="http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/index.html?ref=menuaside">http://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/index.html?ref=menuaside</a></p>
5	<p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц /2000/</p> <p>United Nations Convention against Transnational Organized Crime (2000)</p>	<p>Монгол (конвенц, протоколууд):  Төрийн мэдээлэл, хуудас 910-923, №17 /734/, 2012 он</p> <p>Англи:  <a href="http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf">http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf</a></p> <p>НҮБ-ийн бусад хэл дээр:  <a href="http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menuaside#Fulltext">http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menuaside#Fulltext</a></p>
	<p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын эсрэг конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол /2000/</p>	<p>Монгол: Дээрхитэй адил</p> <p>Англи:  <a href="http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf">http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf</a></p>
	<p>Protocol to Prevent, Suppress and Punish Trafficking in Persons, Especially Women and Children, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime (2000)</p>	<p>НҮБ-ийн бусад хэл дээр:  <a href="http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menuaside#Fulltext">http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menuaside#Fulltext</a></p>

<p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын эсрэг конвенцийн нэмэлт болох шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол /2000/</p> <p>Protocol against the Smuggling of Migrants by Land, Sea and Air, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime (2000)</p>	<p>Монгол:Дээрхитэй адил</p> <p>Англи:  <a href="http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf">http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf</a></p> <p>НҮБ-ийн бусад хэл дээр:  <a href="http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menu#Fulltext">http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menu#Fulltext</a></p>
<p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын эсрэг конвенцийн нэмэлт болох галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, эд анги болон галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол /2000/</p> <p>Protocol against the Illicit Manufacturing and Trafficking in Firearms, Their Parts and Components and Ammunition, supplementing the United Nations Convention against Transnational Organized Crime (2000)</p>	<p>Монгол:Дээрхитэй адил</p> <p>Англи:  <a href="http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf">http://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf</a></p> <p>НҮБ-ийн бусад хэл дээр:  <a href="http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menu#Fulltext">http://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/index.html?ref=menu#Fulltext</a></p>

6	<p>Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенци (1970)</p> <p>Convention for the Suppression of Unlawful Seizure of Aircraft (1970)</p>	<p>Монгол:  <a href="http://www.legalinfo.mn/law/details/1157?law-id=1157">http://www.legalinfo.mn/law/details/1157?law-id=1157</a></p> <p>Англи: <a href="http://www.oas.org/juridico/MLA/en/Treaties/en_Conve_Suppre_Unlaw_Seiz_Aircr_Sig_The_Hague_1970.pdf">http://www.oas.org/juridico/MLA/en/Treaties/en_Conve_Suppre_Unlaw_Seiz_Aircr_Sig_The_Hague_1970.pdf</a></p>
7	<p>Иргэний нийсэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенци (1971)</p> <p>Convention for the Suppression of Unlawful Acts against Suppression of the Safety of Civil Aviation (1971)</p>	<p>Монгол:  <a href="http://www.legalinfo.mn/law/details/1158?law-id=1158">http://www.legalinfo.mn/law/details/1158?law-id=1158</a></p> <p>Англи:  <a href="https://treaties.un.org/doc/db/Terrorism/Conv3-english.pdf">https://treaties.un.org/doc/db/Terrorism/Conv3-english.pdf</a></p>
8	<p>Олонулсынхамгаалалтанд байдаг хүмүүс, түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенци (1973)</p> <p>Convention on Prevention and Punishment of Crimes against Internationally Protected Persons, including Diplomatic Agents (1973)</p>	<p>Монгол:  <a href="http://www.legalinfo.mn/law/details/1159?law-id=1159">http://www.legalinfo.mn/law/details/1159?law-id=1159</a></p> <p>Англи:  <a href="http://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_4_1973.pdf">http://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_4_1973.pdf</a></p>

9	Хүн барьцаалан авахын эсрэг конвенци (1979) Convention against the Taking of Hostages (1979)	Монгол: <a href="http://www.legalinfo.mn/law/details/1161?law-id=1161">http://www.legalinfo.mn/law/details/1161?law-id=1161</a>  Англи: <a href="http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv5.pdf">http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv5.pdf</a>
10	Protocol for the Suppression of Unlawful Acts of Violence at Airports Serving International Civil Aviation (1988)	Англи: <a href="http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv5.pdf">http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv5.pdf</a>
11	Convention on the Making of Plastic Explosives for the Purpose of Detection (1991)	Англи: <a href="https://treaties.un.org/doc/db/Terrorism/Conv10-english.pdf">https://treaties.un.org/doc/db/Terrorism/Conv10-english.pdf</a>
12	International Convention for the Suppression of Terrorist Bombings (1991)	Англи: <a href="http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv11.pdf">http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv11.pdf</a>
13	Convention for the Suppression of Unlawful Acts against the Safety of Maritime Navigation (1988)	Англи: <a href="http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv8.pdf">http://www.un.org/en/sc/ctc/docs/conventions/Conv8.pdf</a>
14	Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенци (1980) Convention on the Physical Protection of Nuclear Material (1980)	Монгол: <a href="http://www.legalinfo.mn/law/details/1160?law-id=1160">http://www.legalinfo.mn/law/details/1160?law-id=1160</a>  Англи: <a href="http://www.iaea.org/Publications/Documents/Inf-circs/Others/inf274r1.shtml">http://www.iaea.org/Publications/Documents/Inf-circs/Others/inf274r1.shtml</a>

V бүлэг

Хөрөнгө буцаан олгох

51 дүгээр зүйл

Ерөнхий зүйл

Энэ бүлгийн дагуу хөрөнгө буцаан өгөх нь энэхүү конвенцийн тулгуур зарчим мөн бөгөөд энэ талаар оролцогч улсууд бие биетэйгээ хамгийн өргөн хүрээнд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлнэ.

52 дугаар зүйл

Гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс  
урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх

1. Энэхүү конвенцийн 14 дүгээр зүйлийг үл хөндөн, оролцогч улс бүр хуулийнхарьяалалдаа багтах санхүүгийн байгууллагуудаасаа харилцагчийнхаа биеийн байцаалтыг нягталж байх, өндөр дүнтэй дансанд хадгалуулсан мөнгөн хөрөнгийн жинхэнэ эзэмшигч нь хэн болохыг тодорхойлох талаар боломжит арга хэмжээ авах, нийтийн чухал чиг үүрэг гүйцэтгэж байгаа буюу байсан хувь хүн, тэдний гэр бүлийн гишүүд болон ойр холбоотой хамтрагч этгээдийн нээхийг хүссэн буюу эзэмшиж буй данс, эсхүл тэдний нэрийн өмнөөс нээхийг хүссэн буюу эзэмшиж буй дансанд хатуу хяналт явуулахыг шаардахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн авна. Ийм хатуу хяналт нь сэжигтэй гүйлгээг эрх бүхий байгууллагад мэдээлэх зорилгоор илрүүлэхэд үндэслэлтэйгээр зориулагдсан байх бөгөөд ийм шалгалтыг санхүүгийн байгууллагыг хууль ёсны харилцагчтайгаа бизнесийн үйл ажиллагаа явуулахад саад болох буюу хориглох гэсэн утгаар тайлбарлаж болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хөнгөвчлөн дэмжихийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн, мөнгө угаахтай тэмцдэг бүс нутгийн, бүс хоорондын болон олон талт байгууллагуудын санаачлагыг удирдлага болгон:

(а) хуулийнхарьяалалд нь багтах санхүүгийн байгууллагаас дансанд нь хатуу хяналт явуулах ёстой хувь хүн, хуулийн этгээдийн төрөл, онцгой анхаарал хандуулах данс ба гүйлгээний төрөл, түүнчлэн тэдгээр данстай холбогдуулан данс нээх, эзэмших, бүртгэл хөтлөх талаарх зохих арга хэмжээний талаар сэрэмжлүүлэг заавар гаргаж;

(b) хуулийнхарьяалалд нь багтах санхүүгийн байгууллага өөр журмаар таньж тогтоох хувь хүн, хуулийн этгээдээс гаднаэдгээр санхүүгийн байгууллагаас хатуу хяналт явуулах ёстой тодорхой хувь хүн, хуулийн этгээдийн талаар эдгээр байгууллагад оролцогч өөр улсын хүсэлтээр эсхүл өөрийн санаачлагаар зохих тохиолдолд мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн хүрээнд, энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүст хамаарах данс, гүйлгээний зохистой бүртгэлийг санхүүгийн байгууллагууд нь зохих хугацаанд хөтөлж байх явдлыг хангах арга хэмжээг оролцогч улс бүр авч хэрэгжүүлэх бөгөөд энэ бүртгэлд наад зах нь харилцагчийн, мөн боломжтой бол жинхэнэ эзэмшигч нь хэн болох тухай мэдээллийг агуулбал зүйтэй.



4. Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, шилжүүлгийг илрүүлэх зорилгоор оролцогч улс бүр биетээр оршдоггүйбанк болон хуулиар зохицуулагддаг санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк байгуулахаас зохицуулагч ба хяналтын байгууллагуудынхаа тусламжтайгаар урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй бөгөөд зохистой арга хэмжээ авна. Түүнчлэн, оролцогч улсууд ийм байгууллагуудтай корреспондент банкны харилцаа тогтоох, тийм харилцаагаа үргэлжлүүлэхээс татгалзахыг, түүнчлэн биетээр оршдоггүй банк болон хуулиар зохицуулагддаг санхүүгийн бүлэгт харьяалагддаггүй банк дансыг нь хэрэглэхийг зөвшөөрч буй гадаадын санхүүгийн байгууллагуудтай харилцаа тогтоохын эсрэг хамгаалалалт бий болгохарга хэмжээ авахыгсанхүүгийн байгууллагуудаасаашаардах асуудлыг авч үзэж болно.

5. Оролцогч улс бүр зохих нийтийн албан тушаалтны санхүүгийн байдалтай холбогдсон мэдээллийг ил тод болгох үр дүнтэй тогтолцоогдотоодын хууль тогтоомжийнхоо дагуу бий болгох асуудлыг авч үзэх бөгөөд үл биелүүлэх тохиолдолд оногдуулбал зохих хариуцлагыг заана. Түүнчлэн энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг мөрдөн шалгах, шаардах, буцаан олгох шаардлагатай тохиолдолд дээрх мэдээллийг оролцогч бусад улсын эрх бүхий байгууллагуудтай солилцохыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр мөн авч үзнэ.

6. Гадаад улсад санхүүгийн дансанд хувь эзэмшдэг буюу гарын үсэг зурах эрхтэй буюу өөр эрх эдэлдэг зохих нийтийн албан тушаалтнаас уг харилцаагаа эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх ба уг данстай холбоотой зохих бүртгэл хөтөлж байхыг шаардах талаар дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр авч үзнэ. Үл биелүүлэх тохиолдолд оногдуулбал зохих хариуцлагыг эдгээр арга хэмжээнд мөн заана.

53 дугаар зүйл

Эд хөрөнгийг шууд буцаан олгох арга хэмжээ

Оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(a) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх буюу өмчлөлийг тогтоох зорилгоор өөрийн шүүхэд иргэний хэрэг үүсгэхийг оролцогч өөр улсад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(b) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдсэн этгээдээрүг гэмт хэргийн улмаас хохирсон оролцогч өөр улсад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх буюу арилгуулах шийдвэр гаргахыг өөрийн шүүхэд зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(с) энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч гэдгээ тогтоолгохтухай оролцогч өөр улсын шаардлагыг эд хөрөнгөхураах шийдвэр гаргах үедээ хүлээн зөвшөөрөхийг өөрийн шүүх буюу эрх бүхий байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна.

54 дүгээр зүйл

Эд хөрөнгө хураах асуудлаар олон улсын хэмжээнд хамтран ажиллах замаар эд хөрөнгийг буцаан олгох механизм

1. Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдэх замаар олж авсан буюу тийм гэмт хэрэгтэй холбоотой эд хөрөнгийнхувьд оролцогч улс бүр энэхүү конвенцийн 55 дугаар зүйлийн дагуу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(а) эд хөрөнгө хураах талаар оролцогч өөр улсын шүүхээс гаргасан шийдвэрийг биелүүлэхийг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(b) мөнгө угаах гэмт хэрэг буюу хуулийнхарьяалалд нь багтах бусад гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхдээ эсхүл дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу зөвшөөрөгдсөнбусаджурмыгхэрэгжүүлэхдээгадаадаасгаралтайэдхөрөнгийгхураах шийдвэр гаргахыг уг хэргийг харьяалан шийдвэрлэх эрх бүхий өөрийн байгууллагад зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(с) гэмт хэрэгтэн нас барсан, оргон зайлсан буюу байхгүй байгаа шалтгаанаар яллаж болохгүй буюу бусад зохих тохиолдолд эрүүгийн ял шийтгэлоногдуулахгүйгээртухайн эд хөрөнгийг хураахыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авах асуудлыг авч үзнэ.

2. Энэхүү конвенцийн 55 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гаргасан хүсэлтээр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийн тулд оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн:

(а) хүсэлт гаргагч оролцогч улсын шүүх буюу эрх бүхий байгууллагаас гаргасан эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураах шийдвэрийн дагуу өөрийн эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураахыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна,чингэхдээуг шийдвэрт ийм арга хэмжээ авах хангалттай үндэслэл байгаабөгөөд эцэст нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсгийн зорилгоор уг эд хөрөнгийн хувьд хураах шийдвэр гарна гэж хүсэлт хүлээн авагч оролцогч улс итгэх боломжит үндэслэлийг заасан байна;

(b) ийм арга хэмжээ авах хангалттай үндэслэл байгаа бөгөөд эцэст нь энэ

зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсгийн зорилгоор уг эд хөрөнгийн хувьд хураах шийдвэр гарна гэж хүсэлт хүлээн авагч оролцогч улс итгэх боломжит үндэслэлийг заасан хүсэлтийн дагуу өөрийн эрх бүхий байгууллагад эд хөрөнгийг битүүмжлэх буюу түр хураахыг зөвшөөрөхөд шаардлагатай байж болох арга хэмжээг авна;

(с) тухайн эд хөрөнгийг олж авсантай холбогдуулан битүүмжлэх буюу эрүүгийн ял сонсгохталаар гадаадад шийдвэр гарсанзэрэг үндэслэлээрэд хөрөнгийг хураах зорилгоор хадгалахыг өөрийн эрх бүхий байгууллагад зөвшөөрөх нэмэлт арга хэмжээ авах асуудлыг авч үзнэ.

55 дугаар зүйл

Эд хөрөнгө хураах зорилго бүхий олон улсын хамтын ажиллагаа

1. Хуулийн харьяалал бүхий оролцогч өөр улсаас нутаг дэвсгэрт нь байгаа энэхүү конвенцийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсангэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийг хураах хүсэлтийгэнэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгтэй холбогдууланхүлээн авсан оролцогч улс дотоодын эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд аль болох өргөн хэмжээнд:

(а) эд хөрөнгө хураах тухай шийдвэр гаргуулах зорилгоор уг хүсэлтийг өөрийн эрх бүхий байгууллагад өгөх бөгөөд хэрэв ийм шийдвэр гарсан бол түүнийг биелүүлнэ; эсхүл

(b) хүсэлт гаргагч оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа шүүхээс энэхүү конвенцийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу гаргасан эд хөрөнгө хураах тухай шийдвэрийг хүсэлт хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгсэлтэй холбоотой хэмжээнд, хүсэлтэд дурдсан хүрээнд хэрэгжүүлэх үүднээс тухайн шийдвэрийгөөөрийн эрх бүхий байгууллагад өгнө.

2. Энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгтэй холбогдууланхуулийнхарьяалал бүхий өөр оролцогч улс хүсэлт гаргасны дараа хүсэлт хүлээн авагч оролцогч улс энэхүү конвенцийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгө, тоног төхөөрөмж буюу бусад хэрэгслийг илрүүлэх, мөрдөх, битүүмжлэх буюу түр хураах арга хэмжээг хүсэлт гаргагч оролцогч улс эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авагч оролцогч улсаас гаргахшийдвэрийн дагуу эцэст нь хураах зорилгооравна.

3. Энэхүү конвенцийн 46 дугаар зүйлийн заалтыг энэ зүйлд хэрэглэх бөгөөд чингэхдээ шаардлагатай ялгааг харгалзан үзнэ. Энэ зүйлийн дагуу гаргасан

хүсэлтэд 46 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт дурдсан мэдээллээс гадна дараахь зүйлийг тусгана:

(а) энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсэгт хамаарах хүсэлтийн хувьд, хураагдах эд хөрөнгийн тодорхойлолт, түүний дотор байршлын тухай мэдээлэл болон холбогдох тохиолдолд эд хөрөнгийн тооцоолсон үнэ өртөг ба хүсэлт хүлээн авагч оролцогч улсаар дотоодын хууль тогтоомжийнх нь дагуу шийдвэр гаргуулахад хангалттай гэж хүсэлт гаргагч оролцогч улсын үндэслэсэн баримтын тухай мэдэгдэл аль болох багтсан байна;

(b) энэ зүйлийн 1 дэх хэсгийн (b) дэд хэсэгт хамаарах хүсэлтийн хувьд, тухайн хүсэлтийн үндэслэл болсон бөгөөд хүсэлт гаргагч оролцогч улсаас гаргасан эд хөрөнгө хураах тухай шийдвэрийн хуулийн шаардлага хангахуйц хуулбар, шийдвэрийг гүйцэтгэхийг хүсэлт болгосон хэмжээнд тохирох баримтын тухай мэдэгдэл ба мэдээлэл, хүсэлт гаргагч оролцогч улсаас шударга гуравдагч талд хангалттай мэдэгдэл өгөх болон эрх зүйн зохиох ёсны журмыг хангах талаар авсан арга хэмжээг тусгасан мэдэгдэл, түүнчлэн хураах шийдвэр нь эцсийн болох тухай мэдэгдэл;

(c) энэ зүйлийн 2 дахь хэсэгт хамаарах хүсэлтийн хувьд, хүсэлт гаргагч оролцогч улсын үндэслэл болгосон баримтын тухай мэдэгдэл, хүсэлт болгосон арга хэмжээний тодорхойлолт, түүнчлэн хэрэв байгаа бол хүсэлтийн үндэслэл болсон шийдвэрийн хуулийн шаардлага хангахуйц хуулбар.

4. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан шийдвэр буюу арга хэмжээг өөрийн хууль тогтоомж, хянан шийдвэрлэх ажиллагааны журам эсхүл хүсэлт гаргагч оролцогч улстай холбоотой заавал биелүүлэх хоёр буюу олон талт аливаа хэлэлцээр буюу тохиролцооны заалтад нийцүүлэн, тэдгээрийн дагуу гаргах буюу авна.

5. Оролцогч улс бүр энэ зүйлийг хэрэгжүүлэх өөрийн хууль тогтоомж, журам, тэдгээрт оруулсан цаашдын өөрчлөлтийн хуулбарыг, эсхүл тэдгээрийн талаарх танилцуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

6. Хэрэв оролцогч улс энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан арга хэмжээг холбогдох гэрээ байгаа тохиолдолд авч хэрэгжүүлэх нөхцөл тавихаар шийдвэрлэвэл тухайн оролцогч улс энэхүү конвенцийг гэрээний шаардлагатай бөгөөд хангалттай үндэс гэж үзнэ.

7. Хэрэв хүсэлт хүлээн авагч оролцогч улс хангалттай нотлох баримтыг цаг тухайд нь хүлээж аваагүй эсхүл эд хөрөнгийн үнэ өртөг нь ялимгүй бол энэ зүйлийн дагуу хамтран ажиллахаас мөн татгалзаж болох буюу түр арга хэмжээг цуцалж болно.

8. Энэ зүйлийн дагуу авсан аливаа түр арга хэмжээг цуцлахаас өмнө хүсэлт хүлээн авагч оролцогч улс ийм арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатайг харуулсан үндэслэлийг гаргаж өгөх боломжийг хүсэлт гаргагч оролцогч улсад боломжтой тохиолдол бүртолгож байна.

9. Энэ зүйлийн заалтыг шударга гуравдагч талын эрхийг хөндөхөөр тайлбарлаж болохгүй.

56 дугаар зүйл

Тусгай хамтын ажиллагаа

Оролцогч улс бүрдотоодын хууль тогтоомжоо зөрчихгүйгээрэнэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогын талаарх мэдээллийг өөр оролцогч улсад өгөх нь мэдээллийг хүлээн авагч оролцогч улсад мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагааг эхлүүлэх буюу явуулахад нь тус дөхөм болж болох буюу Конвенцийн энэ бүлгийн дагуу хүсэлт гаргахад нь хүргэж болно гэж үзэж байгаа тохиолдолд ийм мэдээллийг өөрийн мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагаанд хохирол учруулахгүйгээр өөр оролцогч улсад түүнээс урьдчилж хүсэлт авалгүйгээр илгээхийг зөвшөөрөх арга хэмжээ авахыг чармайна.

57 дугаар зүйл

Хөрөнгө буцаан өгөх ба захиран зарцуулах

1. Энэхүү конвенцийн 31 эсхүл 55 дугаар зүйлийн дагуу аль нэг оролцогч улсын хураасан эд хөрөнгийг тухайн оролцогч улс энэхүү конвенц болон дотоодын хууль тогтоомжийнхоо заалтын дагуу захиран зарцуулах бөгөөд үүнд тухайн эд хөрөнгийг өмнөх хууль ёсны өмчлөгчид ньэнэ зүйлийн 3 дахь хэсгийн дагуу буцаан өгөх явдал орно.

2. Оролцогч улс бүр өөр оролцогч улсын гаргасан хүсэлтийн дагуу энэхүү конвенцид нийцүүлэн арга хэмжээ авах үедээхураагдсан эд хөрөнгийг шударга гуравдагч талын эрхийг харгалзан буцаан өгөх боломжийг өөрийн эрх бүхий байгууллагад олгоход шаардагдаж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна.

3. Хүсэлт хүлээн авагч оролцогч улс энэхүү конвенцийн 46, 55 дугаар зүйл болон энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцүүлэн:

(а) энэхүү конвенцийн 17, 23 дугаар зүйлд дурдсаны дагуу нийтийн мөнгөн хөрөнгийг завших буюу нийтээс завшсан мөнгөн хөрөнгийг угаах тохиолдолд, эд хөрөнгийг 55 дугаар зүйлийн дагуу болон хүсэлт гаргагч оролцогч улсын шүүхийн эцсийн шийдвэрийг үндэслэн хураасан бол (хүсэлт хүлээн авагч оролцогч улс уг шаардлагаас татгалзаж болно) хураасан эд хөрөнгийг хүсэлт гаргагч оролцогч улсад буцаан өгнө;

(b) энэхүү конвенцид хамаарах аливаа өөр гэмт хэргээс олсон орлогын хувьд, эд хөрөнгийг 55 дугаар зүйлийн дагуу болон хүсэлт гаргагч оролцогч улсын шүүхийн эцсийн шийдвэрийг үндэслэн хураасан бол (хүсэлт хүлээн авагч оролцогч улс уг шаардлагаас татгалзаж болно), хүсэлт гаргагч оролцогч улс хүсэлт ийнхүү хураагдсан эд хөрөнгийг урьд нь өмчилж байснаа хүлээн авагч оролцогч улсад үндэслэлтэйгээр нотолсон эсхүл хүсэлт хүлээн авагч оролцогч улс хүсэлт гаргагч оролцогч улсад учирсан хохирлыг хураасан эд хөрөнгийг эргүүлэн өгөх үндэслэл гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хураасан эд хөрөнгийг хүсэлт гаргагч оролцогч улсад буцаан өгнө;

(c) бусад бүх тохиолдолд, хураасан эд хөрөнгийг хүсэлт гаргагч оролцогч улсад буцаан өгөх, уг эд хөрөнгийг өмнөх хууль ёсны өмчлөгчид буцаан өгөх буюу гэмт хэргийн хохирогчид хохирлыг нөхөн төлөх асуудлыг эн тэргүүнд авч үзнэ.

4. Оролцогч улсууд өөрөөр шийдвэрлээгүй бол хүсэлт хүлээн авагч оролцогч улс хураасан эд хөрөнгийг энэ зүйлийн дагуу буцаан өгөх буюу захиран зарцуулах зорилгоор мөрдөн шалгах, яллах буюу шүүх ажиллагаанд гарсан үндэслэлтэй зардлыг зохих тохиолдолд хасч тооцож болно.

5. Оролцогч улсууд хураасан эд хөрөнгийг эцэслэн захиран зарцуулахдаа тухай бүр хэлэлцээр байгуулах буюу харилцан хүлээн авахуйц тохиролцоо хийх асуудлыг зохих тохиолдолд мөн тусгайлан авч үзэж болно.

58 дугаар зүйл

Санхүүгийн мэдээллийн нэгж

Оролцогч улсууд энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тийнхүү шилжүүлэхтэй тэмцэх, түүнчлэн тэдгээр орлогыг буцаан олгох арга зам, хэрэгслийг дэмжих зорилгоор бие биетэйгээ хамтран ажиллах бөгөөд үүний тулд санхүүгийн сэжигтэй гүйлгээний талаарх мэдээлэл хүлээн авах, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагуудад түгээх асуудал хариуцсан санхүүгийн мэдээллийн нэгж байгуулах асуудлыг авч үзнэ.

59 дүгээр зүйл

Хоёр ба олон талт хэлэлцээр ба тохиролцоо

Оролцогч улсууд энэхүү конвенцийн энэ бүлгийн дагуу хэрэгжүүлэх олон улсын хамтын ажиллагааны үр дүнг сайжруулахаар хоёр буюу олон талт хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах асуудлыг авч үзнэ.